Төгс Гэгээрсэн Их Багш

Чин Хай

Сэтгүүл No. 174

- **Дэлхийд тодрон гялалзах хүчирхэг удирдагчид**
  - Бутан: Ард түмнийхээ аз жаргалын төлөө
  - Сингапур: Сингапурчуудын "Ногоон" хувь нэмэр
  - Нидерланд: Ядууралтай тэмцэж буй орнуудаас Европчууд дээгүүр байр эзэлж байна.

- **Сайн хүмүүс ба сайхан үйл явдал**
  - Нью Йорк хотын дарга дэлхийд тустай үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулллаа
  - Нэрт эрдэмтэн хүн төрөлхтнийг зөв зохистой хоол хүнс сонгохыг уриалж байна
  - Амьтан дээр хийдэг туршилт

- **Алтан эрин үеийн технологи**
  Хязгааргүй эрчим хүчний хөгжил







Төгс Гэгээрсэн Их Багшийн DVD

Энэ жилийн эхээр Багш маань өөрийн уншиж, дуулсан дуу, яруу найргийн зургаан цомгоороо бидэнд хайрын бэлэг барьсан билээ. Энэ удаа Багш маань өөр нэгэн дээдийн бэлгээр дэлхий дахинд өргөл барьж байгаа нь “Шөнийн Зүүд”, “Цаг хугацааны Вант улсаас цааш” хэмээх хоёр цомог юм. Багшийн дуу хоолойг бидэнд хүртээж байгаа эдгээр үнэлж баршгүй цомог бүтээл нь Их Багшийн маань нөр их ажлын заваар бичигдсэн юм. Багш маань залуу насныхаа чин сэтгэлийн мэдрэмжээр бүтээсэн шүлгүүдээ уншиж дуулсан бөгөөд мөнхийн хайрын эдгээр дуулал нь сэтгэл зүрхэнд өөрийн эрхгүй гүнээ шингэж, хөөр догдлолд умбуулдаг билээ. Гэгээрлийн эрин үед амьдарч байгаа бид ямар гээч их хувь заяатай хүмүүс вэ? Тансаг мэдрэмж, ухаарлын гүнзгий аяс бүхий шүлгүүдээрээ Багш маань биднийг сансар огторгуйн хязгааргүй орон зайд газарчлан буй нь энэ юм. Их Багшийн шүлгүүдийг шимтэн сонсдог болсноор бодол санаа, мэдрэмж маань улам цэвэршин ариусч, зүрх сэтгэл маань уян зөөлөн болдог. Багшийн шүлгүүдийг уншихаар цэцэг нахиалахыг харж, нарнаас алтран буух түг түмэн цацрагийг мэдрэн, хөх тэнгэрт хөвөх үүлэнд зөөлхөн хүрч байх шиг болдог. Багшийн шүлгээр хүлэг хийхдээ бид уран бүтээлийн гайхамшгуудад нэвтэрч, сүнснийхээ гүнд орших амар амгалан, энэрэл нигүүлслийг дахин нээдэг. Их Багшийн адисыг хүртээж буй дуу, шүлгийн эдгээр цомог нь Багшийн чин энэрэл хайрыг бидний зүрх сэтгэлд цогцлоож, Эх болсон зургаан зүйл, хамаг амьтанд туслуулахаар бидний дотоодын хайрын урсгалыг нээж өгдөг.

764 Шөнийн зүүд
(Аулак дуунууд /21 хадмалтай/)

765 Цаг хугацааны Вант улсаас цааш
(Аулак дуунууд /21 хадмалтай/)

Энэхүү хоёр DVD-г үзэхийг хүсвэл:
http://www.Godsdirectcontact.us/com/Songs
(хадмал орчуулгуудын хамтаар)

To order Master’s publications, please visit
http://www.theCelestialShop.com to purchase online or contact:
The Supreme Master Ching Hai International Association Publishing Co., Ltd., Taipei, Formosa
Tel: (886) 2-87873935 / Fax: (886) 2-87870873
E-mail: smchbooks@Godsdirectcontact.org
ROC Postal Remittance Account No.: 19259438 (for Formosa orders only)
Postal Account: The Supreme Master Ching Hai Publishing Co., Ltd.
Please visit our bookshop’s website to download our catalogue and summaries of the contents of Master’s latest publications:
http://www.smchbooks.com/ (in English and Chinese)

Хэвлэгдсэн он: 5-р Алтан жилийн (2008) 4 сар
Мэдээний эх үүсвэр: 1986 оны 8 сараас
Хэвлэсэн газар: Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн
Олон Улсын Нийгэмлэгийн Монгол дахь салбар

Товч илгээлт:
Эзэн Бурхан болоод Дээд Сүнсний тухай ярихдаа Багш Эзэн Бурхан эр эсвэл эм хүйстэй алин болох маргаанаас зайлсхийж, хүйсний ялгаа заадаггүй оргиналь нэр томъёо хэрэглэж байхыг бидэнд санал болгодог юм.
She+He= Hes (Bless гэдэгтэй адил дуудна.)
Her+Him=Hirm (Firm гэдэгтэй адил дуудна.)
Hers+His=Hiers (Dear гэдэгтэй адил дуудна.)
Жишээлбэл: Эзэн Бурхан хийх болохоороо Тэрээр (Hes) юмыг Өөрийнх нь (Hirmself), Түүний (Hiers) хүсэл зоригт нийцэж тохирч байхуйцаар хийдэг юм.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн мэдээ сэтгүүл нь дараах хэл дээр хэвлэгдсэн: Ау-Лак, Хятад (эртний болон хялбаршуулсан хэлбэрээр), Англи, Франц, Герман, Индонез, Япон, Солонгос, Монгол, Португал, Спани болон Тайланд. Гуань Инь вэб хаягаас энэхүү сэтгүүлийг уншиж болно.

2 Сүнсний дэвшил
Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн сүүлийн үеийн DVD

4 Багшийн айлдар
Жинхэнэ хариултыг дотоодоосоо хай

6 Үйл явдлын зах зухаас
Шинэ Зеланд / Австрали/ Болгар / Испани / АНУ / Формоса

18 Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн ТВ программ
Үнэн гоо зүй, ач буяны хэлбэлзэлд умбах нь нэвтрүүлэг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекц Үндэсний: Бие даасан телевизийн сувагаар: “Дэлхийг шинэ зуунд хөтлөх нь”

22 Багшийн гайхамшиг
Арьяабалын номын цогцос бүх төрөлхтнүүдэд гэрэл гэгээг авчирдаг

23 Та мэдэхгүй байж магад
Дайны золиос бологсдын талаарх гашуун үнэн

24 Дэлхийд тодрон гялалзах хүчирхэг удирдагчид цувралаас
Бутан/ Сингапур/ Нидерланд

29 Оюун санааны завсарлага
Таныг мэддэг болсноос хойш

30 Сайн хүмүүс ба сайхан үйл явдал
Тэдний эд баялаг/ Нью Йорк хотын дарга дэлхийд тустай үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ орууллаа/ Тахиануудад боломж олгож буй буяны үйлс/ Нэрт эрдэмтэн хүн төрөлхтнийг зөв зохистой хоол хүнс сонгохыг уриалж байна/ Мартсаныг сануулагч диваажингийн цэцэрлэг / Амьтан дээр хийдэг туршилт/ “Бусдад туслахгүй юм бол бид хэн юм бэ?”

41 Алтан эриний технологи
Хязгааргүй эрчим хүчиний хөгжил

42 Багш ярьж байна
Өөрсдийнхөө төлөө болон хойч үедээ зориулан Мөнхийн диваажинг бий болгох нь

45 Цагаан хоолны эрин үе
Хоол хүнсээ өөрчлөн энэрэл нигүүслийн замд орохуй - Цагаан хоолизмыг санаачлагч Жон Роббинс/Ариун зөв заншилтай орон зэрэг өөрчлөлт сэрээж байна

48 Энэрэл хайраар бялхсан цагаан хоолтой тосгоны байгуулж байна
Ирланд / Казахстан / Болгар / Порте Рика болон Бахамас / АНУ / Сингапур / Индонез / Формоса

65/70 Багшийн хошигнол
Хэн нь хэндээ туслав аа?/ Хоёрын ухаан нэгийнхээс дээр

66 Бодит явдал
Хайрын илгээлтийг алгаа тосон угтаж авсан хүүхдүүд/
Загас хайрын далайд сэлж явна

66 Гуань Инь вэб сайтууд

68 Багшийн ярьсан түүх
Биеэрээ туулж байж гэгээрэлд хүрэх нь - Эзэн Бурханы сургаалийг сонссон чөтгөр ч гэгээрч болдог

71 Бидэнтэй хэрхэн холбогдох вэ

72 Сонгомол асуулт хариулт
Дотоодын Үнэнд гадаад хил хязгаар гэж үгүй/ Эзэн Бурхан бол бүхнийг эдгээгч/
Гэрэл Аялгуу бол Эзэн Бурхан юм/ Диваажинг харсаны баталгаа/
Залбирал ба бясалгал/ Амар амгалан болон аз жаргалыг ахуй ойлголтоороо олж авах нь зүйтэй

78 Номын танилцуулга
Хайр бол өндөр соёл иргэншлийн үндэс

80/85 Онч мэргэн үгс
Гараг хоорондын харилцаа холбоонд бэлдэцгээ/ Газар дээрх диваажинг цогцлуул

81 Нэлттэй орон зай
Эртний соёл иргэншлүүдийн нэлттэй орон зай

86 Энэрэл хайрын илэрхийлэл
Кени/ Ау Лак/ Солонгос/ Формоса

100 Талархлын захидлууд
Кени улсын Корромпой хотоос цэвэр усны төсөл хэрэгжсэн явдалд талархал илэрхийлсэн захидал/
Жинжү хотын хошуучын талархлын захидал/ Чинжон Гүний амбан захирагчийн талархлын захидал

108 Багш шавийн яриа
Бурханы ивээлд талархахуй

111 Арьяабалын бясалгалын олон улсын төвүүдийн хаяг

114 Мөнхийн шүлгүүд
An Unexpected Day

116 Их Багшийн сүүлийн үеийн уран зургууд
Ash the Chain

ГАРЧИГ

Жинхэнэ хариултыг Дотоодоосоо Хай

Цаглашгүй Их Багш Чин Хайн айлдвар,
Хьюстон, Техас, АНУ, 11-р сарын 13, 1993
(Англи хэлээр) Видео хуурцаг № 393

Билэг ухаандаа дулдуйдан асуултынхаа хариуг ологтун

Та нар надаас юу асуух нь хамаагүй л дээ. Хамгийн гол асуудал бол та нар билиг ухаанаа мартчихсанд л байгаа юм. Уг нь надаас асуугаад шаардлага байхгүй ээ. Намайг бүгдийг мэдэх ёстой, ядаж л бусдаас арай илүү мэднэ гэж бодоцгоодог. Миний тархи та нарынхтай адилхан. Би та нартай ижил хоолтой, үгүйдээ гэхэд адилавтар, тийм үү. Үнэндээ та нарынхаас хэмжээ нь арай бага байх. Их бага иддэгээс шалтгаалдаг бол би та нараас билиг ухаанаар дутуу, энерги ч багатай болж таарнаа даа! Та нарын дотоодод бүх хариулт чинь байсаар байхад юунд надаас бүхнийг асууж байдаг юм бэ?

Тэгэхээр өөрсдөө хариугаа олоход чинь тус болох шилдэг арга надад байна аа. Тэр бол цорын ганц арга; хамгийн шилдэг бөгөөд мөнх үйлчлэх арга юм. Бидний амьдралын зам бол хүмүүс Эзэн Бурханы Вант улсыг таньж мэддэг болоход нь туслах буюу тэдэнд энэ орчлон хорвоогийн оршихуйн болон хамаг амьтдын амьдралын үндэс болсон Аугаа Сүнсээ таньж мэдэхэд нь туслах явдал юм. Түүнгүйгээр та ямар ч хэрэггүй, амьгүй үхдэл болно. Нэгэнт аньсан нүд юу харж, амьсгалахгүй хамар юу үнэртэж, хөдөлгөөнгүй ам хэрхэн эргэж нээгдэх билээ. Харин бид энэ бүхнийг мартчихдаг. Тэгээд л

мах идэж, архи уун эд эрхтэнээ бузарладаг ба бидний Сүнс буюу Бурханы хамгийн чухал үүрэг юу болох талаар хэзээ ч асуудаггүй.

Билэг оюуны банк

Энэ бол хамгийн шилдэг, сансар огторгуй дахь аугаа дээд хүч юм. Үүнийг мартчихвал есөн шидийн асуулт ундарч хариултыг нь хэзээ ч олохгүй байх. Үүнийг мартчих юм бол хэзээ ч сэтгэл хангалуун амьдарч чадахгүй. Та хичнээн их мөнгөтэй байгаад ч, гэргий, нөхөр тань хичнээн царайлаг сайхан байгаад ч таныг бүрэн дүүрэн аз жаргалтай болгож чадахгүй. Таныг хэзээ ч тогтуун баяр жаргалтай болгохгүй. Яахав та өнөө маргаашдаа сайхан байж болох юм, виски уунгуут хэдэн минут сэтгэл хөөрдөг шиг. Харин маргааш нь шартаж, толгой чинь өвдөх бус уу.

Энэ ертөнцийн баяр жаргал бүхэн өөрийн гэсэн сөрөг муу нөлөөтэй байдаг, яагаав өвчинд уудаг эм шиг. Энэ л гол асуудал. Энэ дэлхий ертөнц дээр байгаа чигээрээ амьдарч бас болох юм. Харин амьдрал гэдэг маань ердөө л нэг хуурамч үзэгдэл юм. Өнөөдөр та аз жаргалтай байлаа ч маргааш гай зовлон тохиож л байдаг. Бид муу зүйл хийснээс болоод ч юм уу, хэргээр ийм байгаа юм биш л дээ. Юу гэхээр энэ ертөнцийн баяр жаргал бүхэн муу сөрөг нөлөөллийг дагуулж байдаг. Энэ л муу.

Тэгэхээр яавал дээр вэ? Бидний дотор бүхий л хариултыг агуулах буюу асуудлыг шийдвэрлэх дээд хүчин бий. Тэр бол Аугаа Сүнс маань юм. Биднийг амьд байлгаж, хөдөлгөж, яриулж, бие биенийг маань таньж мэдүүлж, хайрлалцуулж байдаг. Хэрвээ хүн Сүнсэндээ найдах аваас хэзээ ч буруутахгүй байж болно. Сүнс маань бидний дотор оршиж, байнга хамт явж байдаг ч түүнийгээ даанч тоодоггүй, зөвлөгөө ч авъя гэдэггүй. Бид Эзэн Бурханы Сүнс, Хамгийн аугаа Сүнс, Хамгийн Эрхэм Дээд болох Сүнснээсээ хэзээ ч тусламж гуйдаггүй.

Сүнс бол оюун ухааны маань хамгийн дээд хүч юм. Тэрнээс биш гоц ухаантан гэхээр л урт сахалтай өвөө байдаг юм биш. Харин Сүнс маань үргэлж бидний дэргэд байдаг. Аугаа Хүчин үргэлж л бидэнтэй хамт байдаг. Бид ямарваа нэг тусламж хүсэх бүрд Тэр үнэхээр бэлэн байж байдаг. Харин Түүнээс хэрхэн яаж тусламж хүсэх ёстойг мэдэх хэрэгтэй л дээ. Ихэнх тохиолдолд тусламж хүсч байгаа энэ гээд зогсоо чөлөөгүй ярьж гардаг. Мөргөлийн ая гингэнээд л, бөөн чимээ шуугиан дэлдээд л, тэгсээр байгаад Сүнс бидэнд юу гэж зөвлөхийг нь сонсдоггүй. Тиймээс л хариултаа олж авч чаддаггүй юм шүү дээ.

Дотоод шүүгээндээ орж залбир

Та нар надаас асуулт асууж байгаа нь гээд зогсоо чөлөөгүй ярьчихдаг. Тэгэхээр би яаж хариулах юм бэ? Үүний адилаар бид бүгдээрээ буруу, ямар ч үр ашиггүй залбирал үйлддэг. Залбирч болно л доо, гэхдээ чимээгүй залбирах хэрэгтэй. Библид: "Залбирал үйлдэхдээ дотоодынхоо шүүгээнд орж хаалгаа хаагаад нуугдмал байж Аавдаа залбирвал нууцаар уулздаг. Аав тань таныг нээлттэй шагнах болно" (Matthew 6:6,) "Залбирал үйлдэхдээ еврейчүүдийн сүмд орж зогсоод л, гудамжны буланд олны нүдэнд харагдаж залбирах дуртай 2 нүүртэн шиг байж болохгүй" (Matthew 6:5) гэсэн байдаг. Энэ юу гэсэн үг байж болох вэ? Энэ бол Эзэн Бурхантай харилцахдаа ганцаараа бай гэсэн үг. Та зуу зуун мянган хүнтэй хамт сууж байсан ч Эзэн Бурхантай, Сүнстэйгээ ганцаараа л байх хэрэгтэй. Энэ л таны асуудлаа шийдэж, асуултынхаа хариуг олох ганц арга мөн. Тиймээс би хэзээ ч асуулт асуудаггүй, яагаад гэвэл би өөрөө л хариултаа олдог. Би өөрийнхөө бүхий л үйлдэл, бодол болон ярианд хариуцлага хүлээх ёстой. Хүмүүстэй яаж харилцахад хүртэл хариуцлага хүлээнэ. Би өөрөө л хариуцлагатай байх ёстой. Хүн бүр хариуцлага хүлээх ёстой. Энэ уг нь амар амьдрал юмсанж, даанч бид хэцүү нь л сонгодог. Хүн бүр л надаас: "Хөөх, та яаж цагаан хоолтон байж чадаж байна аа, Та бясалгадаг гэх юм, хэцүү л байдаг байх даа, аан" гэж асуудаг. Би: "Үгүй дээ. Таны амьдрал л харин хэцүүхэн байгаа байх даа. Минийх бол ердөө ч тиймгүй. Миний амьдрал ихээ амар. Надад бүх зүйл амархан, тодорхой байдаг" гэж хариулдаг.

Шинэ Зеланд

Хүнсний бүтээгдэхүүний үзэсгэлэнгийн үеэр

Цагаан хоолыг амжилттай сурталчиллаа

Авкландын мэдээллийн баг (Хятад хэлээр)

[Авкланд] Авкландын төвийн авшигтнууд Хаант засаглалт Тонга улсаас буцаж ирүүтээ 2006 оны 8-р сарын 3-наас 6-ны хооронд Авкланд хотод болох "Хүнсний бүтээгдэхүүн 2006" үзэсгэлэнд оролцон Их Багшийн "Өөрөөр амьдарцгаая" энэрэл нигүүслийн сайхан мэдээг олон нийтэд тараахаар нэн даруй бэлтгэл ажилдаа орцгоосон юм. Үзэсгэлэнгийн зочдод цагаан хоол сурталчилан таниулахын сацуу олон улсын 30 гаруй нэр төрлийн хоол хийж барьсан билээ. Үзмэрийн хаягаа бид "Их Багшийн мөрөөдөл хийгээд Өөрөөр амьдарцгаая уриаг дэлхий дахинд түгээх ажил" гэж нэрлэсэн байлаа. Бид зочиддоо өөрсдийнхөө хийсэн амт чанар сайтай олон төрлийн цагаан хоолыг өргөн барьснаараа эрүүл, аз жаргалаар дүүрэн цагаан хоолтон байх боломжийг өөрсдийн үйл хэргээр харуулсан юм. Их Багшийн "Жинхэнэ баатрууд" DVD киног үзүүлж, Өөрөөр амьдарцгаая зурагт хуудсыг тарааж, цагаан хоол хэрхэн хийх жорыг танилцуулахын хажуугаар бид цагаан хоол хийж, үзүүлж амтлуулсан юм. Мөн цагаан хоолтон байхын ашиг тусын талаар тайлбарлаж, цагаан хоол хэрхэн хийх талаар үнэгүй сургалтанд хаана хамрагдах болон хаанаас цагаан хоолны орц, түүхий эдийг худалдаж авч болох тухай мэдээлж байв. Их Багшийг болоод манай төвийг сонирхсон хүмүүст Үлгэр дэвтэр, Арьяабалын номын цогцыг тайлбарласан товч танилцуулга тараалаа. Зарим зочид Дөхөм бясалгалд хамрагдахаар болов. Үзэсгэлэнгийн үеэр Их Багшийн хайр энэрэл хийгээд манай авшигтнуудын чадварлаг үйлдсэн хоолонд татагдсан мянга мянган зочид манай үзмэр уруу ирцгээж байлаа. Олон хүндэт зочин, тухайн үзэсгэлэнд оролцогчид, мөн нэгэн алдартай тогоочийн туслах цагаан хоол амтлахаар манай үзмэр дээр дахин дахин ирцгээж байв. Олонхи нь цагаан хоолыг маш амттай хийж болдог юм байна гэдгийг мэдэж гайхашран өөрсдийн санаа бодлыг хуваалцав. Үзэсгэлэнгийн эхний өдөр болсон нээлтийн ажиллагаанд сэтгүүлчид, зоогийн газрын эзэд, хүнсний мэргэжилтэн зэрэг нийт 2500 тусгай зочдыг оролцуулсан юм. Эхний өдрөө л манай үзмэр олон хүнээр хүрээлүүлж бидний хийсэн бүх хоол дууссан нь Шинэ Зеландын ТВ1 телевизийн анхааралд өртөж бичлэг хийсэн билээ. Мөн Шинэ Зеландын ТВ1

телевизийнхэн Өөрөөр амьдарцгаая зурагт хуудсыг үнээ аятай хувцасласан авшигтан номын ах нийтэд тараах байгаа бичлэгийг хийхийн хамт хятадын ETTN телевиз биднээс ярилцлага авсан юм. Үзэсгэлэнд нийт 300 үзмэрийн хэсэг ажилласны дотор зарим нэр цуутай тогооч нар өөрсдийн хоолыг зогсолтгүй хийж үзүүлж байлаа. Үзэсгэлэн зохион байгуулагчид цагаан хоол бусдын анхаарлыг ихэд татна хэмээн төсөөлөөгүй байсан юм билээ. Бараг бүх зочид бидний хоолыг магтан сайшааж, олонхи нь уг үзэсгэлэнгийн шилдгээр манайхыг нэрлэн ярьцгааж байв. Манай авшигтнуудын урам зоригтой, чин сэтгэлийн үйлчилгээ зочид, үзэсгэлэнгийн зохион байгуулагчид, оролцогчдын талархлыг хүлээж магтаал сайшаалаар дүүрэн байлаа. Бид 3 өдөр хагасын үйл ажиллагаанд нийт 11000 зурагт хуудсыг хичээнгүйлэн тарааж амжив. Манай үзмэрт Их Багшийн дуулсан дуу, зохиосон хөгжмийн DVD киног байнга тоглуулсан нь хүмүүсийн анхаарлыг ихэд татсан. Нэг эмэгтэй биднээс дуулж байгаа энэ эмэгтэй хэн бэ гэж асуунгаа тэр их үзэсгэлэнтэй юмаа гээд дотогш орж уг бичлэгийг үзэхийг гуйсан юм. Авшигтан бидний завгүй ажлын үеэр тэр эмэгтэй Их Багшийн дуулахийг эхнээс нь дуустал нүдэндээ нулимстай үзсэн билээ. Тэрээр бичлэгийн бүх хугацаанд Их Багш зөвхөн түүнд л зориулан дуулахыг мэдэрсэнээ хэлсэн юм.

Нэгэн авшигтан зочдод цагаан хоол тайлбарлан ярьж байхдаа Их Багшийн адислах хүчийг мэдрэн түүнд урам зориг орж өөртөө маш итгэлтэй болсон, тэрхүү мэдрэмж үзэсгэлэнгийн дараа ч үргэлжилсээр байсан гэж ярьсан юм. Тэрээр хэлэхдээ: "одоо би зөв юмны төлөө хэлж ярьж, хийхдээ айдас түгшүүрээ ялж чаддаг боллоо. Нэг төрлийн цагаан хоол болох сүши (далайн байцаанд ороосон ороомог) хийж байхад яг л мэргэжлийн хүн шиг гайхалтай хурдан шалмаг болж, суши ч урьд өмнөхөөсөө ч илүү амтлаг, бас гоё сайхан хэлбэр дүрстэй болж байсан" гэв. Үзэсгэлэнгийн эхний өдрөөс л бусад павильонуудыг цөөн хүн сонирхож байхад сүши хоолыг хэрхэн хийж буйг харахаар манай авшигтныг бүчин цугларч байсан. Ер нь бидний хоолыг амталж үзэхээр хүмүүс олноороо хүрээлэн байв. Өөр нэг авшигтан маань гайхалтай оюунлиг ахуй ойлголтыг энэхүү үзэсгэлэнгийн үеэр мэдэрсэнээ бидэнтэй хуваалцсан билээ. Үзэсгэлэн болохоос хэдэн долоо хоногийн өмнө Их Багшийн "Гэгээрэл" хэмээх уран зурагтай болсон ба тэрхүү зургандаа их хайртай гэнэ. Зургийг харах бүрд зураг бид хоёр агуу их гэрлэн дунд эргэлдсэн нэг л зүйл болохыг мэдэрдэг ажээ. Тэрээр үзэсгэлэнгийн хоёр дахь өдөр тус арга хэмжээнд зориулж хачиртай талх, шимүүс /коктейл/ бэлтгэж байхдаа гэнэт нөгөө "Гэгээрэл"зурагныхаа хурц тод өнгө хачиртай талхны тавиураас гялалзахыг харжээ. Учир нь хачиртай талхны тавиур нь тухайн зурагны өнгөтэй их адилхан байсан аж. "Би буцаж алхаад тавиурыг харахад хачиртай талх бид хоёр уг зурганд уусан буй мэт. Анх Гэгээрэл зургийг харж байхад төрсөнтэй ижил сэтгэгдэл надад төрлөө. Гэрэл, өнгө, гоо үзэсгэлэн нэгэн агшинд хамтдаа үзэгдэн байх нь үгээр илэрхийлэхийн аргагүй байв. Тэр үед Их Багшийн уран зургийн нэг болох "Гоо үзэсгэлэн"

хэмээх зураг хачиртай талхны тавиур дээр харагдахад "Хөөх! Ямар гайхамшигтай үзэсгэлэн гоо вэ хэмээх бодол надад орж ирлээ. Хоёр зураг ээлж дараалан үзэгдэхэд би нүдэндээ итгэж чадахгүй байлаа. Тэрхүү гоо үзэсгэлэн намайг хэмжээлшгүй аз жаргалд умбуулсан төдийгүй миний тэр агшинд үзсэн зүйл үнэхээрийн бодитой байсан юм. Тэр агшинд миний бүх бие энергээр цэнэглэгдэхийг мэдэрсэн төдийгүй түүгээрээ дамжуулж би маш их адис хүчийг олж авсанаа мэдэрсэн. Их Багш таныхаа хайр, адис хүчинд баярлалаа" Хүмүүс махгүй хачиртай талх, коктейлд ихэд дурлацгаасан юм. Өдөрт бид хэдэн мянган хачиртай талх хийж байсан ч 3, 4 дэх өдрүүдэд тэр тоог дахин нэг мянган хачиртай талх болгож нэмээд ч эрэлтийг хангаж хүчрэхгүй л байв. Авшигтнгууд дур булаам хачиртай талх хийснээрээ энэхүү арга хэмжээ бидний төсөөлж байснаас амжилттай болж өнгөрсөн төдийгүй Их Багшийн Өөрөөр амьдарцгаая зурагт хуудсыг тараах ажил эхэлсэн цагаас бүх авшигтан оюун санааны ихээхэн дэвшилд хүрсэн юм. Хүн бүр энэхүү ажилд тал талаасаа нэгдсэнээр оюун санаа, билэг оюунаа хөгжүүлэхийн сацуу олон нийтэд хүрч үйлчлэх олон боломж бидэнд олдсон билээ. Бясалгал хийхийн хажуугаар Их Багшийнхаа хайр, адислалыг хүмүүст чин сэтгэлээсээ түгээн дэлгэрүүлэх нь өөрсдийнхөө зовлон бэрхшээлээс ангижрах хамгийн шилдэг арга болохыг бид өөрсдийнхөө туршлагаас ухаарлаа. Мөн бэрхшээл бүр нь хязгааргүй билэг ухаанаа дотооддоо хөгжүүлэх агуу сувгууд билээ. Нэг амьдралаас дараагийн амьдралд нэмэгдэж байдаг бүх л саад бэрхшээлүүд биднийг дагасаар байдаг ч Их Багшийнхаа хязгааргүй хайр, түүний сургааль, байнгын адислал, энэрэл нигүүслэлд бид маш ихээр Их Багш тандаа талархаж явдаг. Бид бүгд нэг л өдөр энэ ертөнцийн бүх л амьд бодгаль болоод хүмүүст үйлчлэх Их Бурханы төгс зэвсэг болж чадна гэдэгтээ итгэлтэй байна.

Үзэсгэлэнд хийж үйлчилсэн олон улсын 30 нэр төрлийн хоолны цэсийг сонирхуулав.

Австрали

Хөдөө нутгийн бясалгалын шинэхэн төв

Бяцхан диваажинг ертөнцид авчирлаа

Мелбурний мэдээллийн баг, Австрали [Англи хэлээр]

[Мелбурн] Авшигтнууд бясалгалын шинэхэн төвийнхөө байранд даяан хийх болсон нь баяртай үйл явдал боллоо. Энэ хүртэл нийтийн бясалгал маань адууны харанхуй, заваан, чийгтэй зүчээ саравчинд болдог байсан бол одоо Их Багшийн адислал, авшигтнуудын хамтын оюун санааны хүчээр Эзэн Бурханы хүүхдүүд байрлах диваажингийн нэгээхэн хэсэг ийнхүү бий боллоо. Их Багшийн үргэлж сургаж хэлдгээр хөдөлмөр нь биднийг билэг оюунаа ашиглан IQ-гээ хөгжүүлэх, Дээд Бурханы агуу зохицуулалтыг харах боломж өгдөг. Цөөхөн ажиллах хүч, нөөц боломжоо ашиглан бид хэрэггүй болсон барилгын материал, зарим будаг, мөн бие биенээ хэмээх их хайр, мэдээж Их Багшийнхаа хэмжээлшгүй адис хүчний дор нэгдэн байж ертөнцийн нэг багахан хэсгийг гоёж чадлаа. Алхам бүрд Их Багш маань орчиндоо яв цав таарсан дотоод гэрэл чимэглэл болоод таарч тохирсон барилгын материалуудыг зохицуулан өгч байв. Өөрсдийн чадвар болон хүч, мөнгө, материалаар бие биедээ үйлчлэх агуу хичээл энэ болов.

Болгар

2 өдрийн дияаны үеэр
“Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг тараав

Пловдив хотын авшигтан номын эгч Экатерина Атаносове

[Пловдив] Болгар улсын Пловдив хотын авшигтнууд 2006 оны 7-р сарын 13-наас 2 өдрийн даян хийв. Эхний өдөр бясалгалыг 15 цаг хийснээс шөнө 8 цаг, өдөр 7 цаг хийсэн юм. Үлдсэн хугацаанд нь Их Багшийн дуутай бичлэг тавьж лекц үзэж, мөн Төгс Гэгээрсэн Их Багшдаа зориулсан дуу дуулж танилцуулав. Даяаны 2 дахь өдөр Пловдив хотод "Өөрөөр амьдарцгаая" зурагт хуудсыг тараасан ба хүмүүс эелдэгээр хүлээн авч анхааралтай уншиж байлаа. Тэрхүү 2 өдрийн цаг агаар налгар сайхан байв. Даянд оролцогчид Их Багшийн хайр адислалыг мэдэрч, зарим нь бүр Их Багшийг энэ хугацаанд бидэнтэй хамт байсныг мэдэрсэн юм. Даяаны дараа хэмжээлшгүй их тэнгэрлиг адислалтайгаар, Хайрт Их Багшийнхаа хүчинд талархан харьцгаасан билээ.

Испани

Оюун санааны төв

Малагагийн мэдээллийн баг

[Малага] Андалусиа хот нь Өмнөд Испаний 2 дахь том хот юм. Энэ хот нь жилийн турш өөрийн тааламжит сайхан уур амьсгал, байгалийн үзэсгэлэнгээрээ жуулчдын анхаарлыг татаж байдаг. Шинэхэн байгуулагдсан Малага бясалгалын төв

нь өргөн уудам үзэсгэлэнт газар болох 6000$м^2$ талбайд байрладаг. Авшигтнууд одоогийн төвийнхөө хажууд газар худалдан авч ойрын ирээдүйд төвөө өргөтгөх өөр нэг сайхан мөрөөдөлтэй байгаа. 2006 оны 8-р сарын 25, 26-ны өдөр Испаний номын ах эгч нар Малага бясалгалын төвдөө энэ жилийн 2 дахь даянаа хийлээ. Мадрид, Валенсиа болоод Малага хотын 20 гаруй авшигтан Малага бясалгалын төв дээр гайхамшигт даян хийж бясалгацгаав. Эхний оройн даяны дараа модон байшингийнхаа дэргэд барьсан том майхандаа бүгд цугларан одод түгсэн тэр нэгэн шөнө тэнгэрт дүүрэн гэрэлтэх оддыг ширтэн, тариалангийн талбайн хажууд гуаглах мэлхийнүүдийн дуугарахыг сонсон тааламжтай амарцгаав. Бид даяны үеэр гайхалтай ахуйн ойлголттой байсан ба Их Багшийн адислал, Диваажингийн вант улс уруу дэвшин орж сэргэсэн шиг сэтгэгдэл бидэнд төрсөн билээ. Өдрийн хамгийн сайхан чөлөөт цаг бол өглөөний цайны дараа жимсний цэцэрлэгт хүрээлэнд өтгөн ногоон өвсөн дунд зугаалах байлаа. Шувуудын жиргэх, азарган тахиа донгодохыг сонсон, дэлгэрч байгаа цэцэгсийн анхилуун сайхан үнэртэй цэвэр тунгалаг агаарт өглөөний наранд биеэ ээж байв. "Нэг өдрийн дотор Ром хотыг барихгүй" гэсэн үг байдгийн адилаар энэ ертөнцөд юу ч хийхэд хялбар биш ээ. Валинсиа, Мадрид хотуудаас ирсэн барилгын материал, хүн хүчний туслалцаа, Малага хотын дөхөм аргаар бясалгагч нар, авшигтнууд болоод тэдний гэр бүлийнхний шаргуу хөдөлмөр, хувь хандивын ачаар Малага хотын бясалгалын оюунлиг төв 3 сар гаранхан хугацаанд баригдаж ашиглалтанд орлоо. Их Багшийн хэмжээлшгүй хайр адислалын хүчээр хүн бүр хичээн зүтгэл, урам зоригтой ажилласан билээ.

Их Багшдаа баярлалаа! Оройн Дээд Бурхандаа баярлалаа!

АНУ

Сар бүр болдог Семинарууд

Памила Миллар, Жолли Чиов номын эгч нараас (Англи хэлээр)

[Сан Жоси] Сан Жосигийн авшигтнууд Их Багшийн сургаалийг бусадтай хуваалцах видео семинарыг 6-р сард Милпитас номын санд, 7-р сард

Саратога номын санд, 8-р сард доктор Мартин Лютер Кингийн номын санд баяр хөөртэй зохиов. Сан Жоси дахь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн цагаан хоолны байранд тараасан сурталчилгааны хуудас, манай нийгэмлэгийн радиогоор зарласан зарлал, мөн номын санч авшигтнуудын байнгын үйлчлүүлэгчдэд зарлаж түгээсэн урилгыг хүлээн авсан зочид эдгээр семинарт хүрэлцэн ирцгээв. Милпитас хот нь шинэхэн байгууллагдсан хот бөгөөд ихэнх оршин суугчид нь залуу, боловсролтой хүмүүс байдаг. Тэд бидний урилгыг баяртай хүлээн авсан юм. Үүний өмнө видео семинарт оролцож байсан өөр хотын хоёр иргэн манай семинарын төвыг лавлаж асуусан билээ. Тэд түрүүчийн семинараас хойш Их Багшийн семинарт байнга оролцож мөн авшиг авах өдрөө чин сэтгэлээсээ хүлээж байгаа юм байна.

Хотоос нэлээд зайтай суудаг нэгэн хараагүй хүн такси хөлөглөн 8-р сарын семинарт ирлээ. Тэрээр сүүлийн 6 сар гаруй хугацаанд Их Багшийн радиогийн хөтөлбөрийн шүтэн бишрэгч болсноо бидэнд хэлсэн юм. Тэр хэдийгээр видео бичлэг үзэж чадахгүй ч Их Багшийн Нью Йорк дэхь Нэгдсэн үндэсний байгууллагад тавьсан "Чанагуухи ертөнцийн нууц" хэмээх лекцийг сонссон байна. Хайр булаам тэр эмэгтэй дөхөм бясалгалын нэрсийн жагсаалтад чин сэтгэлээсээ бүртгүүлэв. Тэр мөн гэр бүлийнхэндээ уншуулахаар нэмэлт сурах материалыг биднээс авсан билээ. Түүнд Үлгэр дэвтэр, зарим сэтгүүл өгсөн юм.

Семинар бүр дээр олон хүн дөхөм бясалгал заалгаж, авшигтнуудаас сонирхсон асуултандаа хариу авч байлаа. Тэд чин сэтгэл гарган Арьяабалын номын цогцыг гүн гүнзгий ойлгож байгаа нь бидний сэтгэлийг ихэд хөдөлгөсөн билээ.

Формоса

Бие, Оюун Ухаан, Амин сэтгэлийн нигүүлсэнгүй номын үзэсгэлэн

Тайбэйн мэдээллийн баг (Хятад хэлээр)

[Тайбэй] Пингши хотын нийтийн номын сангийн номын санч хатагтай

Гуо Дунг-наний урилгыг хүлээн авч Тайбейн бясалгалын төвөөс эрхлэн цагаан хоолтнуудын амьдралын хэв маягийг сурталчилах болон бие, оюун ухаан, амин сэтгэлийн тухай номыг дэлгэн үзүүлэхээр найман хоногийн турш нийтийн үзэсгэлэн-арга хэмжээ зохион байгуулав.

2006 оны 8-р сарын 12-ны өдөр болсон нээлтийн ажиллагаанд олон арван хүндэт зочид хүрэлцэн ирсэн юм. Тэдгээрийн дотор Пингши хотын захирагч ноён Линяао Тин, мөн хотын зөвлөлийн гишүүд, номын санч Гуо болон Тайбей дүүргийн номын сангийн захирал нар байлцав.

Нээлтийн үеэр хэлсэн үгэндээ тэд Их Багш Чин Хайн оюунлаг урлагийн бүтээл болон тансаг хэвлэл нийтлэлийг шагшин магтаж байлаа. Түүнчилэн энэхүү цагаан хоолны амталгаа болон номын үзэсгэлэнг хамтарч зохион байгуулахад гаргасан авшигтан ах эгч нарын шинэлэг санаа, хичээл зүтгэлийг үнэлсэн юм. Төгс Гэгээрсэн Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн Тайбэйн төвөөс зохиосон “Эрүүл саруул, оюунлиг амьдралыг хэрхэн хэвшүүлэх вэ” сэдэв семинар-сургалтыг маш амжилттай арга хэмжээ боллоо хэмээн хотын захирагч Лин, хотын зөвлөлийн дарга хатагтай Ли- Жоу Шиуцин болон номын санч Гуо нар тэмдэглэж хэлэв. Энэхүү үйл явдал нь нутгийн иргэд болон жуулчдын сонирхлыг татахаас гадна ард иргэдийг илүү чанар чансаа, ухамсар төлөвшилтэй амьдрахаднөлөөнө гэж тэд үзэж байгаа ажээ. Үзэсгэлэн-семинарт оролцогсод хүмүүний аз жаргалын тулгуур нь эрүүл бие, саруул ухаан, ариун сэтгэл болох тухай бясалгагч бидний үзэл санааны үндсийг сайшаан дэмжив. Оролцогсод Чин Хай Багшийн олон улсын холбооноос жил бүрийн 9-р сард зохиодог “Гоо сайхны цай” орон нутгийн үзэсгэлэн худалдаанд уригдав. Эдгээр цуврал ажил нь эрүүл саруул амьдрах замыг сонгоход орон нутгийн иргэд болон жуулчдад туслах юм.

Уг семинар сургалтын нээлтийн ажиллагаанд хүнс судлаач доктор Чен Жиан-Зонг: “Эрүүл саруул, оюунлиг амьдралыг хэрхэн хэвшүүлэх вэ” сэдэвт лекц уншив. Тэрбээр хүний биеийн бүтэц болон хүний эрүүл мэндэд махан хоолны үзүүлж буй нөлөөллийн судалгааны дүнгээс танилцуулав. Түүнчилэн цагаан болон махан хоолны шингэцийн ялгааг ч тайлбарлав. Ноён Чен хооллолт нь хорт хавдар үүсгэх эрсдэлтэй нягт холбоотойг маш энгийн ойлгомжтойгоор тайлбарласан юм. Тэрбээр хүний хооллолт нь экологийн тэнцвэрийг алдагдуулах боломжтойг анхаарууллаа.

Удаах илтгэгч болох хатагтай Ши Руи-Чүн Тайбейн телевизийн хөтлөгчөөр ажиллаж байсан бөгөөд нуугдмал чадварыг хөгжүүлэх чиглэлээр мэргэшсэн туршлагатай судлаач юм. Тэрбээр Англи дахь амьтны эрхийг хамгаалах байгууллагаас эрхлэн гаргасан богино хэмжээний киног уг семинарт оролцогчдод үзүүлэв. Кинонд нэгэн гахай усанд живж буй хөвүүнийг хэрхэн аварсан тухай өгүүлж, амьтан араатан ч гэсэн хүмүүний адил сэтгэлийн мэдрэмж, оюун ухаан, эр зоригтой болохыг үзүүлжээ. Удам төрлөөсөө өөр өрөөл нэгэн хүний алтан амийг аврахаар энэхүү гахай амиа золиослон эр зориг гаргаж байхад магадгүй гахай усанд живж байвал хүмүүс бид түүний төлөө амиа золиослох болов уу гэсэн сэтгэхүйн бодлого бодоход хүргэв.

Хатагтай Ши амьтны судалгаа явуулдаг Европын нэгэн хүрээлэнгийн судлаачийн тахианы судалгааг иш татаж ярьснаар гургаалдайн өндгийг тахианыхтай хамт тавихад тахиа тэдгээрийг алагчилахгүйгээ" адилхан анхаарч байжээ. Тахиа нь өөрийн дэгдээхэйг хүний бэлтгэн өгсөн хоолоор тэжээдэг бол гургалдайн дэгдээхэйг ойд аваачин газраас өт ухан өгч идүүлдэг болжээ. Тэр тахиа гургалдай шувууны дэгдээхэйг бэлдмэл тэжээлд дургүй зөвхөн байгалийн хоолоор хооллодгийг мэдсэн ажээ. Судлаач галууны өндгийг мөн дээрхи маягаар хамт тавьжээ. Гэтэл өнөөх тахиа дэгдээхэйг гарган цөөрөмд аваачиж сэлүүлдэг болжээ. Энэхүү хоёр туршилтаар тахиа нь оюун ухаан, хайрлан энэрэх сэтгэлээр дүүрэн болохыг нотолсон байна. Тэрхүү тахиа өндгийг ямар шувууных болохыг нь мэдрэн дэгдээхэйнүүдэд өсөн бойжих арга замыг нь зөв зааж байсан байна. Амьтан үүнийг хийж чадаж байхад хүмүүс бид өөрийгөө амьд бүхний хаан хэмээн өргөмжилчхөөд үнэн хэрэгтээ ан, амьтныг хөнөөн идэж яаж чадаж байна вэ? Үүний зэрэгцээ дайн дажин хийж бие биеэ устгах сэтгэл хаанаас гарна вэ?

(Баруун талаасаа 4 дэхээс 2 дэх хүртэл) Тосгоны зөвлөлийн гишүүн, номын санч хадагтай Гуа Донг нан авшигтнуудын хамт Пингси хотын дарга Линь Йао-тинг

Хатагтай Ши мөн гахайд видео тоглоом тоглохыг зааж өгсөн туршилтаасаа хуваалцсан юм. Энэхүү туршилтаар гахай нь уг тоглоомын удирдлагыг нохой болон

сармагчингаас илүү хэрэглэх чадвартайг харуулжээ. Иймээс судлаачид гахайг нөгөө хоёр амьтнаас илүү оюун ухаантай хэмээн дүгнэсэн байна. Гахай нь мэдэрч, сэтгэн бодож чаддаг, цэцэн ухаантай амьтан байхад хүмүүс бид тэдгээрийг хязгаарлагдмал орон зайд боймлон хорьж, хэрцгийгээр нядалж хороодог бус уу.

Сургалт-семинарын үеэр гахай нядалж буй тухай видео бичлэг болон “жинхэнэ баатрууд ” DVD киноны хэсгээс үзүүлэв. Энх тайван, эв ээ, энх тунх байдал нь энэ дэлхийн бүх амьд амьтад хоорондоо хэрхэн зохицож, хүндэлж амьдрахаас хамаарах учир холбогдлыг хүмүүст ойлгуулах нь уг семинарын зорилго юм. Иймд бид өөрсдийн хайр энэрэлийг харамгүй хуваалцан цагаан хоолтны амьдралын хэв маягийг хэвшүүлэх ёстой юм.

Найман өдрийн үзэсгэлэнгийн үеэр арав гаруй хүн Аръяабалын дөхөм бясалгалд суралцжээ. Түүнчилэн Аръяабалын бясалгалын талаар дэлгэрүүлж мэдэх үүднээс номын сангийн ажиллагсад Их Багшийн сургаальтай гүнзгий танилцаж эхэлжээ. Олон оролцогч Чин Хай Багшийн урлагийн бүтээлийг сонирхон биширч байлаа. Бид “Бясалгал оюун ухааныг тэлнэ” өгүүллийг (сэтгүүлийн 167дугаарт хэвлэгдсэн) номын сангийн мэдээллийн самбарт томруулсан байдлаар байнга тавьж сурталчилав. Номын сангийн ажиллагсад сонирхсон хүмүүсийг бүртгэн авч Аръяабалын бясалгал заалгахаар болов. Бурхан тэнгэрийн оронд очих үүд хаалгыг Пингши хотноо нээж өглөө. Бурханы ивээлд багтаж диваажинд буцан очихыг хүсэгчдийн тоо жил ирэх тутам улам олширч байна.

Цагаан хоолтон болж өвчин эмгэгээс сэргийлэх нь

Чиай мэдээллийн баг, Формоса (Хятад хэлээр)

[Чиаи] Өвчин эмгэгээс хэрхэн сэргийлэх тухай семинар-сургалтыг Цагаан хоолтны амьдралын хэв маягийн судалгааны нийгэмлэгээс эрхлэн Чунг Ченг Үндэсний их сургуулийн байранд 2006 оны 8-р сарын 25-ны өдөр хийв. Тайваний Үндэсний их сургуулийн эмнэлгийн Юнлин салбарын эмч Хуан Жиан Шун үндсэн илтгэлийг тавьсан байна. Зочдод дан ногоогоор хийсэн цагаан хоол танилцуулах зорилгоор үдийн зоог барьсан юм.

Семинарыг их сургуулийн интернет сүлжээгээр зарлаж, нийгэмлэгийн гишүүд идэвтэй сурталчилсны дүнд гурав дахин илүү хүмүүс цугларлаа. Их Багш Чин Хайн зурсан уран зургийг семинар-сургалтын өрөөний хананд байрлуулж, түүний шинэ бүтээл болох “Эрүүл мэндийг хангахуй” болон цагаан хоолны жорын “ Дээдийн дээд гал тогоо” номыг дэлгэн үзүүллээ. Их Багшийн од хэлбэртэй, гэрлийн гэгээнд цай хийж өгч буй Их Багшийн сэтгэл булаам “Гэгээрэл” фото зураг зочдыг угтан авч байв. Оролцогсдыг цагаан хоолны жорын дагуу бэлтгэсэн нарийн хоол болон амтатнаар дайлав. Хоолны цэсэнд суши (далайн байцааны ороомог), пүнтүүзтэй хуурга, байцааны ороомог, хулууны шөл, цэлцгий оруулсан юм. Олон улс үндэстний төрөл бүрийн хоол хүмүүст ихэд таалагдаж байв. Тэр тусмаа хүүхдүүд амтархан зооглож байлаа.

Үдийн зоогны дараа Хуан эмч цагаан хоол, бие болон сэтгэлийн эрүүл мэндийн талаар оролцогсдод мэдээлэл өгөв. Тэрээр дэлхий дахины тулгамдсан асуудал болох өвчин, өлсгөлөн, эдийн засаг болон байгалийн хямрал зэргийг хөндөж, энх тунх, энэрэл нийгүүслийн талаар ярьж тайлбарлав. Тэр цагаан хоолтны амьдралын хэв маяг, ач тус, давуу талын талаар олон жишээ иш татав. Мөн өөрийн амьдралын туршлагаас хуваалцаж, бясалгахын ач холбогдлыг таниулж, бие болон оюун ухааны хувьд эрүүл саруул амьдралын хэв маягийг хэвшүүлэхийг уриалав. Өвчин эмгэгээс сэргийлэхийн тулд цагаан хоолтон болж, өөрсдийн самуурсан оюун ухааныг ариусгаж ухамсараа дээшлүүлэхийг дахин давтан санууллаа.

Оролцогсод түүний яриаг халуун дотно хүлээн авч, цагаан хоолыг дэмжиж, саяхан амталсан хоолоо магтан сайшааж байв. Тэд цагаан хоолны талаар олон асуулт асууж, энгийн/химийн бордоогоор бордсон хүнс/ болон органик (химийн бордоогүй

тарьж ургуулсан) хүнсний ялгаа, цагаан хоолтнууд кальцийг хэрхэн нөхөж авдаг тухай сонирхож байлаа. Хүмүүс ярилцлагад идэвхтэй оролцон өөр өөрсдийн амьдралын туршлагаас бусадтайгаа хуваалцсан юм.

Семинарын дараа зочид Их Багшийн шинэ ном, бас сургаалийг унших, энэхүү сэдвийг гүнзгийрүүлэн судлах боломжийг үзэсгэлэнгийн танхимд бүрдүүлсэн байлаа. Энэ удаагийн ажил нь эрүүл, оюунлиг, бурханлиг ариун байхын учрыг таниулахыг зорьсон бөгөөд найрсаг, халуун дулаан уур амьсгалд болж өнгөрөв.

Ном сургааль түгээж сэтгэлийн дэм өгөх нь

Каосиунг мэдээллийн бүлгээс бэлтгэв (Хятад хэлээр)

[Каосиунг] Каосиунг төвөөс "Хүн бүр нэг ном хандивлая" ажлыг 2004 онд зохиож, Чин Хай Багшийн сүүлийн үеийн ном хэвлэлийг хотын номын сангийн 15 салбарт түгээсэн ба Их Багшийн ном сургаалийг олон нийт дуртайяа хүлээн авсан байна.

Багшийн оюунлиг сургааль, сайн номын хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Каосиунг төв нь ном түгээх, дүүргүүдийн номын санд хандивлах ажлыг энэ жил далайцтай зохион байгуулжээ. Багшийн шинэ бүтээл болох "Амьдралыг өнгөлиг өдрөг болгох нь", "Бурхан ба хүмүүсийн тухай Библийн сургаалиас" номыг Каосиунг хотын төв номын сан болон түүний 15 салбар, Каосиунг дүүргийн соёлын товчоо, бусад хотын 38 номын санд хандивлав. Энэхүү хандивын ажиллагааны ачаар Каосиунг хотын бүх номын сан Их Багшийн мэргэн сургаалийн номтой болсон байна. Их Багшийн "Алтан Зуунд шинэ амьдралыг сонгохуй" хэмээх нийгүүлсэнгүй илгээлтийг бүх уншигч нарт хүргэх зорилгоор "Өөрөөр амьдарцгаая" зурагт хуудсыг ном бүрд хавсаргажээ.

Их Багшийн оюунлиг аугаа сургааль, тэнгэрлиг илгээлт, хайр энэрэлийн үрийг хүн бүрийн зүрх сэтгэлд суулгаснаар тухайн нийгэм шинэ эрч хүч, бурханы хайрын амин дэмээр тэтгэгдэх болно гэдэгт бид итгэж байна. Нөгөөтэйгүүр олон мянган чин бишрэлтэн Их Багшийн ариун сургаалийг дагаснаар Бурханы гэртээ эргэн очих болно.

Үнэн гоо зүй, ач буяны хэлбэлзэлд умбах нь-Телевизийн суваг

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекц

Үндэсний i: *Бие даасан телевизийн суваг:*

“Дэлхийг шинэ зуунд хөтлөх нь”

“Энтейнмэнт” групп бэлтгэв. АНУ-ын Калифорниа мужийн Лос Анжелес хот (Англи хэлээр)

“Энэхүү дэлхий дээрх бидний амьдрал маш богинохон. Тиймээс маш өр ашигтай өнгөрөөх хэрэгтэй. Хүмүүсийг өөртөө үйлчлүүлэх гэсний хэрэггүй. Харин бид цаг үргэлж хүмүүст яаж үйлчлэх, туслах талаар асууж байх хэрэгтэй. Ингэж чадвал хэзээ ч буруудахгүй.

Бид дотоодынхоо билэг оюун, эерэг энерг, сайн үйлээрээ эргэн тойрноо болон хүмүүсийг адислаж явах бол харин гаднаа өөрсдийн цаг, хүч чадал, ухаан, авъяас чадвараа ямар ч цаг үед, хаана ч гэсэн бусдад туслахад зориулах хэрэгтэй. Хэрвээ бид үүнийг чин сэтгэлээсээ хийх аваас бид үргэлж сэтгэл хангалуун байж өөр юу ч хүсэхгүй хангалуун байх юм.

Төгс Гэгээрсэн Их Багш ЧинХай, Маоли, Формоса
1992 оны 4 сарын 10 (Англи хэл дээр хэвлэгдэв) 21-р Сэтгүүлийн “Багшийн сургааль” хэсгээс

Дэлхийг шинэ зуунд хөтлөх нь" лекцийнхээ үеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн өгсөн зөвлөгөө нь биднийг үнэхээр шийдвэртэй алхам хийхэд хүргэсэн билээ.

Түүний аугаа хайр, энэрэнгүй өгөөмөр сэтгэл биднийг өлгийдөн авч энэхүү дэлхийд гэгээ түгээхэд зоригжуулж байгаа билээ. Түүний хайр энэрэл, тусламжийн үйл ажиллагаа нь маш энгийн бөгөөд аугаа. Яагаал гэвэл энэ нь амьдралын ямар ч саад бэрхшээлийг давж хүн төрөлхтөнийг шинэ амьдралын хэв маяаг, үзэл бодолтой болоход тэргүүлж, жинхэнэ хайр, өөрийгөө үл хайхрахад гаргуун үлгэр жишээ үзүүлэхэд бидэнд тусалдаг.

"Бид өөрсдийнхөө байж чадна гэж төсөөлснөөс илүү аугаа байх хэрэгтэй. Бид хөршөө ямар байгаасай гэж хүссэнээсээ илүү сайн байх хэрэгтэй. Бид өөрсдийн хөрш, дотно хүмүүс, танилуудаасаа хүсч байгаагаасаа илүүг тэдэнд өгөх хэрэгтэй. Зөвхөн ийм замаар л бид хэрхэн энэрэнгүй, аминч биш, хайраар дүүрэн байхаа бусдад үзүүлж чадна. Бид өөрсдийгөө золиослохдоо албадсан биш, сэтгэлээсээ хийх хэрэгтэй, золиосолж байгаагаа ч мэдэхээ больтлоо, бодохоо больтлоо, золиос гэдэг үг байхгүй болтол дахин дахин хйих хэрэгтэй. Иймэрхүү хандлагатайгаар л бид дэлхийгээ бас нэгэн тэргүүлэх гэгээлэг газар болгож, Нирвана руу явах шаардлагагүй болох юм. Тиймээс энэхүү үзлийг байнга санаж өөрсдийнхөө дэлхийг диваажин болгох хэрэгтэй. Мянга мянгаараа бид хоорондын эерэг энерг, зөвшилцлөөрөө үүнийг хийж чадна."

Их Багшийн өөрийгөө огоорсон сэтгэлийн дэм үг олонд цацагдаж байх яг тэр үед буюу 2006 оны 9 сарын 7-нд Европд Төгс Гэгээрсэн Их Багшийн Телевиз анх байгуулагдаж байсан нь таарсан юм. Багшийн энэ урам хайрласан үгийг сонсоод бидний олонх маань Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн дэлхийн олон сая хүмүүсийг адислах тэрхүү олон улсын сансрын телевизийн сувгийг олонд хүргэхээр ханцуйгаа шамлан орсон билээ.

Уг өдөр тэрхүү гэгээрэлд хөтөлсөн телевизийн нэвтрүүлгийг үзсэн хүмүүс өөрийн эрхгүй Их Багшийн талаар сонирхон илүү мэдээлэл авахаар утасдаж байсан юм.

Нэгэн утасдагч хэлэхдээ нэвтрүүлэг маш их таалагдсан, "Тэр эмэгтэй маш энгийн даруу харагдаж байсан" гээд Их Багш Чин Хай маш ариун хүн гэдэгт итгэж байгаагаа хэлээд Түүний болон манай холбооны талаар илүү их мэдээлэл авахыг хүссэн юм.

"Эрт орой хэзээ нэгэн цагт бид сүнслэг болон дэлхийлэг зүйлд анхдагч болох нь маргаангүй. Бид өөрийгөө огоорох жинхэнэ хайрын төлөө үлгэр дуурайл, санаачилагчид нь болох ёстой. Ингэж л бид дэлхийгээ аварч, шинэ зуунд хөтөлж, бие биеэ хайрласан, авах биш өгсөн өгөөмөр орчинг байгуулах юм шүү дээ.

Бид сүнслэг замаар замнахдаа дэлхийдээ тусалж, байгаль орчноо улам сайхан болгож, ядуу болон гачигдалтай хүсүүст тусалж байх юм. Зөвхөн ганц нэг үндэстэнд биш нийт дэлхийдээ туслах хэрэгтэй. Энэ бол бидний ирээдүйн зорилт. Тиймээс бид өөрсдийн бүхий л чадлаараа хичээх хэрэгтэй.

Их Багшийн ирээдүйн талаарх үзэл Нью Йорк дахь үзэгчийг бидэнтэй холбоо барихад хүргэсэн юм. Тэрээр манай телевизийн нэвтрүүлгийг анх удаа үзсэн бөгөөд Багшийн дэлхийн талаарх үзэл түүнд их таалагдсан талаар хэлсэн юм. Кентаки мужийн нэгэн эмэгтэй өөрийнхөө сэтгэгдлийг хуваалцахдаа: "Би Христийн шашинд итгэж өссөн, тэгээд Библийн судартбичсэн .. миний гэрт маш олон өргөө байдаг … гэдгийг уншаад Бурхан өөр өөр итгэл үнэмшилтэй олон хүүхэдтэй гэж байгаа юм байна гэж бодлоо, сүүлийн үед энэ нь яг л тийм юм шиг санагдаад гээд цааш нь Их Багшийн сургааль нь ямар ч шашин

шүтлэгийг ялгадаггүйгээрээ олон итгэл бишрэлтэй хүмүүст хүрч байгаа нь таалагдаж байна" гэсэн юм. Мөн нэвтрүүлгийн зөвхөн сүүлийн хэсгийг үзэж амжсан боловч өөрийн үзэл бодолтой нь нийцэж байсан нь түүний сонирхлыг их татсан гэлээ.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн лекц нь төрөл бүрийн байдлаар олон хүмүүсийг сэтгэлийг эзэмдэж бас эдгээж байдаг билээ. Жишээ нь Мэриланд мужийн солонгос эмэгтэй хэлэхдээ тэрээр Библи судрат дурдсанчлан хүмүүний угийн нүгэлтэй байдаг талаарх үзэлд сэтгэл нь их эмзэглэж, буруутан мэт шаналдаг болохоороо Бурханаас маш хол мэт сэтгэгдэл төрдөгөө хэлсэн юм. Тэгээд Их Багшийн лекцийг сонсоод өөрийгөө үнэхээр Бурханы хүүхэд, үргэлж Бурханаас хайр энэрэл хүртэж байдгаа мэдэрсэн аж. Энэхүү мэдрэмж нь түүний сэтгэлийг ихэд хөдөлгөн тэр дороо утасдаж Багшийн талаар болон Гуан Инь бясалгалын аргын талаар сонирхож асуусан. Христийн шашинтан тэр эмэгтэйд Их Багшийн лекц үнэхээр гүн сэтгэгдэл төрүүлж манай сувгийг олж нээснээрээ ихэд олзуурхаж байсан юм.

Бас нэгэн Идахо мужийн оршин суугч эмэгтэй ганцаардлын дундаас санамсаргүй би Бурханыг оллоо гэж хэлсэн. Учир нь тэрээр "Би өчигдөр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн маш сонирхолтой нэвтрүүлгийг үзлээ. Би маш их ганцаардаж байсан болохоор зурагтаа асаатал Тэрээр ярьж байсан. Түүний философи надад маш их таалагдсан. Түүний хэлсэн үг бүрт би дурлаж байлаа." Үнэндээ, бид зүрх сэтгэлдээ шаналж, ганцаардаж байх тэр үед Бурхан биднийг тайтгаруулахаар ирдэг. Тэгээд хэрвээ бид бэлэн бол Тэрээр биднийг жинхэнэ гэрт маань буцаан аваачихад бэлэн байдаг.

Хойд Каролайн мужийн нэгэн цагаан арьстан эмэгтэй бидэнтэй холбогдсон юм. Тэрээр сайн сонсож чадахгүй байлаа. Бидэнд хэлэхдээ "Би танай нэвтхүүлгийг үзээд их таалагдлаа. Та нар дуулж байгаа видеогоо надад явуулахгүй юу? Би найзуудтайгаа хуваалцах гэсэн юм. Та нарт бүгдэнд нь хайртай шүү."

Хэдийгээр түүнд гараараа бичин иймэрхүү байдлаар холбоо барих нь хэцүү байсан ч тэрээр огт төвөгшөөлгүй бидэнтэй холбогдож мэдээлэл тэсэн ядан хүлээж байгааг хэлсэн юм. Бид түүнд Даваа гаригийн өглөө гэхэд түүний хүссэнийг явуулъя гэхэд бидний дэмжлэгэнд талархаж байгаагаа хэллээ.

Энэхүү "Үнэн гоо зүй, ач буяны хэлбэлзэлд умбах нь" нэвтрүүлгээрээ бид бусадтайгаа байнга хуваалцах талаар дахин сурсан бөгөөд Их Багшийн хүмүүнлэгийн ажлын тайланд ч мөн дурдагдсан билээ. 2006 оны 7 сард Багш Америк улс дахь ядуу тарчиг оюутан, хүмүүст санхүүгийн тусламцаа үзүүлсэн. Оранж мужийн эргийн колежийн эрхлэгч професор Хү Фам талархлаа илэрхийлээд "Би Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн талаар сонссон, түүний нэвтрүүлгийг үзэх дуртай. Түүний энэхүү тэтгэмжийн хандивт би чин сэтгэлээсээ болон Вьетнамын Оюутны Холбооны өмнөөс талархаа илэрхийлье. Түүний сургаалийг олон олон хүмүүс сонсох болтугай. Ялангуяа, сүнсэнд хоол болсон гэгээлэг сургааль нь дотоодын амар амгаланг олоход онцгой хэрэгтэй билээ" гэсэн юм. (Илүү мэдээллийг "Хайрын Үйл" хэсгээс уншина уу. Сэтгүүлийг дугаар #174.)

Их Багшийн тайланг уншаад Техас мужаас нэгэн эрэгтэй илүү мэдээлэл хүсэн бидэнтэй холбоо барьсан юм. Тэрээр Католик шашинтай Филипин хүн бөгөөд Филипин, Вьетнам улсын хамгийн ядуучуудад тусалдаг Католик шашны байгууллагыг удирддаг.

Тэрээр Багшийн хүмүүнлэгийн ажил болон лекцэнд нь гүн сэтгэгдэл төрсөн байв. Үнэндээ тэрээр Багшийн лекцийг хуулж авах гэсэн боловч гүйцээгүй байснаа бидэнд

дурдаад тэндээс Багшийн нэг өгүүлбэр үнэхээр анхаарлыг нь татсан тухай ярьсан юм. Энэ нь "Хэрвээ бид дэлхийгээ аугаа сайн болгъё гэвэл бид өөрсдөө эхлээд аугаа сайн болох ёстой". Түүний бодлоор энэ нь маш оюунлаг болоод хүчирхэг санаа бөгөөд урд нь хэн ч ингэж хэлж байгаагүй гэсэн юм.

"Бусдын тэвчмээргүй бүх зүйлийг тэвч, бусдын хийхийг хүсэхгүй байгаа бүх зүйлийг хийж хүн төрөлхтөнд хэрэгтэй ямар ч салбарт ажиллах хэрэгтэй. Энэ нь л аугаа эр хүний, эмэгтэй хүний замнал юм. Бид ийм аугаа байх ёстой. Бид хэрвээ дэлхийгээ аугаа байлгъя гэвэл өөрсдөө аугаа байх ёстой. Хэрвээ бид дэлхийн хүмүсийг сайн байгаасай гэж хүсч байвал өөрсдөө эхлээд сайн байх ёстой. Хэрвээ бид дэлхийг диваажин байгаасай гэж хүсч байвал бид дэлхий дээрээ яг л диваажингийн хүмүүс шиг амьдрах хэрэгтэй."

Дээр дурдсан ноёнтон Багшийн лекцны хуулбарыг авч сүмийнхээ гишүүдтэй хуваалцахыг хүсч байсан ба энэ нь бүх хүн төрөлхтөнд үнэтэй зүйл гэж үзсэн юм.

Их Багшийн хамгийн сүүлийн үеийн "Хэрвээ амьдрал чамгүй байсан бол" гэдэг дуунаас /Шөнийн мөрөөдөл DVD-ээс/ илүү сайхан нэвтүүлгийн төгсгөл гэж юу байх билээ. Энэхүү дуу нь хэдийгээр Вьетнам хэл дээр боловч ямар ч үндэс угсаа, итгэл бишрэл, хэлний бэрхшээлийг үл хайхран хүний сэтгэлд хүрдэг билээ. Ази хүмүүс цөөхөн байдаг Америкийн цагаан арьстай хүн хүртэл Их Багшийн дуулахыг сонсоод энэхүү хэлэнд үнэхээр дуртай болсон байдаг.

"Би нэвтрүүлгийн зөвхөн хамгийн сүүлийн хэсгийг л үзэж чадсан" гэж Техас мужийн нэгэн эр хэлсэн юм. Тэгээд тэрхүү дуу ямар санагдсан талаах асуухад тэрээр "Тэрийг л хэлэх гэж би утасдлаа" гээд "Энэ дуу надад маш амгалан тайван мэдрэмж төрүүлсэн". Тэр урд нь хэдэн сарын өмнө манай нэвтрүүлгийг үзээж байсан ч утасдаж байгаагүй гээд харин одоо Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн талаар илүү их мэдээлэл авахыг хүсч байгаагаа хэлсэн юм. Хавайд амьдардаг Вьетнам эмэгтэй Их Багш яагаад хайрын тухай дуу дуулж байгаа талаар сонирхсон юм. Их Багш маань маш олон авъяастай бөгөөд сүнслэг зүйлийг сонирхохгүй, урлагт дуртай хүмүүстэй ч холбогдохын тулд ингэж байгаа талаар хэлэхэд тэрээр машид таашааж Холбоонд хэрхэн нэгдэх талаар болон Их Багшийн талаар мэдээлэл агуулсан интернэтийн хуудасыг асуусан юм.

Бас нэг Католик шашинтай үзэгч "Маш сайхан дуу байсан" гэж өөрийнхөө сэтгэгдлийг хуваалцангаа Багшийн лекцийн үеэр зурагтынхаа өмнө зогсож хэрхэн Багшаас энерг авсан талаараа ярьсан юм.

Вержиниа мужийн холбогдогч зөвхөн сүүлийн хэсэг болох Багшийн дууг сонссоноо хэлээд түүний нэг найз нь Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайг үзэх дуртай гээд нэвтрүүлгийн талаар илүү мэдээлэл авахыг хүссэн юм. Тэрээр мөн манай Холбооны шинэ сэтгүүлийг байнга авч уншдаг уншигч байв.

Их Багшийн маань жинхэнэ хайрын хүчээр хүмүүсийн зүрх сэтгэл бүлээцэж гэгээрсээр байна. Түүний адислалын хүчээр бидэнд бүгдэнд маань байдаг сүнслэг чанар нь сэрсээр байна. Иймэрхүү гайхамшигт зүйлсийн амьд гэрч болсноороо бид энэ насандаа хайрт Их Багштайгаа учирсандаа ямар их азтай, адислагдсан гэдгээ дахин нэг санасан билээ.

Арьяабалын Номын Цогцос бүх төрөлхтнүүдэд Гэрэл гэгээг авчирдаг

Авшигтан номын эгч Иексэн, Сан-Франциско, Клифорни , АНУ

Нэгэн удаа тохиолдлоор ер бусын нэгэн үйл явдалын талаар номын эгчийн ярьсныг олж сонссон маань аряабалын номын цогцсыг бясалгах нь бидэнд төдийгүй бүхий л дэлхий ертөнцөд ач тусаа өгч байдаг гэдэгт намайг улам ихээр итгүүлсэн юм. Энэ нь нүдэнд үл үзэгдэх төрөлхтөнүүдийг ч мөн дэвшүүлдэг байна.

Энд ярих гэж буй зүйл маань тэр номын эгчийн ахуй ойлголт бөгөөд 2001оны 9 сарын 11нд АНУ д болсон үйл явдлын дараахан тохиолджээ. Нэгэн орой номын эгч хог хаяхаар гадагш гарчээ. Тэр үед номын эгч нүдний булангаар тэнгэрт том цагаан зүйл байхыг санамсаргүй анзаарчээ. Тэрээр тэр зүгрүү хараад бараг муужирч унах шахсан байна. Номын эгчээс 10 гаран метрийн зайд мянга орчим төрөлхөтнүүд зөвхөн цээжин бие нь харагдан агаарт хөвж байжээ. Тэд түүнрүү эгцлэн харалгүй тойлгойгоо бага зэрэг гудайлгасан нь бясалгагчыг хүндлэж, түүнийг айлгахгүйн төлөө байсан бололтой. Тэгэхдээ түүнд дараах санааг дамжуулсан нь “ Бид 9 сарын 11 ний үйл явдалд амь үрэгдэгчид. Бидэнд гэрэл байхгүй тул өөр газарт очиж чадахгүй байна. Бидэнд тусламж их хэрэгтэй байгаа бөгөөд аряабалын бясалгагч нар л зөвхөн туслаж чадна. Та бүхэн бидэнд Гэрэл илгээнэ гэж найдаж байна” гэжээ.

Дэлхий дээр маш олон бясалгалын бүлгүүд байдаг ч Аряабалын бясалгалынхан л зөвхөн тэдэнд туслаж чадна гэж онцгойлон заасанд би их гайхсан. Аряабалын бясалгалын төгс хүчин тэдэнд үлэмж тус хүргэж чадна гэдгийг тэд сайн мэдэж байсантай холбоотой байх.

9 сарын 11нд болсон аймшигт явдлын үеэр төвүүдээр дамжуулан багш бясалгагч нарт хохирогчдын төлөө илүү ихээр бясалгах зааварчилгаа өгч байсныг би санаж байна. Тэдгээр хөөрхий төрөлхтөнүүдэд бидний тус маш их хэрэгтэй байгааг багш мэдэж байсан нь тодорхой. Зааварчилгааны дагуу авшигтнууд илүү ихээр бясалгацгаасан юм. Гэвч бидний дундаас цөөнгүй хүмүүс бясалгаснаар тэдгээр төрөлхтөнүүдэд үзүүлэх тус дэмийн талаар сайн ухамсарлаагүй байж болох юм.

Багшаас ирсэн бүхий л зааварчилгаа маш их учир утгыг агуулж байдгийг энэхүү явдлаас жишээлж тодорхой мэдэж болох юм. Иймээс авшигтан ах, эгч нар багшийн зааварчилгааг үл тоомсорлох эсвэл бясалгалаар энэ дэлхийд ирж байдаг ашиг тусыг анхаарахгүй байж боломгүй байна. Хамтын бясалгал маш их хүчтэй бөгөөд дэлхий ертөнц болоод хамаг амьтанд тустай гэдгийг Багш маань бидэнд байнга сануулж байдаг.

Дайны Золиос

бологсодын талаарх

Гашуун Үнэн

Цаглашгүй Их Багш Чин Хайн айлдвар, Хсиху, Формоса, 8-р сарын 11, 1991 (Хятад хэлээр)

Видео хуурцаг No.187 II-р хэсэг

Сүнс болоод Тамын аль аль нь оршдог. Гэсэн хэдий ч бүх зүйл сэтгэлээс үүдэлтэй. Бид өнгөрсөн болоод энэ амьдралдаа юу хийснээс шалтгаалж бид үхэхдээ ижил уур амьсгалд орох болно. Нас барсан хойно амьдралынхаа туршид дадаж зуршсан тэр хэмжээст хөшиж гацтаг. Та бүхэн гэнэтийн үхлээр үхсэн, эсвэл цэргүүдэд алагдсан, дайны үед санаандгүйгээр амиа алдсан хүмүүсийн тухай хийсэн судалгааны талаар сонин сэтгүүл, телевизээс хаая нэг харж байсан байх. Тэдгээр хүмүүс сэтгэл зүйн хувьд үхэлд бэлэн бус байсан болохоор шоконд ордог байна. Мөнгөн утас нь гэнэт хүчтэй тасарснаас тэд өөрийн үхэлтэйгээ эвлэрч чаддаггүй. Тэд хайрцган дотор зугтаж чадахааргүйгээр хоригдсон мэт болж тодорхой нэг хэмжээст гэнэт хөшиж гацдаг. Тэд өөрсдийгөө армид дайтаж байгаа хэвээрээ гэж санан өдөр бүр хашгиран замдах бүхнээ алж устгасан хэвээрээ байдаг. Хий юм үзэж, харсан бүхнээ дайсан гэж санадаг. Тэд ердөө л дайтсан хэвээрээ. Дайн тулаан, гэнэтийн үхлээр үхсэн хүмүүс үнэхээр өрөвдөлтөй. Тэд энэ байдлаасаа Гэгээрсэн Их Багшийн тусламжгүйгээр хэзээ ч гарч чадахгүй. Амиа хорлогсдын хувьд ч мөн адилхан зүйл тохиолддог. Амиа хорлох үеийнх нь зовлон шаналал, үхсэн хойно нь ч тэднийг орхидоггүй. Үхэл хэн нэгнийг хэзээ ч зовлонгоос ангижруулахгүй!. Зүйрлэвэл залуу насандаа сурч мэдээгүй бол өтлөх насандаа их мэдлэгтэй болж чадахгүйтэй адил юм. Тиймээс дайны уур амьсгал хамгийн аймшигтай нь. Маш олон сүнснүүд өөрийн гацсан хэмжээсээс гарч чаддаггүй. Хэрэв маш урт удаан хугацааны дараа энэ байдлаасаа гарч хүн болж төрсөн тохиолдолд уур хилэгнэлээр дүүрэн дайтсан амьдралруу тэмүүлэх нь элбэг. Энэ дэлхий хүмүүст маш их хор хөнөөл учруулж байдаг. Тиймээс ихэнх оюунлаг хүмүүс дайны эсрэг байдаг ч түүнийгээ нээлттэй илэрхийлэх аргагүй байдаг. Тэд үргэлж дайныг эсэргүүцээд байвал хувьсгалчид мэт харагдаж, энэ нь хүмүүст буруу ойлголт төрүүлэх, эсвэл улс төрийн эрх мэдлийн төлөө тэмцэж байна гэж ойлгогдох байсан. Гэлээ ч тэд дайн хүмүүсийг сайн зүйлд хүргэхгүйг мэддэг учир зүрх сэтгэлээрээ дайны эсрэг байдаг. Шалтаг шалгаан нь юу ч байлаа гэсэн дайн бол муу зүйл. Дайны үед хүмүүст тайван ч үхэх боломж олддоггүй шүү дээ.

Дэлхийд тодрон гялалзах Хүчирхэг Удирдагчид цувралаас

Гэгээрсэн удирдлага доор Гэрэлт Ирээдүйг цогцлуулах нь

Их Багшийн үнэлгээ өгсөн нийтлэлээс

Бутан

Ард түмнийхээ Аз жаргалын төлөө

Тайбэйн мэдээний групп, Формоса (Хятад хэлээр)

Бутан нь Энэтхэг Хятадын дунд Гималайн нурууны өмнөд атираанд өлгийдүүлсэн жижигхэн орон юм. Бутан нь хүн ам цөөнтэй ч засаглалын ухаалаг бодлогоороо олон улсын хэмжээнд өндрөөр үнэлэгддэг орон юм.

АЗ ЖАРГАЛЫГ ЦОГЦЛООХ НЬ

Бутаны хаан нь ❤❤❤❤❤ ард түмэнийхээ хайр хүндлэлийг ихээр хүлээсэн нэгэн билээ. Тэрээр энгийн амьдралаар амьдарч, улс орноо ухаалгаар удирддаг. 1972онд төрийн эрхэнд гарч Хааны Титэм зүүсний дараагаар ард түмнийхээ буюу “дотоодын нийт аз жаргал”-ыг цогцлоох зорилготой байгаагаа мэдэгджээ. Тэрээр ард түмнийхээ аз жаргал, хөгжил цэцэглэлтийг дээшлүүлэн бэхжүүлэх нь түүний төр барьж байгаагийн эрхэм зорилго гэж үздэг байна. Өнөөдрийг хүртэлх энэ хугацаанд засгийн газар дөрвөн үндсэн чиглэлийг үйл ажилгааныхаа гол зорилго болгож байна. Үүнд: байгаль хамгаалал, урлаг соёлын сурталчилгаа, эдийн засгийн хөгжил болон сайн засаглал зэрэг болно. Энэ нь үндэсний нийт бүтээгдхүүнийг чадан ядан өсгөх, үйлдвэрлэл худалдаа арилжааг сохроор хөгжүүлэх бус, харин өөрийн иргэдийн амьдралын материаллаг болон оюунлаг талын хөгжлийг тэнцвэртэй байлгах бодлого юм.

Бутан улсын Хаан

Дэлхийд тодрон гялалзах Хүчирхэг Удирдагчид цувралаас

Гэгээрсэн удирдлага доор Гэрэлт Ирээдүйг цогцлуулах нь

Их Багшийн үнэлгээ өгсөн нийтлэлээс

Дэлхийн аваргууд

Бутан улсын шинэчлэлт өөрчлөлтийн явцад хаан Вангчук хүрээлэн буй орчныг хадгалан үлдээх тал дээр маш их санаа тавьж, иргэн бүр жилд доод тал нь 10 мод тарьж суулгах тухай хуулийг засгийн газраар батлуулжээ. Бутаны нийт газар нутгийн 75%ийг ой эзэлдэг бөгөөд онгон төрхөөрөө байдаг нь бахархууштай юм. НҮБ-ийн Хүрээлэн Буй Орчнийг Хамгаалах хөтөлбөрөөс Бутаны Эзэн Хаан болоод ард түмэнд байгаль хамгаалах үйлсэд оруулсан онцгой хувь нэмрийг өндрөөр үнэлж “ 2005оны Дэлхийн Аваргууд” шагналыг гардуулжээ.

Тамхийг хориглосон анхны улс

2004оны 12сарын 17нд улс даяар тамхи зарж борлуулах болон татахыг хориглосноор Бутан улс нь тамхийг бүрэн хориглосон дэлхий дээрх хамгийн анхны улс боллоо. Энэ нь гудамж талбай болон олон нийтийн газарт тамхи татах мөн борлуулхыг хориглосон гэсэн үг юм.

Боловсрол болон эрүүл мэндийн ашиг тус

Бутан улс нь бүрэн дунд болоод их дээд боловсролыг бүх иргэддээ үнэ төлбөргүй олгодог боловсролын салбар нь өндөр хөгжсөн орон юм. Мөн түүнчлэн засгийн газраас иргэдийнхээ эрүүл мэндийн үйлчилгээний бүх зардлыг даадаг. Ванчук хааны бодлого нь боловсролыг дэмжих, ялангуяа Бурхан шашины сургаалуудаар дамжуулан ард иргэдийнхээ материаллаг хүсэл сонирхолыг нь бууруулах явдал юм.

Ванчук Хааны төр барьсан 30 гаруй жилийн хугацаанд Бутаны ард түмний үндэсний орлого ихээр өсөөгүй ч ард түмний олонхи нь онгон байгалийн дунд тайван, аз жаргалтай амьдарч байгаа нь эмх замбараагүй энэ цаг үед тэнгэрийн орон гэлтэй.

Гэгээрсэн удирдлага доор Гэрэлт Ирээдүйг цогцлуулах нь

Их Багшийн үнэлгээ өгсөн нийтлэлээс



Сингапур ❤❤❤❤❤

Сингапурчуудын *“Ногоон”* хувь нэмэр

Сингапурын мэдээллийн баг (Англи хэлээр)

Дэлхийн дулаарал нь хүн төрөлхтөнд тулгараад байгаа өнөөгийн хамгийн ноцтой асуудал болоод байна. Аж үйлдвэрийн хувьсгалаас хойш хүмүүс гэр орон болон аж үйлдвэр, тээврийн болон бусад цахилгаан хэрэгслүүдийг ажиллуулахын тулд хуурай түлш ихээр шатаах болсон нь хүлэмжийн хийг үлэмж үүсгэж, энэ нь эргээд дэлхийн цаг уурын өөрчлөлтөнд сөргөөр нөлөөлж байна.

Сингапурыг газар нутагтай нь харьцуулахад хэт олон хүн амтай, жижиг арлын улс бөгөөд дэлхийн дулаарлын аюулыг тойрч гарсангүй. Сингапурын хувьд хамгийн дулаан арван жил нь 1990 оноос хойш болж байгаа ба үүнд 1997 оноос хойшхи бүх жилүүд хамаарч байна. Цаг уурын энэхүү өөрчлөлт нь өнгөрсөн арван жилд Сингапурын эдийн засгийн хөгжил түргэсч, үйлдвэржилтийг ихээхэн хурдацтай явуулсантай холбоотой. Амьжиргааны үзүүлэлт ихэд сайжирсан хэдий ч харамсалтай нь үүнийг дагаад агаарын бохирдол ихэссэн байна. Хүлэмжийн хийн хэмжээг одоогийн хэмжээнд нь барихгүй бол түвэгтэй байдалд орохыг Сингапурын засгийн газар ойлгож, агаарын бохирдлыг нэмэгдүүлэхгүйн тулд хэсэгчилсэн арга хэмжээ авч байна. Сингапурын Байгаль орчны сайд асан Ноён Ли Ся хэлэхдээ: “Материаллаг хөгжил бол бидний хэлэлцэх энгийн асуудал. Бид богино хугацааны эдийн засгийн өсөлт, нийгмийн дэвшлийн төлөө урт хугацааны байгалийн гамшгийг өөрсөддөө учруулж болшгүй” гэжээ. Сингапурын удирдлагууд агаарыг цэвэршүүлэхийн тулд хий ялгаруулалтын хэмжээг хуулиар хатуу тогтоон, хүчний зөв шийдлүүдэд дэмжлэг туслалцаа үзүүлж, энергийн цэвэр эх үүсвэрүүдэд хөрөнгө оруулалт хийхээр төлөвлөж байна. 2006 оны 4-р сард Сингапур Кёотогийн протоколд нэгдсэн ба хүлээсэн үүргийнхээ дагуу хүлэмжийн хийг багасгах арга хэмжээ авч байна. Кёотогийн протоколын нэг гол нөхцөл нь байгаль орчинд халгүй технологийг хэрэгжүүлснээр илүү үр дүнд хүрэх, энэ чиглэлийн ажлыг дэмжих явдал юм. Кёотогийн протоколын дагуу хэрэгжих Сингапурын “Байгаль орчинд халгүй төлөвлөгөө - 2012” нь агаарын нүүрсхүчлийн хийг 2012 онд 1990 оныхоос 25% бууруулах зорилт дэвшүүлээд байна.

Дэлхийд тодрон гялалзах Хүчирхэг Удирдагчид цувралаас

Гэгээрсэн удирдлага доор Гэрэлт Ирээдүйг цогцлуулах нь

Их Багшийн үнэлгээ өгсөн нийтлэлээс

Сингапурын анхны шахмал хийн автобус

CNG хөдөлгүүртэй “Смарт” такси. “Сматр” нь Сингапорт CNG хөдөлгүүр бүхий автомашин хэрэглэсэн анхны компаниудын нэг юм.

Мөн уламжлалт тээврийн хэрэгслийг хий бага ялгаруулдаг хэрэгслээр солихыг дэмжиж байгаа юм. Улсын тээврийн асуудал эрхэлсэн мэргэжлийн байгууллагаас “Байгаль орчинд халгүй” машин унахыг хүмүүст зөвлөж байна. Эдгээр тээврийн хэрэгслүүдэдердийнавтомашинаасбага нүүрсхүчлийн хий ялгаруулдаг холимог цахилгаан тээврийн хэрэгслүүд болон байгалийн шахмал хийгээр ажилладаг автомашин багтана. Холимог тээврийн хэрэгсэл нь уламжлалт хөдөлгүүрүүдийг цахилгаан буюу агаарын даралт зэрэг өөр эх үүсвэрүүдтэй хослуулсан байдаг. Холимог тээврийн хэрэгсэл нь хөдөлж эхлэхдээ цахилгаан мотор хэрэглэж, бага хурдаар явдаг. Хуурай түлшит хөдөлгүүр хурдаа авч өндөр хурдаар явахын тулд цахилгаан моторын холбоосоор ажилладаг. Хүмүүст холимог болон шахмал хийн автомашиныг худалдан авахыг дэмжиж Засгийн газар үнэ болон татварын хөнгөлөлт үзүүлж байна. Энэ мэт ажил нь жолооч нарт тээврийн хэрэгслэлээ Евро II-стандартын болон түүнээс илүү үзүүлэлттэй Евро IV–стандартын тээврийн хэрэгсэлд шилжүүлэхэд дөхөм болж байна. Энэ ажлын цар хүрээг өргөжүүлэхийн тулд “Байгаль орчинд халгүй тээврийн хэрэгслийн хөтөч” хэмээх гарын авлагыг олон нийтэд танилцуулж байна. Сингапурын Засгийн газар хариуцлагатай удирдлагын салшгүй хэсэг болох байгаль орчныг хамгаалахад ихээхэн анхаарлаа хандуулж байна. Иймэрхүү гэгээлиг бодлогоор эдийн засгийн хөгжил болон байгаль орчныг хамгаалах явдлыг зохистой хослуулах боломжтой юм. Шахмал хийгээр явдаг “Ухаалиг такси“ нь энэ чиглэлийн тээврийн хэрэгслийг ашигласан Сингапурын анхны компаниудын нэг юм.

Сингапурын Байгаль орчинд халгүй тээврийн хөтөч

Нэмэлт лавлагаа

FAQ on Motor Vehicle Emission and Green Vehicle Technology:http://app.nea.gov.sg/cms/htdocs/category_sub.asp?cid=34#q6
Singapore’s “Green Transport Guide”: http://www.neec.gov.sg/fueleconomy/GTD05Booklet.pdf
The Singapore Green Plan 2012: http://www.mewr.gov.sg/sgp2012/index_2006.htm

Дэлхийд тодрон гялалзах Хүчирхэг Удирдагчид цувралаас

Гэгээрсэн удирдлага доор Гэрэлт Ирээдүйг цогцлуулах нь

Их Багшийн үнэлгээ өгсөн нийтлэлээс

Нидерланд ❤❤❤❤❤❤

Ядууралтай тэмцэж буй орнуудаас Европчууд дээгүүр байр эзлэж байна

Авшигтан номын ах Рой Маннарт, Амстердам, Нидерланд (Герман хэлээр)

Нидерланд улс дэлхийн ядууралтай тэмцэж буй орнуудаас нэгдүгээрт орлоо. Үүнийг дэлхийн хамгийн баян 21 орноос ядуурлыг бууруулахын тулд үзүүлж буй тусламж дэмжлэгийн хэр хэмжээг харьцуулсан жагсаалтаас харж болох юм. CGD буюу Глобал хөгжлийн төв бууруулахын төлөө төвөөс эрхлэн гаргадаг. Энэ үзүүлэлт нь тухайн орны хүн амын тоо, эдийн засгийн чадамж, тусламжинд шууд хандивлаж буй үндэсний бүтээгдхүүний хувь зэрэг хүчин зүйлүүдээс шууд хамааралтай байдаг. Олон улсын норм хэмжээ 0.7%, байдаг ч Нидерландчууд үүнээс хавьгүй ихийг хандивладаг байна. Дээрх төв нь худалдаа арилжаа, хөрөнгө оруулалт, шилжилт суурьшилт, хүрээлэн буй орчин, аюулгүй байдал болон техник технологтой холбогдох хөгжлийн бодлогыг харгалзан үздэг. Ялангуяа хөрөнгө оруулалтын тал дээр илүү анхаарал тавьдгийг Нидерландын нэгэн компани ядуу оронд үйлдвэр байгуулж өндөр үнэлгээ авч байснаас харж болно. Түүнчлэн мөргөлдөөний бүс нутгуудад энхийг тогтоох үйл ажиллгаанд хувь нэмэр оруулах гэх мэт аюулгүй байдлын бодлого нь багагүйгээр үнэлгддэг байна. Гэсэн ч хөгжлийн төлөө төвөөс мэдээлснээр Нидерландчууд үүнээс ч ихийг хийж чадах гэнэ.

Сайд Ван Ардэннэ (Нидерландын хөгжлийн хамтын ажиллгааны яам) нэг дүгээр байранд орсондоо сэтгэл хангалуун байгаа аж. “ Энэхүү бие даасан үзүүлэлт нь Нидерланд улс хөгжлийн томоохон хөтөлбөртэйг харуулж байна. Дан ганц тусламж нь ядууралтай тэмцэхэд хүсүүштэй үр дүнд хүргэхгүй. Нидерланд улс хөгжиж буй орнуудад экспортыг дэмжих, хувийн чанартай хөрөнгө оруулалтыг түлхүү үзүүлэх тал дээр мөн анхаарал тавьдаг.

Энэхүү Индэксийн ачаар засгийн газраас ядууралтай хийж буй тэмцэл, хөгжилд оруулж буй хувь нэмрийг олон улсын зүгээс зүй ёсоор үнэллээ.

Таныг мэддэг болсноос хойш

Эх газрын хятадын авшигтан (Хятад хэлээр)

Таныг мэддэг болсноос хойш би хүүхдийн тоглоом тоглож байгаагийн адилаар энэ ертөнцөд наадчихмаар олон юм байгааг ухаарч эхэлсэн. Мөрөөдлөөсөө сэрээгүй байгаа хүмүүсийн хувьд энэ дэлхий дээрх юухан ч гэсэн хялбар биш. Энэ дэлхий дээр хамгийн хялбар нь болох Дотоодын Бурханаа санасан цагт л зүрх сэтгэл баяр жаргалаар дүүрдгийг хүмүүс ойлгоосой хэмээн би хүсдэг. "Намайг хайрлаач" хэмээх Таны дуунд "Намайг хайрлаач! Урьд нь хэнийг ч тэгтлээ хайрлаж байгаагүйгээр намайг хайрлаач! Намайг хайрлаач! Зөвхөн намайг л хайрлаач!" хэмээн Та минь дуулдаг. Энэ дууны цаад утгыг олохоор эрэлхийлж байхад минь доорх жижиг шүлэг төрсөн билээ.

Энэ гариг дээр төрснөөс хойш

Дэлхийг тэмтчин энэ гаригт төрөөд
Толгой эргэм аль бэрхтэй учирч
Тоогоо алдсан гашууныг амсаж
Тоймгүй бэрх тавилан минийх байсаан
Таныгаа таньж л
Зүрх минь хайлсан
Түнэр харанхуйд чийдэн асах мэт
Гэрэл намайг гийгүүлсэн
Таныг санах бүр
Сэтгэл зүрхэнд
Хөгжим намуухан эгшиглэж
Баярын нулимс мэлтрэн урсдаг
Дотоодод минь нуугдмал Их Багшаа нээмэгц
Тун ч гайхам аз жаргалыг олж
Тантай өнгөрөөх болсон мөч бүрд талархдаг
Энэ л харгуйгаар Таныгаа бараадаж
Эзэн Бурханы аугаа адист багтан
Энгүй их аз жаргал уруу дөтөлнөм би

Эрхмийн Дээд Багш ээж минь ээ, би өөрийнхөө дадалд захирагдан заримдаа бясалгалынхаа замд алдаа гаргадаг бол Таныхаа өмнө нүглээ наминчилж байна. Тэр болгонд Таныхаа тэр их тэвчээр, хатуужил, өгөөмөр сэтгэлийг, Та мөн надтай үргэлж хамт байдгыг ухаарсан. Ямар ч үед зүрх сэтгэлийг минь гэрлээр гийгүүлэн, нүдний минь нулимсыг асгаруулдаг хүн бол зөвхөн Та минь билээ.

Тэдний эд баялаг

Хонгконгийн мэдээллийн баг (Хятад хэлээр)

Дэлхийн олон баячууд өгөөмөр сэтгэлийн хандив өргөсөөр байна. Ноён Баррен Баффет нь Форб сэтгүүлийн дэлхийн хамгийн баян хоёрдогч хүнээр шалгарсан нэгэн бөгөөд дөчин дөрвөн тэрбум ам. долларынхаа 85%-ийг хүмүүнлэгийн таван санд хандивлахаа мэдэгдэв. Түүний энэ гайхалтай хүмүүнлэгийн үйл хэрэг нь олны талархлыг хүлээсэн билээ. Саяхан Хятадын хамгийн баян нэгэн, Форб сэтгүүлийн дэлхийн жагсаалтын аравд бичигдсэн ноён Ли Ки Шан❤❤❤❤❤❤ө м ч хөрөнгийнхээ гуравны нэгийг /64 тэрбум ам.доллар/ өөрийн гурван хүмүүнлэгийн санд хандивлахаар шийдсэнээ зарлав. Тэрээр түүний гэр бүлийн гишүүн биш ч бай, мөн ч бай хамаагүй сангийн захирлууд сангаас мөнгө авч болохоор гэрээслэсэн байна.

Тэр бээр далан найман настай тэрбумтан, ноён Баффетийг өмч хөрөнгийнхээ ихэнхи хэсгийг буяны тусламжинд хандивласанд нь ихэд магтаж байсан юм. "Үнэхээр сайн байна! Ийм зүйл хийж байдаг түүн шиг хүмүүсийг би гайхан биширдэг" гэж хэлсэн тэр бээр "Амьдрах хугацаандаа нийгэмдээ болоод хүмүүсийн амьдралд туслах боломж байвал энэ нь маш чухал юм. Амьдралынхаа турш би үүнийг зорилгоо болгож ирсэн" гэжээ. Өнгөрөгч арван жилд ноён Ли олон нийт, зовж зүдэрсэн хүмүүст өөрийн нэр дээр байгуулсан сангуудаараа дамжуулан үлэмж хандив хүртээсэн юм. Тэрээр өөрийн том корпорацийг санд мөнгө хандивлах, нийгмийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцох үйл хэрэгт татан оролцуулж байсан юм.Түүний нигүүлсэнгүй үйл хэрэг нь Европ, Ази, Америкаар дамнан өргөжиж боловсрол, соёл, анагаах ухаан болоод бусад салбаруудыг хамарсан байна. Тэр одоо өөрийн сангууддаа зуун мянгаас илүү гишүүдтэй.

2005 онд Францын ерөнхийлөгч Ф.Жак Ширак түүнд шагнал гардуулсан байна. Ерөнхийлөгч Жак Ширак ноён Лигийн залуу үеийнхээ хүнд хэцүү зовлон бэрхшээлийг даван туулсан няцашгүй зориг хийгээд барилгын салбарт урьд өмнө нь байгаагүй их амжилтанд хүрснийг нь өндрөөр үнэлжээ. Амжилтын үр шимийг амталсан ноён Ли анагаах ухаан, боловсрол, соёлын салбарт тус нэмэр болох, хувь хандив оруулахад ухамсарт амьдрал, хүч хөдөлмөрөө зориулж ирсэн нэгэн юм. Үйл хэргээрээ дэлхийд хосгүй ховорхон түүний үлгэр дууриал бусдыг хошуучлан дагуулж байна.



Ноён Ли нь Панама, Англи, Хонконг, Бельгийн засгийн газруудын шагналыг хүртэж байсан юм.

Их Багш маань: "Би алт мөнгөтэй төрөөгүй учир энэ дэлхийгээс явахдаа ч алт мөнгөтэй явахгүй. Надад байгаа бүхэн та нарынх, энэ дэлхийнх, яг л эндээс аваад тэнд тавихтай адил. Энэ бидний хэний нь ч хувьд адилхан. Бид голоос ус аваад ус түгээгүүрийн хоолойд хийхэд л бүхэл хот тосгоноор тараахтай ижил. Бид яг л ундны усны түгээгүүр шиг амьдрах хэрэгтэй. Бидэнд байгаа бүхэн бусдад тараах түгээхийн төлөө байдаг юм. Бид бол зөвхөн хүлээн авагчид" /Их Багш Чин Хай, Формоса, Тайпей хот, 1994 оны 5 сарын 23. эх нь хятад хэл дээр/ гэж айлдсан билээ. Ноён Ли, Билл Гейтс, Баррен Баффет шиг хүмүүс эд хөрөнгө нь хаанаас ирснийг мартдаггүй юм. Тэд аз завшааныг ашиглан буцаан нийгэмдээ тусалдаг. Тэд энэхүү хайрын үйлээрээ мөнгийг чухамхүү үнэ цэнтэй болгож байдаг. Энэрэнгүй үйлс нь тэднийг энэ дэлхийн үлгэр дууриал болгож байна.

Нью Йорк хотын дарга

Дэлхийд тустай үйл хэрэгт өөрийн хувь нэмрээ оруулллаа

Нью Йоркийн мэдээллийн баг (Англи хэлээр)



Нью Йорк хотын дарга Майкл Блүүмбэрг саяхан тамхины эсрэг компанит ажлаа алхам ахиулав. 2006 оны 8 сарын 15 нд дэлхийн тамхины эсрэг компанит ажилгаанд тэрээр өөрөөсөө 125 сая ам доллар зарцуулахаар амлажээ. Энэхүү хандив нь тамхины эсрэг үйл ажиллагаа явуулж байгаа байгууллагуудад 2 жил гаруйн хугацаанд хувиарлагдах бөгөөд тамхийг хязгаарлах үйлсэд хувь хүнээс үзүүлж буй маш том хувь нэмэр юм. Ноён Блүүмбэрг нь Америкийн томоохон баячуудын нэг бөгөөд өөрийн буянт үйлсээ тэр бүр хүмүүст тунхаглаад байдаггүй нэгэн. Харин энэ удаад тэрээр тамхины эсрэг компанит ажлынхаа талаар олон нийтийн

байгууллагуудаар дамжуулан мэдэгдэл хийж нээлттэйгээр хэлэлцжээ. Энэ нь тамхины эсрэг үйл ажиллагаа явуулдаг байгууллагуудад өөрийн сангийн талаар сонордуулах гэсэн явдал байлаа. Блүүмбэрг хэлэхдээ" Би хамгийн сайчуулын анхаарлыг татах замаар бидний бодож олоогүй ямар нэг шинэ санааг хэн нэгэн гаргаж ирэх үгүйг мэдэхийг хүссэн юм" гэжээ. Блүүмбэрг 30 жилийн өмнө тамхийг хаяж тэр цагаас эхлэн тамхи үйлдвэрлэгчдийн эсрэг тууштай тэмцэгч болжээ. Тэрээр хотын дарга болсноосоо хойш доктор Томас Р. Фрийдэнийг өөрийн эрүүл мэндийн зөвлөхөөр томилжээ. Доктор Фрийдэн нь халдвар судлаач мэргэжилтэй бөгөөд ноён Блүүмбэргийн тамхины эсрэг хатуу байр суурийг дэмжигч юм. Тэд тамхины хэрэгцээг багасгах олон талаас нь тооцож судалсан төлөвлөгөө гаргасан байна. Үүнд: Тамхинд ноогдуулах татварын хэмжээг нэмэгдүүлэх, ажлын байрыг тамхигүй орчин болгох хууль тогтоомж гаргахыг шаардах, улмаар Нью Йорк хотын бүх баар рестораннуудад тамхи татахын эсрэг хууль тогтоомжийг мөрдүүлэх, хүмүүсийг тамхинаас гаргах зорилгоор никотинийг орлуулах бүтээгдхүүнийг түгээх, тамхинаас болж хүний эрүүл мэндэд учрах эрсдлийн талаарх хүмүүсийн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор олон нийтийг хамарсан компанит ажил өрнүүлэх зэрэг болно. Хэвлэлийн бага хурал дээр ноён Блүүмбэрг "Явал хүмүүсийг тамхинаас хялбархан гаргах тал дээр бид баггүй туршлага хуримтлуулсан гэж би бодож байгаа" гэжээ. Тамхины эсрэг дэлхий даяарх шинэ компанит ажлыг нийгэмд оруулж буй хөрөнгө оруулалт юм гэж тэр тайлбарлаж байна. Жил бүр дэлхийн хэмжээнд 5 сая гаруй хүний амь насыг авч оддог тамхидалт нь урьдчилан сэргийлэх боломжтой зүйл болохыг ДЭМБ- аас анхааруулж байна. "Энэ бүхнийг эргүүлэх гэсэн дэлхий нийтийг хамарсан үйл явц эрч хүчээ авч байгаа бөгөөд баян, ядуу дэлхийн олон орнууд тамхины хэрэглээг хязгаарлаж, тамхинаас гарахыг хүсэгчдэд туслах арга хэмжээг авч хэрэгжүүлж эхлээд байна" гэж ДЭМБ-ын ерөнхий захирал, доктор Андэрс Нордсторм хэлжээ. Түүний үзэж байгаагаар Ноён Блүүмбэргийн өгөөмөр хувь нэмэр нь тамхины эсрэг хөдөлгөөний эрч хүчийг нэмэгдүүлхэд тус болох ажээ.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл:
http://no-smoking.org/aug06/08-16-06-3.html
http://www.scoop.co.nz/stories/WO0608/S00238.htm

Тахиануудад боломж олгож буй Буяны үйлс

Их Британий мэдээллийн групп (Англи хэлээр)

"Тахианууд ухаантай амьтад. Тэд байгалиас заясан өөрийн зан араншингаа гаргах хүчтэй зөн билэгтэй, бас өдөөлт болон харьцаанд орохыг эрэлхийлж байдаг" ~ Жэйн Ховарт (BHTW- ийг үндэслэгч)

Жэйн Ховарт болон түүний нөхөр Девон руу шилжин суурьшихдаа цөөн тооны тахиаг хобби болгон гаднаа тэжээхээр төлөвлөж байжээ. Гэсэн хэдий ч энэхүү төлөвлөгөө нь төдөлгүй тахиаг аврах



даалгавар болон хувирчээ. Нэгэн өдөр тахиа авахаар өндөглөгч тахианы ферм дээр очиж тэндэхийн байдлыг харж дотор нь хирдхийн муухайрсан Жэйн анх төлөвлөснөөсөө гурав дахин илүү тахиаг гэртээ авч харьжээ. Бараг л нэг шөнийн дотор Жэйн Ховарт тахианы сайн сайхны төлөө тэмцэгч болон хувирсан байна. Түүний байшин зуун зуун өндөглөгч тахианы гэр болсон бөгөөд улмаар (BHWT) буюу өндөглөгч тахианы төлөөх байгууллага үүсгэн байгуулагдсан юм.

BHWT нь зовж шаналсан олон тахиаг нядалгааны газар болон фермүүдээс олон жилийн турш аварч амар тайван амьдрах гэр орон, эрүүл мэндээр хангаж үрчлүүлэх үйл ажиллгааг явуулсаар иржээ. Өндөглөгч тахиаг агуулах торыг ашиглахыг хориглосон хуулийг батлуулахын тулд Жэйн боломж завшааныг ашиглан олон нийтэд мэдээлэл хүргэх, нийтлэл бичих, илтгэл тавих зэргээр аль болох олон хүний сонорт асуудлыг хүргэхийг оролддог байв. Түүний хийсэн ажлын үр дүнд орчин үеийн өндөгний үйлдвэрлэлийн харгис хэрцгий байдлыг олон хүн ухаарч ойлгож байгаа нь түүний хичээл зүтгэл үр өгөөжөө өгч байгааг илтгэж байна. Жэйн болон түүний нөхөр сайн дурын багийн хамтаар 2003оны 10сараас хойш 23,396 тахиаг аварч гэрийн тэжээвэр амьтан болгож үрчлүүлжээ. Хэрцгийгээр алагдах хувь заяатай байсан тэдгээр тахианууд шинэ гэртэй болох сайхан боломж олдож хөдөө нутгаар аз жаргалтай гүйж явна. Англи улс даяар хэд хэдэн аврагчид энэхүү буяны үйлсд зүтгэж байна. Жэйн Ховартын тахиануудын сайн сайхны төлөөх цуцалтгүй хичээл зүтгэл энд хүрээд зогссонгүй. Тэрээр одоо дахин байршуулах төвүүд -ийн сүлжээг улс орон даяар бий болгох ажлыг зохион байгуулж байна.

Нэмэлт Мэдээлэл

Өндөглөгч тахианууд далавчаа ч дэлгэж чадахааргүй хавчиг төмөр торонд өдөр шөнөгүй зогсож бүхий л амьдралаа өнгөрөөх бөгөөд торны шал нь хөлд нь шигдэж өвтгөдөг. Төмөр торонд бие нь байнга үрэгдсэнээс болж хамаг өд сөд нь унах бөгөөд бие нь шарх сориводоор дүүрдэг байна. Тороор нь түүрэн байдаг химийн бодис нь тахиануудын нүдийг түлж бүр сохолдог. Дэгдээхэйг өндөгнөөсөө гарах үед хушууг нь тайрч богиносгодог нь тэднийг цус алдаж эсвэл шоконд оруулж улмаар олон дэгдээхэйг 24 цагийн дотор үхэхэд хүргэдэг. Зарим нь бүр мөсөн хошуугүй болсноор хооллох ч аргагүй болдог. Дээрх торнуудын хэрэглээг 2012он гэхэд Европын бүх орнуудад хориглохоор төлөвлөж байгаа ч эсэргүүцэлтэй байнга тулгарсаар байгаа тул олон нийт ялангуяа хэрэглэгчдийн дэмжлиг хэрэгтэй байгаа юм. BHWTнь өөрсдийн хүчин чармайлтаараа өдрөөс өдөрт дэлхийг өөрчлөж байгаа байгууллага билээ.

http://www.thehenshouse.co.uk

Нэрт эрдэмтэн хүн төрөлхтөнийг зөв зохистой хоол хүнс сонгохыг уриалж байна

Авшигтан Хаппи, Эх газарын хятад (Англи хэлээр)



Dr. Jane Goodall
and her book "Harvest for Hope"

Жэйн Гүүдоол нь дэлхийн шимпанзе судлалын нэрт эрдэмтэн юм. Түүний шинжилгээ судалгааны ажил нь хүн болоод амьтны хоорондын уялдаа холбооны талаарх шинжлэх ухааны ойлголтыг өөрчилөж чадсан билээ. Эрдэм шинжилгээний бага хуралд оролцож шимпанзе болон бусад ойн амьтад агнагдаж, хүнсний зориулалтаар худалдаалагдах ноцтой аюул учраад байгааг олж мэдсэнээр өөрийн судалгаа шинжилгээний ажлыг амьтныг хамгаалахын чухлыг хүмүүст ойлгуулахад чиглүүлжээ. Ингэх явцдаа өлсгөлөн, ядуурал, дүрвэгсэд, мал амьтны аж ахуй, хүрээлэн буй орчны сүйрэл гэх мэт олон өөр хүрээнд орж ажиллажээ. Аажмаар ан амьтан болоод байгалиа хамгаалахын чухлыг хүмүүст уриалахын сацуу хүмүүнлэгийн боловсорлыг залууст ухуулагч, байгаль хамгаалагч, нийгмийн ажилтан болжээ. Түүний авсан шагналуудын дотор Ганди-Кинг шагнал байгаа нь зөвхөн шинжлэх ухааны судалгааны төдийгүй мөн хүмүүнлэгийн салбарт хичээл зүтгэл гаргасны үнэлгээ юм. 2002оны 4сард НҮБ-ийн тэргүүн Кофи Аннан НҮБ-ийн энхийн элчийн ажилд Гүүдоолыг томилжээ. 2005 оны сүүлчээр Гэрри Маковий, Гэйл Хадсон нартай хамтарч хоолллотын тухай (Харвэст фор хоуп) -номоо хэвлүүлжээ. Энэхүү ном нь Бурханы адис хүчээр хүн төрөлхтөний ухамсар дээшилж байгаагийн нэгэн илрэл юм. Тэрээр номондоо хоол хүнсий үйлдвэрлэл болоод хоолны хэрэглээгээ эргэж нухацтай харахыг эрдэмтэн хүний зүгээс зөвлөжээ. Мөн өөрийн үр хүүхэд, эх дэлхийнхээ ирээдүйн төлөө эрэг өөрчлөлтүүдийг хийх нь хичнээн хялбар болохыг өгүүлсэн байна. Түүнчлэн байгалийн гаралтай бүтээгдхүүнээр үйлчилдэг ресторан, дэлгүүрээр үйлчлүүлэх гэх мэт эрэг өөрчлөлтүүдийг амьдралдаа мөрдөхийг зөвлөжээ. Газар тариалангийн эхэн үеийн түүх, түүний алдаатай менежментээс аваад генийн хувьд өөрчлөгдсөн орчин цагийн хоол хүнс, үйлдвэржсэн фермийн аймшигтай бодит байдлыг уншигчдад хүргэхийг зорьжээ. Амьдралын хэв маягаа хэрхэн өөрчилж болох тухай, мөн усны ариг гамтай хэрэглээ, байгалийн гаралтай хоол хүнсний хаяг шошгийн сайжруулалтын тухай гэх мэт системийн өөрчлөлт хийхийг хэрхэн шаардах тухай зөвлөмжүүдийг уншигчид энэхүү номноос авах



боломжтой. Магадгүй хүмүүс ухаалаг зөв зохистой хооллосноор хувь хүн болоод бүх дэлхий ертөнцөд үзүүлэх ер бусын ашиг тусыг олж мэдэх нь хамгаас чухал юм. “Нэг дүгээрт бол Байгаль орчин” гэж доктор Гүүдоол тайлдбарлаж байна. “ Үржил шимтэй их хэмжээний ойг малын бэлчээрт зориулж огтлон тайрч байна. Хүмүүс баян чинээлэг болохын хирээр махны хэрэглээ нь өсөж байна. Хоёрдугаарт идэж байгаа зүйлс маань биднийг амьтны аминд шууд хүргэж байна. Гуравдугаарт хоол хүнснээс бидний эрүүл мэндэд үзүүлж буй нөлөөлөл. Газар тариаланд дахь химийн бодисоор бохирлогдсон хоол хүнснээс үүдэлтэй бүх төрлийн харшлын өвчнүүд болоод хэт таргалалтыг аваад үзэхэд л хангалттай шүү дээ.” “ Махыг ихээр хэрэглэхгүй байх нь зүйтэй. Мах ихээр хэрэглэх нь тэртэй тэргүй эрүүл мэндэд сайнгүй байтал үйлдвэржсэн фермийн мал амьтны махыг хэрэглэснээр үлдэгдэл антибиотек, даавруудыг авч биеэ давхар хордуулж байна. Тэдгээр амьтадтай яаж харьцаж байдгийг мэддэг миний хувьд тавган дээрх зүсэм мах айдас, зовлон, үхлийг илтгэж байдаг. “ Тэрбээр одоо 71настай хэдий ч цагаан хоол илүү их эрч хүч түүнд өгдөг гэж үздэг. “ 1986 оноос хойш би илтгэл тавих, уулзалт цуглаанд оролцох, улс төрчдийг ятгах, багшлах гэх мэт ажлуудыг жилийн гурван зуун хоног хийж аялсаар ирсэн. Нэг газарт гурван долоо хоногоос багагүй хугацаагаар, ихэвчлэн цөөн хэдэн хоногийг өнгөрүүлдэг байсан. Үнэнийг хэлэхэд 30 настайдаа хийж чадахгүй байсан зүйлээ одоо хийж чадаж байгаа нь махыг хаясаных юм гэж би бодож байна. “Борлуулалтаараа Тэргүүлэгч” болсон номнуудынхаа нэгэнд өөрийн дотоод ертөнцөө олон нийттэй хуваалцаж, их эрч хүч нь хаанаас ирдэг, яагаад ийм амгалан тайван байдаг тухай сонирхсон хүмүүсийн асуултанд хариулжээ. Энэхүү номондоо нэгэн удаа сүмд байх үед төрсөн мэдрэмжээ дурьдсан байдаг. Тэрээр дотоодынхоо дуу аялгууг олж сонсоод мөнхийн тайвшралын байдлыг мэдэрчээ. Энэхүү дотоодын ахуй ойлголт болон бусад дотоодын дуу аялгуу нь түүнийг Бурханы хүчтэй холбож, амьтны аймагтай зөв зохистой холбоо харилцааг тогтоох хэрэгтэй гэсэн санааг хүн төрлөхтөнд хүргэгч Бурханы илчээр ажиллах урам зоригийг өгдөг гэдэгт тэрээр итгэлтэй байдаг. Түүний Бурханд итгэх чин итгэл, бүгдийг хайрлах цэвэр ариун сэтгэл зүрх нь дэлхий ертөнцийн төлөө өөрийгөө зориулахад нь тус дэм болдог аж. Энэхүү номыг уншсанаар түүний эрдэм шинжилгээний ажил, оюунлагийнх нь аялал дахь гэгээрсэн ойлголтуудын талаар олж мэдэж болох юм.

Жэйн Гүүдоол нь Бурханд чин итгэл сүсэгтэйгээсээ болж дэлхий ертөнцөд нөхцөл болзолгүйгээр үйлчилдэг, хайр энэрэл, эр зоригтой, төлөв даруу эрхэм сайхан хүний тод жишээ юм. Хэдийгээр зарим үед энэ амьдралын бодит байдалд гутрах үе гардаг ч эх дэлхийгээ илүү сайхан газар болгохын төлөө, ирээдүйдээ итгэх итгэл найдварын галыг түгээхийн төлөө зүтгэсээр иржээ. Түүний хичээл зүтгэл үр өгөөжөө өгч, ашгийн бус Жэйн Гүүдоол институт нь эрүүл экосистемүүдийг бий болгон, тогтвортой амжиргааг сурталчлах замаар бүхий л амьтны сайн сайхны төлөө өөрчлөлт хийхэд нь дэлхийн олон хүмүүст хүч чадал хайрлаж байна.

Маккавой болон Гэйл Хадсоны “Итгэл найдварын учир шалтгаан”, Жэйн гуудвал Филлип Бернаны хамт

Мартсаныг сануулагч диваажингийн цэцэрлэг

Авшигтан Жэйн Роуз Майнер, Мичиган, АНУ (Англи хэлээр)





Номын зохиогч Др.Томас Виллиам



Др.Томас Виллиас

Нью-Иорк хотын нэгэн эмч - фермер өөрийн мэдлэгийг энэрэл нигүүсэлтэй хослуулан, улмаар хүмүүс болоод амьтдын аж байдлыг дээшлүүлэхэд чиглэсэн шинэ зүйл санаачлан ажиллаж байна. Асрамжийн газрын захирал Томас Виллиам Нью-Йоркийн Шервүргийн 103 га газартай фермд ажиллаж байхдаа амьтан хийгээд настангуудад туслах боломжийг олж мэджээ.

Тэр өөрийн ур ухааныг дайчлан зүлгийг амьд цэцэрлэг болгон засаж янзалснаар ахмадууд шинэхэн түүсэн жимс ногоогоор хооллож үзэсгэлэнтэй сайхан цэцэрлэгийн орчинд баясах боломжтой болжээ. Тэрээр өндөр настан бүрд жижигхэн тоть шувуу бэлэглэж, тэднийг муур нохой, зүлэг ногоотой асрамжийн газартаа нүүлгэн суурьшуулжээ. Томас “Амьтад ч бидэнд ойлгуулж чадахуйц тун чухал зарим зүйлийг хүмүүс харин мартжээ” гэж хэлдэг нэгэн. Энэ асрамжийн газар халдварыг 50% бууруулж, ахмад настан бүрийн өдөр бүрийн эмний төлбөрийг 71%-иар багасгаж, асрагчийн эргэлтийг 26% бууруулсан ололттой байгааг Нью-Йоркийн Эрүүл мэндийн газрын судалгаа харуулжээ. Энэ нь “Диваажин” гэмээр анхны асрамжийн газар болсон бөгөөд Виллиам Томаст Америкт 300, гадаадын орнуудад 200 “Диваажин” буюу ашгийн бус асрамжийн байгууллага байгуулах зөвшөөрөл өгчээ.

Enjoying a "family-style" dinner.



Мөрөөдөгч, уран төсөөлөгч, ухаалиг удирдагч Томас асрамжийн газруудын тусгаарлагдмал байдлыг бүрэн өөрчилж, дүнсгэр байгууллагыг хөгжүүлэн дэвжүүлж, сүр жавхаатай, гэр бүлийн уур амьсгалтай болгож байна. Томас Виллиамын өөр нэгэн шинэчлэл бол бүх насныхны "Зорилтот нэгдэл" бүтээл юм. Тэрээр "Бид ахмадуудаа нийгмийнхээ гол төвд буцаан аваачих юм бол бүх насны хүмүүс улам сайхан амьдарна" гэж хэлдэг бөгөөд энэ халамжтай, эрч хүчтэй эр ахмадуудын зүрх сэтгэлд нь энэрэнгүй нийгмийг буцаан аваачиж байх шиг санагдана.

Нэмэлт мэдээлэл:
http://www.usnews.com/usnews/biztech/articles/060619/19leader.htm
http://www.eldershire.net/Vision/WillamThomas.php
http://www.edenalt.com/

Амьтан дээр хийдэг туршилт

Сан Мин Чен, Тасман Австрали (Англи хэлээр)

Анагаах ухааны эмч нарын хороо орчин үеийн технологийн зориулалтаар хийх 675 хархны амийг химийн үйлдвэрийн туршилтаас аврах хөтөлбөрийг санаачилсан явдалд талархал илэрхийлж байна. АНУ-ын Засгийн газар 1000000 фунт /450г/-ээс дээш органик, полимер бус химийн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх буюу импортоор оруулахыг зөвшөөрдөг.

Энэ оны гуравдугаар сарын эхээр Dow химийн компани хээлтэй хархнуудын арьсанд нь химийн бодис түрхэж туршилт явуулсан бөгөөд зулзгалсаны дараа эх зулзага хоёул үхжээ.

Энэ туршилтыг химийн бүтээгдэхүүн хөхтөн амьтны үржил хөгжилд ямар нөлөө үзүүлдэгийг судлах зорилгоор хийсэн байна.

Анагаах ухааны эмч нарын хорооны шинжээч нар химийн бүтээгдэхүүн хархны арьсанд нэвчсэн эсэхийг тогтоохын тулд эхлээд амьд бус загвар ашиглах саналыг Dow компаний мэргэжилтнүүд хүлээж авсан бөгөөд амьд амьтанд туршилт хийхийн оронд орчин үеийн компьютерийн технологийг ашигласан байна. Компьютерийн судалгаа нь химийн бүтээгдэхүүн амьтны арьсанд их хэмжээгээр шингээгүй учраас тэдний үржилд нөлөөлөхгүй болохыг харуулсан юм.

Энэ санаачлага бүгдэд нь ач тустай хэрэг болов. Dow компани шаардлагагүй туршилтанд хий дэмий хөрөнгө мөнгө, хүч хөдөлмөр зарахаас сэргийлж, мөн олон хархны амь насыг аврав.

Анагаах ухааны эмч нарын хороо нь 1985 онд АНУ-д байгуулагдсан ба эмнээс зайлсхийх, эмчилгээний судалгаа явуулах болон судалгааны үр дүн, ёс зүйд өндөр жишиг тогтоохыг хөхүүлэн дэмждэг ашгийн бус байгууллага юм. Энэ хороо нь шилдэг их сургуулиудтай хамтарч ажилладаг, өндөр мэргэжлийн эрдэмтэн судлаачид болон санхүүжүүлэгч нараас бүрддэг. Вэбсайт /WWW.PERM.ORG/ нь тэдний явуулсан сонирхолтой судалгаануудаар дүүрэн байдаг бөгөөд анагаах ухааны тогтсон сэтгэлгээний тулхүүрийг өөрчилж цоожийг нь мулталж чадсан юм. Тэд цагаан хоол, дан ногоогоор хооллохыг дэмждэг, ургамалд суурилсан хоололтын хэлбэр нь урт удаан эрүүл амьдралын үндэс гэж үздэг байна. Тэд мөн амьтан дээр судалгаа хийх хандлагыг өөрчлөхийг сурталчилж, цуст туршилтуудыг болиулахаар чармайн ажиллаж байна. Одоогоор АНУ-ын анагаах ухааны бүх сургуулиудын дөрөвний гурваас илүү нь амьтны лабораториудыг татан буулгаад байна.

The website of PCRM is full of interesting information.

«Бусдад туслахгүй юм бол бид хэн юм бэ?»

Флоридагийн мэдээний групп (Англи хэлээр)

Академийн шагналт жүжигчин эмэгтэй Анжелина Жюли ❤❤❤❤❤ бол хүний эрхийг идэвхитэй хамгаалагч билээ. Камбучид "Булш тоногч" киноны зураг авалтын үеэр түүний энэрэн нигүүлсэх сэтгэл ундран гарчээ. Ядуурал болоод дайны хор уршгаас үүдсэн үгүйрэл



сүйрлийг мэдэрсэн тэрээр НҮБ-д хандаж хэрхэн тус хүргэж чадахаа мэдэхийг хүсчээ. " НҮБ-ийн хийхээр оролдож буй зүйлд итгэдэг болохоор НҮБ-ын Дүрвэгсдийн Дэд Хороонд би хандсан юм…. Тэгээд ч би НҮБ-ыг дэмждэг. НҮБ-ын хөтөлбөрүүдтэй танилцсаны үндсэнд НҮБДДХ хамгийн илүүтэйгээр анхаарлыг маань татсан юм. Учир нь дүрвэгсэд бол дэлхий дээрх хамгийн эмзэг хүмүүс гэж би боддог. Тэд бүхий л зүйлд өртдөг. 2001 онд Сири, Танзан, Пакистан (Афганистаны дүрвэгсдэд 1сая ам доллар хандивлав) дахь дүрвэгсдийн хуаранд зочилсоны дараа НҮБДДХ-ны сайн дурын элч төлөөлөгч болсон. Тэр цагаас эхлэн дайны хөлд нэрвэгдсэн Гайти, Косово, Ливан, Шриланка болон Судан зэрэг орнуудаар аялан дүрвэгсэдтэй уулзаж тэдний бэрхшээл зовлонтой байдлыг бусдын анхааралд хүргэжээ. Жюли хүмүүнлэгийн даалгаваруудыг гүйцэтгэх үедээ НҮБ-ын тусламжийн ажилтнуудын яриа, дүрвэгсдийн аймшигт түүх болоод хуаранд очих үед өөрт төрсөн сэтгэгдлийнхээ талаар тэмдэглэл хөтөлдөг байв. 2003 онд дээрх тэмдэглэлүүдийн заримаас Миний аялалын тэмдэглэл - нэрээр ном хэвлүүлж олсон бүх ашгаа НҮБДДХ –нд хандивлажээ.

Жюлигийн хувьд энэ нь ер бусын зүйл биш юм. Тэрээр олон саяар хэмжигдэх орлогынхоо гуравны нэгийг буяны үйлсэд зориулдаг байна. Жүжигчин хүний чөлөө завгүй ажлын хажуугаар дүрвэгсдийн хуарангуудаар айлчлахын зэрэгцээгээр өөрийн цаг зав, эрч хүч, мөнгөө дэлхий дээрх дэвшилтэт төслүүдэд зориулдаг. Тэрээр " Миний хувийн үзэл бол өөрт байгаагаа хэрэгцээтэй хүнд нь өг" гэдэг нь хоосон яриа биш юм хэмээдэг.

Зөвхөн 2005 оны байдлаар тэрээр:

- Этиопийн ДОХ-той өнчин хүүхдүүдэд зориулсан эмнэлэгийг дэмжихээр амлав;
- АНУ-д орогнол хайж буй хүүхдүүдэд хууль зүйн тусламж үзүүлэхэд зориулж 5сая ам долларын тусламж амлав;
- Кампучи, Баттамбанд дархан цаазат газар байгуулахад нь 5сая ам долларын тусламж амлав;
- Гайти дахь нэгэн сургуульд 500,000 ам долларын тусламж бүрдүүлж өгөв;
- Кенийн тогтвортой хөгжлийг дэмжих хүрээнд эдийн засгийн ухааны Доктор Жеффеританй хамтран баримтат кино бүтээв;
- Пакистан дахь Афганистаны дүрвэгсэд болоод газар хөдлөлтөд нэрвэгдэгсэдтэй очиж уулзав
- Дэлхийн хэмжээнд боловсролыг үнэгүй олгохыг дэмжих хүрээнд АНУ-ын сенатор Хилари Клинтон, Английн канцлер Гордон Браун нартай хамтран ажиллав.

Тэрээр бага насны гурван хүүхдийн ээж. Саяхан төрсөн бага хүүхэд нь Брэд Питт, ❤❤❤❤❤ Жюли нарынх, харин бусад хоёр хүүхдийг үрчлэж авсан. Хүү Мэддоксийг 2001 онд Кампучийн хүүхдийн асрахаас, охин Захараг 2005 онд Этиопи дахь ДОХ-ын халдвараас эцэг эхээ алдсан хүүхдийн асрах газраас тус тус үрчлэн авчээ. Охин Захараг үрчлэхдээ ДОХ-ын халдвартай эсэхийг мэдэхгүй байсан ч түүний хувьд охинд эхийн хайр хэрэгтэй байсан нь л чухал байлаа. ДОХ-ын халдвартай байсан ч тэрээр түүнийг өсгөхийг хүсч үүндээ бэлэн байв. (Захара Бурханы авралаар эрүүл байжээ.) Захараг өөрийн гэр бүлийн гишүүний нэг болгосон тэр үеэс эхлэн Этиопоос АНУ-ын иргэд хүүхэд үрчлэн авах нь үлэмж нэмэгдсэн бөгөөд олон зуун балчир хүүхдүүд гэр бүлтэй болж аз жаргалтай амьдарцгааж байна. Анжелина Жюлигийн энэрэнгүй сайхан үйлс нь олны дунд сайшаагддаг. Өөрийн хүмүүлэгийн ажлын талаар тэрээр өгүүлэхдээ “ Сурч боловсорч бусдын төлөө чадах бүхнээ хийхээ, энэ үйлсэд нэгдэж байгаагаа илэрхийлэн дэлхийн өнцөг бүрээс ирүүлсэн залуусын захиа нь миний хувьд хамгийн дээд шагнал юм. Тэд ирээдүйдээ итгэх итгэлийг надад өгдөг.”

Өөрийн нэр нөлөөг бусдын амьдралыг дээшлүүлэхийн төлөө зориулдаг . Дүрвэгсэд, гамшигт нэрвэгдэгсэд, ядуурлын эсрэг тэмцэж буй гэр бүлүүд бүгд түүний нөхцөл болзолгүй хайр энэрлийг мэдэрцгээжээ. Хийсэн бүхнээрээ бахархах бүрэн үндэстэй ч Жюли ерөнхийдөө даруу хүн юм. Сонин сэтгүүлд өгсөн ярилцлагандаа зовж шаналсан ахан дүүсийнхээ амьдралаас олон зүйлийг ухаарснаа байнга онцлож хэлдэг. Бусдад тусласнаар үнэндээ бид өөрсдөдөө туслаж байдгийг тэрээр сайн ойлгодог. НҮБДДХ- ын элч төлөөлөгчийн ажил түүний амьдралыг хэрхэн өөрчилсөн талаар асуухад тэрээр “ Ажил маань амьдралыг минь зорилготой болгож өгсөн. Бусдад туслахгүй бол бид хэн юм бэ?” гэжээ. Ажелина Жюлигийн ачаар олон хүмүүс энэ асуултыг өөрөөсөө асууж байна. Эрхэм уншигч та өнөөдөр хэн нэгэнд тус хүргэсэн үү?

Дэлгэрэнгүйг:
http://www.unhcr.org/cgi-bin/texis/vtx/news/opendoc.htm?tbl=NEWS&id=3db3f99b5
http://www.unhcr.org/cgi-bin/texis/vtx/news/opendoc.htm?tbl=NEWS&id=3bb2f8be16
http://abcnews.go.com/GMA/story?id=1120954&page=2
http://edition.cnn.com/TRANSCRIPTS/0512/26/sitroom.01.html
http://abcnews.go.com/GMA/story?id=1120954&page=2
http://news.bbc.co.uk/1/hi/talking_point/3584021.stm

Хязгааргүй эрчим хүчний хөгжил

Номын ах Мэтью Сирпис .Тасман Австрали (Англи хэлээр)

Стерн хэмээх Ирландын компани чөлөөт энерги үйлдвэрлэдэг шинэ систем нэвтрүүлээд байна. Энэ систем нь түлш шатахуун хийлгүйгээр, юу ч шатаалгүйгээр үнэгүй гэрэл, дулаан ялгаруулдаг бөгөөд машин болон гар утас зэрэг цахилгаан шаардагддаг бүх хэрэгслүүдийг эрчим хүчээр хангадаг.

Энэ технологи нь физикчид, компанийн ажилчдын хамтын бүтээл юм. Энэ нээлт нь физикийн гол хуулиудын нэг болох ”Энерги үүсч бий болохгүй, мөн устаж үгүй болохгүй, зөвхөн хэлбэрээ өөрчилдөг“ гэсэн Энерги хадгалах хуультай зөрчилддөг. Уг технологи компанийн 2003 онд эхлүүлсэн “Сайн бичил трансформатор” төслийн хүрээнд бий болсон юм. Төслийн эхэн үед компани хүч чадлаа зуун хувь ашигтай ажил болгох трансформатор нээсэн бөгөөд энэ нь зарцуулснаасаа илүү энерги ялгаруулдаг гэсэн үг юм. Энэ технологийг улам хөгжүүлсээр байна. Одоогоор Стерн компани бүтээлүүдийнхээ үр дүнг Шинжлэх ухааны нийгэмлэгээр батлуулахаар ажиллаж байна. Шалгууруудыг тогтоох туршлагатай, мэргэжлийн арван хоёр шүүгчдийн бүрэлдэхүүн, сорилт шинжилгээг хянах, үр дүнг нь нийтэд зарлах сорилтын төвүүдийг шалгалт сорилт хийлгэхээр урьж байна гэсэн зар сурталчилгааг Эдийн засгийн сэтгүүлд нийтлүүлээд байна. Тус компанийн гол бэрхшээл бол олон нийтэд ийм технологи аль хэдийн бий болчихоод байгааг итгүүлэх явдал юм байна.

Disclosure Project /Нээлт/ хэмээх АНУ-ын Засгийн газар, Тагнуулын газрын 400 гаруй цэрэг армийнхнаас бүрдэх чөлөөт энерги оршдогыг батлахаар оролдож буй өөр нэгэн бүлэг нисдэг биет, бусад технологид хийсэн туршилтуудаа нотлохоор оролдож байгаа ч мэдээллийн нууцаа хадгалж байгаа юм. Америкийн Засгийн газрын энэ бүлэг нь харь гаригийнхнаас чөлөөт энергийн технологийг олж авсан гэх ба үүнийгээ олон нийтээс нууцалж байна. Энэ багийнхан дэлхий нийтэд тулгараад байгаа байгаль орчны асуудлыг шийдвэрлэхэд тус болох зорилгоор энэхүү технологийг олон нийтэд ил гаргахыг эрмэлзэж байгаа юм. Тэдгээр 400 хүн туршилтуудаа видео хальсанд буулгасан ба АНУ-ын Засгийн газарт гэрчлэн батлахыг зөвшөөрөөд байгаа юм.

Дээрх мэдээлэлүүд нь Их Багшийн Флорида, Лондоны бичлэгүүдэд дурдсан “Бид удахгүй энергийн өөр эх үүсвэрүүдтэй болно, цахилгаанд найдах шаардлагагүй болно. Дэлхий маань Алтан Үед дэвшиж, гаригийн маань ухамсар дээшилж, технологийн шинэ чиг хандлага бий болж, бидний мэддэг дэлхий тэс өөр болох болно” гэж айлдсантай тохирч байгаа юм.

Дэлгэрэнгүйг:
http://www.disclosureproject.org/
http://www.steorn.net
http://news.yahoo.com/s/afp/20060818/bs_afp/irelandscienceenergy
http://www.firstscience.com/site/editor/0156_ramblings_14092006.asp

Өөрсдийнхөө төлөө болон хойч үедээ зориулан *Мөнхийн диваажинг* бий болгох нь

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, 1992 оны 3-р сарын 3
Сингапур, (Англи хэлээр) Видео хуурцаг № 223

Хэрвээ хүмүүс дор бүрнээ Библид тэмдэглэснээр амьдарч, Дотоодын Бурханаа харж, Эзэн Бурханы буюу Диваажингийн Гэрлийг олж үзэн, Аялгууг сонсож, Эзэн Бурханы үгийг сонсож, Бурхан Чанараа таньж мэдвэл дэлхий ертөнц маань тэр чигээрээ Диваажин болж хувирахсан. Дотоодын Гэрэл, Аялгуу маань биднийг Гэгээнтнүүд, мөн Бурхад болгож байдаг билээ. Бурхадын амьдардаг ертөнц бол Нирваан. Гэгээнтнүүдийн амьдардаг ертөнц бол Диваажин юм.

Эзэн Бурханы хүчинд оршихуй

Манай дэлхийгээс өөр зөндөө олон диваажинлиг гараг ертөнц байдаг ба оршин суугчид нь Эзэн Бурханы таалалд багтаж, бүхий л хүсэл мөрөөдлөө биелүүлэн өөрөө өөрийнхөө эзэн нь болж энх амгалан, эв эетэй амьдардаг. Эдгээр гараг ертөнцөд зөвхөн сайн сайхан л гэж байдаг ба харин манай дэлхий дээр байдаг шиг муу муухай зүйл ер үгүй юм. Сансар огторгуйд зөвхөн манай дэлхий л дан ганцаараа оршдог юм биш. Дэлхийтэй төстэй маш олон гараг байдаг. Зарим нь манайхаас илүү соёлжсон, өндөр хөгжилтэй байхад зарим нь хөгжлөөр дорой буурай байх жишээтэй. Энэ бүхний талаар нэгд нэгэнгүй ярих цаг зав даанч алга. Тиймээс эхлээд өөрийнхөө гараг дэлхийн тухай ярилцацгаая. Илүү бодитойгоос гадна хамгаас чухал юм.

Хэрвээ та агаар мандал гэдгийг юу болохыг ойлгодог бол аливаа биет хөнгөн байх тусам дээшилж хөөрч байдаг. Агаарт халуун дулаан хурдан дэгддэгийн адилаар хөнгөн биетүүд агаар мандлын дээд давхарга руу тэмүүлж байдаг байх нь. Харин жин ихтэй, хүйтэн байх тусам хүндийн хүчнээс болоод ч тэрүү агаар мандлын ёроол хавиар тогтдог.

Хэлбэлзлийн өндөр давтамжтай байхыг хичээ

Үүнтэй нэгэн адилаар сайн сайхан их ч бай, бага ч бай муу муухайгаас үргэлж давж байдаг. Сайн, муу холилдон оршдог манай дэлхий дээр ч ялгаагүй сайн нь муугаа дийлдэг жамтай. Гэхдээ энэ нь бид муу муухайгаас чөлөөлөгдсөн гэсэн үг биш юм. Хөршүүдээсээ болоод ч юм уу, доройтох үедээ гэхчилэн муу муухайтай зууралдаж байдаг. Бусад ертөнцөд зөвхөн сайн сайхан л гэж бий. Тэдгээр ертөнцийг Диваажин буюу Эзэн Бурханы Хаант улс гэж нэрлэдэг. Хэрвээ бид бие сэтгэлээ цэвэр ариун байлгах буюу Диваажингийн орны ариун сүнснүүдтэй адил хэлбэлзлийн давтамжинд оршиж чадах юм бол Диваажинд хүрч чадах буюу тэнд зочлон очих ч боломжтой болно.

Тиймээс Эзэн Бурханы Оронд бясалгах буюу Нирваан дүрийг олно гэдэг нь домог бус харин туйлын тодорхой бөгөөд шинжлэх ухааны үндэстэй амьдралын хэв маяг юм. Ийнхүү амьдрахыг хүсвэл хэцүү юм үгүй. Энэ бол бидний сонгох амьдрал мөн билээ.

Өдөр бүр түр зуур ч болов Диваажинг цогцлуул

Эзэн Бурхан энэ дэлхийд ядуурлыг бий болгоогүй. Эзэн Бурхан тамыг бий болгоогүй. Харин хүмүүн бидний гаргасан алдаа, хоорондын харьцаа болон шийдвэрлэх мөчид муу үйлдлийг сонгосон зэргээс болж тамыг бид өөрсдөө бий болгосон юм. Тиймээс одоо сайтар бодож цэгнэн Диваажинг цогцлуулж, ядахдаа түр зуурын Диваажинг бий болгож жаахан ч атугай амарч болно. Тэгвээс энэ дэлхийн зовлон шаналалаас түр ч болов ангижирч, хойшид яахаа бодож тунгаан, энэ дэлхийд дахин төрөх үү яахав, хамгийн тэнгэрлиг Диваажинд очих уу гэдгээ шийдэх боломжтой болох юм. Хүмүүн бид сайн үйлс бүтээж, Эзэн Бурхандаа итгэж, залбирал үйлдэж, гэм буруугаа чин сэтгэлээсээ хүлээж гэмшин, өөрт болон нийгэмд хамгийн тустай юу байна, тэр бүхнийг хийхийг оролдож, чадах чинээгээрээ цагаан хоолтон болох аваас түр зуурын Диваажинг цогцлуулж чадна. Би та нартаа мах орлуулагч болох Дүпүг санал болгох байна. Хямд төсөр, хурдан шингэцтэй, үйлийн үр хөнгөнтэй, нүгэл ч багатай. Үйлийн үр гэдэг та юу тарина, түүнийгээ хураах буюу үйлдсэн хэргийнхээ шийтгэлийг хуулийн дагуу амсах гэсэн үг юм. Тэгэхээр одоо та нар өөрийнхөө төлөө түр зуурын Диваажинг цогцлуулна биз ээ.

Цагаан хоолтон болох нь эх дэлхийгээ аврах хамгийн зөв шийдэл

Бид чадах чинээгээрээ л цагаан хоолтон байхыг хичээдэг. Цагаан хоолтон байна гэдэг зөвхөн ариун амьдрал гэгдээд зогсохгүй бүр эх дэлхийгээ өлсгөлөн, ядуурлаас аврах нэгэн гарц юм. Үүнийг батлах олон судалгаа бий. Хүний гараар бүтээгдсэн болон байгалийн бэлэн бүтээгдэхүүн, байгалийн нөөц баялагийг үхэр, гахай тэжээхэд дэндүү их хэмжээгээр үрж зарцуулж байна. Ганц гахайг хэмжээлшгүй их эм тан, уурагт тэжээл, шош, бүх төрлийн хүнсний ногоогоор удаан борддог. Тэгэж тэжээсэн гахайгаа бид маш хурдан, удлаа гэхэд тавхан минутанд идээд барчихдаг. Зарим хүнд бол ганц минут л хангалттай байх!

Бид зөвхөн ариун хүмүүс байхын тулд бус харин эх дэлхийгээ аврах гэсэн чин эрмэлзлийн үүднээс цагаан хоолтон байгаа билээ. Манай дэлхийн зарим хэсэг ядуурал автаж өлсгөлөнд нэрвэгдээд байгаа нь хүмүүн бид бие биеэ аврахын төлөө хамтран ажилладаггүйн хар гай юм. Мэдээж олон буяны байгууллага тусламжийн гараа сунгадагт эргэлзэх зүйлгүй. Гэвч энэ бол асуудлын үндэс нь биш. Зөвхөн африк, азийн зарим нэг оронд хоол хүнсний гачаал бий болсон юм

биш. Хоол хүнсний дутал цэвэр махан хүнстэй холбоотой. Өөрөөр хэлбэл технологийн хөгжил болон бусад оюуны хөрөнгө оруулалт нь дэлхийн хүн амд нийцтэй хувь хандив оруулахад бус, хүн амыг аливаа уурагт хүнсээр хангахад бус, харин мах бий болгоход л үрэгдэж байна.

Эрдэмтэд цагаан хоолтон байх нь эрүүл мэндэд ашиг тустайг аль хэдийн судалж нотолсныг та нар мэднэ. Бүх эмнэлэгийг хэний төлөө барьсан гэж? Мах идэгсдэд зориулж! Эмнэлэгт хэвтэж буй өвчтний дийлэнх нь махан хоолтон байдаг. Бид өөрсдийгөө хороор хооллоод байвал эцэстээ эмнэлэгийн тоног төхөөрөмжинд найдахгүй гээд яах билээ. Бид ийнхүү өөрсөддөө давхар гай удаж үйлээ үзэж байдаг.

Ариун амьдралаар амьдарч Алтан үеийг бүтээцгээ

Зовлонгийн үндсийг мөчир мөчрөөр тастах биш харин үндсээр нь суга татан хаях ёстой юм. Дэлхийд тулгараад буй өлсгөлөнгийн асуудал нь тусламжийн шугамаар юмуу жаахан хоол хүнс хандивласнаар шийдэгдэх юм биш. Асуудлын үндэс нь бид бүгдэд л байгаа. Тиймээс бид бүгдээрээ туслах ёстой. Өөрсдийнхөө жаахан ч атугай энергийг мөн дэлхийн нөөц баялагийг хойч үе, ах дүүдээ үлдээх ёстой. Хөгжил буурай орнууд уураг, аминдэмээр баялаг бүтээгдэхүүнээ хөгжилтэй оронд үхэр гахайгаа тэжээхэд нь ч зориулж зарж худалдаад өөрсдөө өлсөж суудаг. Үүний оронд бид харилцан тэнцвэртэй хуваалцан амьдрах ёстой бус уу,

Мэдээж, би улс төрч биш л дээ. Харин өөрийнхөө хүч чадлын хэмжээнд, өөрийнхөө арга хэлбэрээр асуудлыг шийдвэрлэх тухай л хэлж өгч туслах байна. Дэлхийн төр, засгийн удирдлагууд өөрийн улс орноор зогсохгүй хэрэв бүх улс үндэстнүүдийн сайн сайхан аж амьдралын төлөө гэсэн сэтгэлтэй бол хамтарч ажиллах хэрэгтэй. Гэхдээ бас өөрийнхөө улс орныг аятайхан аваад явчхаж байгаа нь авууштай тал юм. Ямар ч улс орон цэвэр цэмцгэр, гэгээлиг, хоорондоо эв этэй амьдарч, хөгжиж цэцэглэж байгааг харахад надад үнэхээр сайхан байдаг. Жишээ нь, Сингапур байна.

Бид Загалмайтан, Бурханы шашинтан, Хинду нар шиг амьдарч Алтан үеийг цогцлуулж чадна. Хүмүүжилтэй, ёс суртахуунтай байж, хөршүүддээ чадах чинээгээрээ тусалж, эх дэлхийнхээ хөгжил цэцэглэлийн төлөө өөрсдийнхөө зарим нэг хүсэл мөрөөдөл, эд баялагийг золиосолж, бусад номын ах эгч нартаа хэрэгтэй зүйлээр нь тусалж болно.

Хойч үеийнхээ төлөө бодох нь

Иймэрхүү маягаар бид ирээдүй хойч үеийнхээ төлөө улс үндэстнээ сайн сайхан авч явах гэж хүч чармайлт гаргадаг. Хожоо мэдээж байнаа. Учир нь үр хүүхэд, ач зээ, үеэлүүдэд маань ч ашиг тус нь ногдоно. Зарим нь магадгүй ингэлээ гээд яах ч билээ дээ, тэртээ тэргүй үхээд өгөх юм чинь, ашиг тусыг нь хүртэхгүй шүү дээ гэж бодох хэрэггүй. “Үр хүүхдэд маань хэрэгтэй. Үр хүүхэдгүй байлаа ч иймэрхүү өчүүхэн сэтгэлэн байж таарахгүй. Биднийг зүтгэж байгаад явсны хойно хойч ирээдүй маань хичнээн эв этэй, элбэг хангалуун амьдарна гээд төсөөлөөд үз дээ. Бид материаллаг ашиг хонжоо олохгүй ч сэтгэлийн баяр цэнгэл эдлэх биш үү. Энэ бол жинхэнэ боловсон хүний шинж, энэ бол хэдэн мянган жилийн тэртээгээс Лууз, Күнз, Бурхан Будда болон Исүс Христ зэрэг гэгээнтнүүд хүн зонд хэлж, зааж сургах гэж оролдсоор ирсэн эрхэм чухал зүйл юм.

Би та нарт цоо шинэ зүйл номлож байгаа юм биш. Энэ бол бидний зарим нь таг мартчихсан буюу иймэрхүү амьдралын замналыг дагах гэж хэзээ ч оролдоогүй болохоор хэрхэхээ мэдэхээ больчихсон тэр зүйл байгаа юм. Гэхдээ бид өнөөдөр ч бай, маргааш ч бай дахин оролдоод үзэж болох бөгөөд юмс хэрхэн өөрчлөгдөж, бидэнд ч илүү сайхан мэдрэмж төрж, улс орнд маань болон газар дэлхийд хичнээн ашиг тустайг нь биеэрээ харж болно.

Хоол хүнсээ өөрчлөн энэрэл нигүүслийн замд орохуй



Цагаан хоолизмыг санаачлагч Жон Роббинс

Гонгконгийн мэдээллийн баг (Хятад хэлээр)

Жон Роббинсийн "Шинэ Америкийн Хоол Хүнс" номонд энэрэнгүй хүнсэнд шилжсэнээр эрүүл чийрэг, аз жаргалтай, ирээдүйдээ итгэлтэй амьдарч болох тухай өгүүлнэ. "Цагаан хоол нь илүү эрүүл чийрэг болгоод зогсохгүй цаад утгаараа оршин буй байгаль орчноо хамгаалан, дэлхий ертөнцийг зовоож байгаа асуудлуудыг хөнгөвчлөхийг та харах болно" гэж уг номонд бичжээ.

Жон Роббинс Америкийн нэгэн чинээлэг гэр бүлд төржээ. Эцэг Ирвин Роббинс нь дэлхийн хамгийн том "Баскин Роббинс" мөхөөлдөсний компанийг үүсгэн байгууллагч, захирал нь байсан байна. Тэрээр айлын ганц хүү учраас гэр бүлийнхээ бизнесийг өвлөн авахад бэлтгэгдэж байлаа. Гэсэн хэдий ч өсөж том болоод баян чинээлэг амьдралаа орхин өөрийн зорилгоо дагахаар шийджээ. Эрүүл хүмүүс, эрүүл гаригийг бий болгохын тулд цагаан хоолыг хүмүүст ухуулахад амьдралаа зориулан "EarthSave" хэмээх ашгийн бус байгууллага байгуулж улмаар амьдралын мөн чанарыг тусгасан хэд хэдэн ном бичсэнээс "Шинэ Америкийн Хоол Хүнс" ном нь цагаан хоол, хүнс тэжээл, амьтдын амьдралын талаар бичсэн анхны бүрэн судалгааны ном болж чадсанаараа уншигчдын дунд ихэд алдаршсан байна.

"Бидний ихэнх маань хооллож суухдаа зоог маань дэлхий ертөнцөд хэрхэн нөлөөлдгийг ихэнхдээ ухамсарладаггүй. "Биг Мак" түргэн хоолны газруудад тэрбум бургерийг зарах бүрд дараагийн зуун төрөл зүйл мөхдөг болохыг бид ухаардаггүй. Бидний зооглож буй зүсэм шарсан мах амьтныг зовоон, хөрсийг гэмтээн, ой модыг огтчин, эдийн засагт хор хохирол учруулаад зогсохгүй бүр эрүүл мэндийг маань муутгаж байдгийг ойлгодоггүй. Хоол хүнсээр гачигчигдан уйлж буй сая сая хүмүүсийг хооллож ундлаж болохыг зүсэм махаа шажигнуулан зооглож байхдаа бид сонсдоггүй. Эдгээр түргэн хоолны газрын шүлжээнүүд хорт бодисын цуглуулгаараа бидний үр хүүхэд, дэлхий ертөнц, мөн ирээдүйд мэндлэх хойч үеийг маань хордуулж байдгийг бид хардаггүй" гэж уг номонд бичсэн бий. Жон Роббинсийн үг, түүний амьдрал нь дэлхий ертөнцийн олон хүнийг илүү энэрэнгүй, алсын хараатай амьдрахад нь урам зориг өгч байдаг.

Жон Роббинсийн талаар илүү ихийг мэдье гэвэл доорх вэб хуудсуудруу орж үзнэ үү:
http://www.earthsave.org/
http://www.ivu.org/people/writers/robbins.html



Энэтхэг Улс

Ариун зөв заншилтай оронг Эерэг Өөрчлөлт Сэргээж байна

Бомбэй хотын мэдээллийн баг (Англи хэлээр)

Энэтхэгийн сургуулийн сурагчид 1997 оноос хойш биологийн хичээл дээр амьтныг задлан шинжлэх эсэхээ сонгох эрх олгогдсон. Цагаан хоолтны нийгэмлэгийн өргөх бичгийг үндэслэн Дэли хотын шүүх энэ дүрмийг гаргасан юм.

Бүтээгдэхүүний шошгонд тэмдэглэгээ хийлгэх тухай Цагаан хоолтнуудын шаардлага

Цагаан хоолтнуудын шаардлагаар 2001 онд Энэтхэгийн Засгийн газар цагаан хоолтон ба ердийн хоолтой хүмүүст зориулсан тусгай таних тэмдгийг бүтээгдэхүүний шошгонд бичиж байхаар шийдвэрлэсэн юм. Одоо бүх төрлийн хүнсний бүтээгдэхүүний брэнд нэрний хажууд ногоон, бор өнгөтэй жижиг дугуй тэмдэглэгээ тавьдаг боллоо. Ногоон дугуй тэмдэг нь уг бүтээгдэхүүнд амьтны гаралтай аливаа хольц, тухайлбал сүү, цагаан идээнээс өөр зүйл ороогүй, мөн өндөггүй болохыг илтгэнэ. Бор дугуй тэмдэг нь тус бүтээгдэхүүн амьтны гаралтай болохыг заана. Ингэснээр цагаан хоолтон цагаа хэмнэх боломжтой болж, басхүү болгоомжлолоос ангижирсан юм. Энэхүү санаачлагыг цаашид бүх орны засгийн газар хэрэгжүүлээсэй гэж хүсч байна.

Энэтхэгт цагаан хоол болон амьтны гаралтай хүнсийг савлагаан дээр нь тэмдэглэж өгдөг бөгөөд ногоон дугуй нь цэвэр цагаан хоол болохыг заана.



Илүү мэдээлэл авах бол Энэтхэгийн Цагаан хоолтны нийгэмлэгийн доорх вэб хуудсыг сонирхоно уу.
http://www.bwcindia.org/veg_campaign/veg_campaign_details.htm#laws

Үхэр сүргийг хамгаалах хөдөлгөөн

Хинду шашны сүсэгтнүүд үхэр нядлахыг төрсөн эхээ егүүтгэхтэй ижилтгэж маш ноцтой гэмт хэрэг гэж үздэг. Энэтхэгийн зарим шашны урсгал, мал төхөөрдөг газрууд дээрх үзлийн эсрэг байдаг. Бомбэй хотод “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг тараалцсан манай багийн гишүүн, Махатма Гандигийн шавь Горакса Санчалан Самити сүүлийн 15 жилийн турш Деонер гээч мал төхөөрдөг газарт үхэр сүргийг хороохын эсрэг жагсаал хийж байгаа гэж ярилаа. Тэд уг нядалгааны газрын дэргэд жагсаал хийхээр таван хүнийг байнга томилдог байна. Заримдаа цагдаа нар тэднийг барьж, бичиг баримтыг нь бүртгэж шалгаад суллан явуулдаг гэнэ. Тэр хооронд дараагийн таван хүнийг жагсаал хийлгэдэг юм байна. Цуглааны нэг гишүүн “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг тайлбарлуулсны дараа олныг гуйн авч жижиг бөмбөрөө зүүгээд “Үхэр сүргийг хамгаалья” гэсэн бичиг малгайдаа зүүчхээд зурагт хуудас тараав.

Цагаан хоолтонд орон сууц олдох нь хялбар байдаг

Энэтхэгийн бизнес, санхүүгийн том төв болох 16 сая хүн амтай Бомбэй хотод махан хоолтой хүмүүст орон сууц олдохдоо муу байдаг. Энэтхэг улсад орон сууцыг нийгмийн гарал, шашин шүтлэг, тусгай нийгэмлэгүүд зэргийг харгалзан хуваарилах хууль байдаггүй ч тухайн хороололд орон сууц эзэмшихийн тулд заавал цагаан хоолтон байх ёстой гэж зарим хорооллын оршин суугчдын зөвлөл шаарддаг. Учир нь цагаан хоолны дэглэмийг хатуу баримталдаг олон арван дундаж давхрагын энэтхэг хүмүүс Гужрат, Ражистан зэрэг хөрш хотуудаас Бомбай хотод суурьшихаар нүүж ирдэг нь цагаан хоолтнуудын бүхэл бүтэн нийгэмлэг үүсгэхэд хүрдэг. Тэдгээр дүүргийн орон сууц эзэмшигчдэд цагаан хоолтнуудын төлж байгаагаас илүү их мөнгө амалсан ч зарахыг зөвшөөрдөггүй.

Оршин суугчдын бараг 98% нь цагаан хоолтноос бүрддэг бүхэл бүтэн хороолол, гудамж ч Бомбей хотод байдаг.

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

Төгс Гэгээрсэн Их Багшийн энэрэнгүй уриаг түгээхийн төлөө дэлхий нийтийн зүтгэл

Өөрөөр амьдарцгаая

Их Багш маань хүн төрөлхтөн, ан амьтанд дахин заналхийлж буй гэнэтийн тахал өвчнүүдийг харгалзан үзээд тэднийг нигүүлсэх чин сэтгэлийг урьдал болгож, улмаар эдүгээгийн эмтарианы хямрал, дэлхийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд эдгээрийн гол үндэс суурь болсон цагаан хоолыг дэлгэрүүлэх, ан амьтныг хамгаалахыг уриалсан "Өөрөөр амьдарцгаая" зурагт хуудасны загварыг өөрийн биеэр зохиож хүн төрөлхтөнд санал болгосон билээ. Их Багш бүх авшигтан, дэлхийн өнцөг булан бүрт амьдарч байгаа ах, эгч нарт энэхүү илгээлтийг сурталчлахыг зөвлөсөн юм. Эдүгээ бясалгагчид Их Багшийн хайрыг хуваалцахаар их хүч чармайлт тавин ажиллаж эхэллээ. Доорх мэдээллүүд нь уг ажлыг олон оронд хэрхэн дэлгэрүүлж буй талаар өгүүлэх болно.

Ирланд

Эзэн Бурханы Хайрын Далайд умбах нь

Анжелхолмын мэдээллийн баг (Ау Лак хэлээр)

2006 оны 7-р сарын 25-нд Шведээс ирсэн олон авшигтан Их Багшийн "Өөрөөр Амьдарцгаая" хайрын уриалгыг хуваалцахаар Ирландын нийслэл Режкевикийг зорин явцгаалаа

Ирланд бол дэлхийн хамгийн том галт уул оршдог арал юм. Тэгсэн ч энд 300,000 хүний гэр орон бий. Өндөр уулсаар хүрээлэгдсэн энэхүү байгалийн үзэсгэлэнт газар хүмүүст тав тух, аюулгүй байдлыг бий болгож байдаг юм.

Нутгийн авшигтангууд, тэдний гэр бүлийнхэн оролцож таван өдрийн дотор 20000 гаруй "Өөрөөр амьдарцгаая" зурагт хуудас, 200 хувь үлгэр дэвтрийг тараалаа. Хүчтэй салхилан, бороо орж байсан болохоор нутгийн оршин суугчид гудамжинд төдий л харагдахгүй байв. Тиймээс зурагт хуудсыг орон сууцных нь шуудангийн хайрцагт хийж

тараав. Олон орон сууц үүдний жижүүрийн ширээн дээр үлгэр дэвтрийг хүмүүст авахад нь харагдахаар тавихыг зөвшөөрсөн юм. Үлгэр дэвтэр, зурагт хуудсыг эмнэлэгийн хүлээн авах өрөөнд ч мөн тавьж сурталчилсан билээ.

Авшигтнууд Ирландын хамгийн алдартай Блию Лагуун амралт, жуулчлалын газарт очин жуулчид болоод нутгийн амрагчдад зурагт хуудсаа тарааж өгөв. Блию Лагуун бол ер бусын далайн гүний халуун рашаантай газар юм. Эзэн Бурханы бүтээсэн рашаанд амрангаа хайр энэрлийг нь улам мэдэрч Их Багшийн зурагт хуудсыг хүлээн авсан тэдгээр хүмүүс бол дэлхийн хамгийн азтай хүмүүс гэдэгт бид итгэлтэй байлаа.

Ирландчууд их нөхөрсөг хүмүүс юм. Тэд зурагт хуудсыг авангуутаа дуустал нь уншина, мөн хүүхдүүд ч гэсэн өөрийн гэсэн унших зурагт хуудастай болохыг хүсэж байв. Хаалганы өмнө зогсож байсан нэгэн тахир дутуу хүн зурагт хуудсыг уншиж дуусаад Их Багшийн талаар илүү ихийг мэдэхийн тулд түүний вэб хуудсыг заавал үзнэ гэж хэлж байна. Цагаан хоолтой зарим хүмүүс дэлгэрэнгүй мэдээлэл авахаар асууж лавлаж байв.

Ирландчуудын өмнөөс энэ сайхан орныг адисласан Их Багшдаа талархья.

КАЗАХСТАН

Төв Азид Эзэн Бурханы Ариун Хайрын үндсийг тарьсан нь

Авшигтан номын ах Лонг, Формоса, Тайпэй (Хятад хэлээр)

Алмати хот бол Төв Азид орших хамгийн нөлөө бүхий нийслэл хотуудын нэг бөгөөд 1997 оноос Казахстан улсын нийслэл болсон билээ. Би цагаан хоол дэлгэрүүлж, Эзэн Бурханы Ариун хайрын илгээлтыг түгээхсэн гэхдээ “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг Их газрын хятадаас Алмати хот хүртэл тараан аялахаар шийдсэн хэрэг. 2006 оны 3-р сараас

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

7–р сар хүртэл Шанхай хотод гурван удаа виз хүссэн өргөдөл өгч бүтэн 4 сар хүлээсний дунд 7-р сарын сүүлээр Бээжин дахь Казахстаны Элчин сайдын яаманд ярилцлаганд орох болов. Надад 20 хоногийн виз өглөө.

8-р сарын эхээр Алмати хотод ирмэгцээ зочид буудалд бууж, бүхнийг зохицуулж өгсөн Их Багшдаа талархлаа илэрхийлэхээр бясалгав. Гайхамшиг үнэхээр ар араасаа цуварсаар л! Нутгийн хүмүүс зөвхөн оросоор юмуу казак хэлээр л ярина. Англи хэлээр ойлголцох их төвөгтэй, Хятад хэлийг бол бүр санах ч хэрэггүй. Гэтэл маргааш өглөө эрт зочид буудлаасаа гарч ирмэгц нэгэн настайвтар таксины жолооч намайг хятад хүн болохыг таниад сайн биш ч хятадаар ярьж эхлэв. Энэ явдал намайг үнэхээр баярлуулсан. Жолооч маань 70 дөхсөн нэгэн. Тэрээр намайг хотын хэд хэдэн хятад хоолны газруудаар явч яван цагаан хоол захиалж өгч, надтай хамт цагаан хоол зооглон хүмүүстэй намайг холбож байлаа. Энэ бол эхний гайхамшиг байсан юм!

Цагдаа нар, иж бүрэн зэвсэглэсэн цэргүүд, мөн хамгаалалтын хүмүүс том, жижиг гудамжаар хаа сайгүй л харагдана. Би дэлгүүр, цэцэрлэгт хүрээлэн, хотын дүүргүүд, сүм хийд, Лалын шашины сүм гэх мэт олон газраар бүтэн долоо хоног явлаа. Би авч очсон орос хэл дээрх бүх зурагт хуудсаа тарааж дуусав. Зурагт хуудсыг авсан хүн бүр түүнийг анхааралтай уншаад хямгатай авч хадгалж байлаа. Хэн ч зурагт хуудсыг хаяж гээсэнгүй. Уг нь энэ хотод зурагт хуудас тараахыг хориглочихсон юм билээ. Энэ мэдээж хоёрдох гайхамшиг!

Тав дахь өдөр жолооч маань намайг нэгэн хятад хоолны газар авчирлаа. Би зоогийн газрын эзэнтэй сайхан яриа дэлгэн түүнд үлгэр дэвтэр, орос, хятад хэл дээр хэвлэсэн зурагт хуудас сэлтийг өгөв. Тэрээр даруй тус хот дахь манай Арьяабалын номын цогцсын гэр бүлийн нэгэн гишүүн болсон юм. Тэрээр дөхөм аргад суралцаад зогсохгүй өдөр бүр надад өөрийн гараар цагаан хоол хийж өгч байв. Энэ гурав дахь гайхамшиг болов!

Зурагт хуудсаа тарааж дууссан тул орос хэл дээр зурагт хуудсыг хэвлэх сонирхол бүхий хэвлэл мэдээллийн хүнтэй уулзуулж өгөхийг зоогийн газрын эзнээс хүсэхэд тэр тусалж, удалгүй хотын хамгийн нөлөө бүхий өдөр тутмын сонины сэтгүүлч, редактортай уулзах завшаан тохиов. Би тэднийг цагаан хоолонд урьж, Их Багшийн сургаалыг тэдэнд танилцуулж орос хэл дээр хэвлэсэн үлгэр дэвтэр өгсөн юм. Их Багшийн хайр тэдний зүрх сэтгэлд хүрч “Өөрөөр амьдарцгаая” илгээлтийг дэмжин олон нийтэд хүртээн бидэнд туслан хэвлэлийн бүтэн нүүрэнд хямд

үнээр хэвлэхийг зөвшөөрлөө. Мөн хоёулаа цагаан хоолтон болж дөхөм аргад суралцахаар зөвшөөрсөн нь дөрөв дэх гайхамшиг байлаа!

Тус улсад байх сүүлийн өдрөө би нөгөө зоогийн газар ажиллаж байсан Хятадаас ирэн Казахын Үндэсний коллежид сурж буй нэгэн эмэгтэй оюутныг урьж түүнд цагаан хоол, Аръяабалын номын цогцсын талаар танилцуулсан юм. Харин тэр дөхөм аргад суралцахыг чин сэтгэлээсээ хүссэнээр бид хоёр хагас цаг хамтдаа бясалгав. Ингэж миний аялалын хугацаан дахь дөрөв дэх Аръяабалын номын цогцсын үр соёолон ургаж эхэллээ. Энэ бол Их Багшийн зохицуулсан тав дахь гайхамшиг байв!

Би ийнхүү бараг мэдэхгүй шахуу байсан орондоо богино хугацаанд буюу ердөө 20 хоног байсан юм. Гэлээ ч Их Багш минь өөрийнхөө аугаа хайрыг бүх л зүг чигт таксины жолоочоор, Өөрөөр Амьдарцгаая зурагт хуудсаар, сонин сэтгүүлээр мөн дөрвөн “Арьяабалын номын цогцсын үрүүдээр” дамжуудан ургуулан дэлгэрүүсэн билээ. Хайрын үрүүд тэрхүү үзэсгэлэнт хотод урган соёолохыг бид бүгдээрээ харахдаа баяртай байх болно. Мөн тун удахгүй соёолсон үрүүд маань алим жимстэй сайхан модод болон ургана гэдэгт бид итгэлтэй байна.

БОЛГАР

Цагаан хоолны эринд алхан орцгооё!

Пловдивийн Мэдээллийн группээс (Болгар хэлээр)



Өөрөөр Амьдарцгаая” тараах хуудсыг олонд хүргэх нь бидний хувьд тогтмол үйл ажиллагаа боллоо. Хэзээ л чадна тэр үедээ гараад бүх л боломжтой арга замаар тарааж байна.

3-р Алтан Жилийн 6-р сарын 1-ний Хүүхдийн Баяраар Их Багшийн маань Хайр болон бидний амьтдыг хайрлах хайрын бэлэг тэмдэг болсон “Та Ийм амьдралыг сонгож болно” тараах хуудсаа агаарын бөмбөлгөн дээр тогтоож хөгшин залуу, ээж хүүхдүүд, хосууд гэх мэт янз бүрийн хүмүүст өдөр, оройн цагуудаар тараалаа. Үүнийг авсан ихэнх хүмүүс сонирхон асуулт асууж, их анхааралтай уншицгааж байв. Их Багшийн маань адислал тэдгээр хүмүүсийн сэтгэлийн гүнд нэвчиж цаашид үр жимс нь боловсроно гэдэгт бид итгэлтэй байна!

Түүнчлэн өнгөрсөн долоо, наймдугаар сарuudад Болгарын авшигтнууд тэнгисийн эрэг хавь болон алс холын уул нуруud, алслагдмал хот суурингуудаар аялж энэхүү тараах хуудсаа олонд түгээлээ. Түүнчлэн Болгарын Христийн шашны том баяр болох Виржин Мэригийн Өдрөөр ч бас түүний цогчин дуганы эсрэг талд тараасан юм. Хаа сайгүй хүмүүс бидэнд туслахыг хүсч тараах хуудсыг тараалцанаас гадна хамаатан садан, найз нөхөддөө өгөхөөр авч байв.

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

Олон хүнд яаж илүү үр дүнтэй, хурдан тараах янз бүрийн санаа бидний толгойд байнга орж байсан юм. Үүнээсээ бид улам ихээр урамшин, нөхцөл байдал болгоноос улам бүр биеэ дааж байлаа. Хэн бидэнд иим урам хайрлаж, хэн биднийг хамгийн жижиг зүйлийг ч мэдрэх мэдрэмжтэй болгов гэхээр мэдээж Их Багш, Их Багш дахиад л Их Багш маань байсан юм. Эх дэлхийгээ нигүүлсэнгүй, цагаан хоолтон гараг болгох энэхүү бурханлаг үйлсээр дамжуулан биднийг нүдэнд харагдахгүйгээр суралцуулан өдрөөс өдөрт дээшлүүлэн хөгжүүлж байдаг Их Багшийнхаа хурц билгүүн ухаан, хүч чадалд баярлалаа!

ПОРТЕ РИКА БОЛОН БАХАМАС

Багшийн айлдварын халуун дотно хариу

Миссүри, Нью-Жерси, Илиной-н Төвийн авшигтнуудын хамтын сурвалжлага (Англи хэлээр)

Гуравдугаар Алтан жилийн /2006/ 8-р сард Миссүри, Нью-Жерси, Пенсилван, Иллиной дахь Бясалгалын төвийн найман авшигтан Багшийн “Өөрөөр Амьдарцгаая” санамж уриаг авч, энэхүү үнэт айлдварыг Карибын арлуудаар тараахаар нэг баг болов. Бид Порте Рика болон Бахамагийн хоёр арлын аялалдаа гарахыг тэсэн ядан хүлээж байлаа.

Порте Рикад 8-р сарын 11-нд ирэхэд нутгийн авшигтнууд халуун дотно угтаж авсанд бидний сэтгэл их хөдөлж байсан ба тэд мөн байр сууц, унаа, энэрлийн тусламжаа бидэнд хайрласан юм. Хэдийгээр бид бүтэн өдөржин аялж ирсэн ч эрч хүчтэй байсан ба шууд л нутгийн авшигтнуудтай Порте Рика дахь Понсе хотын Бясалгалын төв уруу явлаа. Энэ бол бид бие биеэ харсан анхны уулзалт байсан ч Багшийн хайраар нэгдэн нийлж хамтдаа нэг хүн шиг ажиллав.

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

Порте Рикачууд бол маш эелдэг найрсаг хүмүүс. Гудамжинд санамж уриаг тарааж буй авшигтнуудыг хараад түүгээр явсан хүмүүс машинаа зогсоон байж хуудсуудыг авч байлаа. Цагдаагийн ажилтнууд хүртэл цонхоо онгойлгон санамж уриаг авч байсан юм. Тэр шөнөдөө гудамжинд зам дээр Багшийн айлдварыг тайлбарлан тарааж зогссоцгоов. Хотын тэр хэсэгт мотоциклтэй эргүүл хийж байсан хоёр цагдаа хажуугаар өнгөрөх бүрдээ бидэнтэй найрсаг инээмсэглэн мэндэлдэг байв. Дараагийн өдөр бид Понсед тараалаа. Нэгэн Порте Рика хүн “Өөрөөр Амьдарцгаая” санамж уриаг мотоцикл дээрээ тавьсан байсан авшигтанд хандан: “Энэ лав Бурханаас л ирсэн байх учиртай “гэж хэлж байв.

8-р сарын 13-ны ням гаригт бид Порто Рикагийн нийслэл Санжуаныг зорив. Өглөө бид үзэсгэлэнт Карибын тэнгисийн ойролцоох толгодыг тойруулан барьсан хэрэмтэй, эртний Санжуанд санамж уриаг тараахаар явлаа. Үдээс хойш нутгийн авшигтнууд биднийг худалдааны төвд хүргэж өгөв. Худалдааны төв дүүрэн хүнтэй байхыг хараад бид их баярлав. Энэ улсын хуулиар худалдааны төв дотор хуудас тараахыг зөвшөөрдөггүй юм байна. Гэсэн хэдий ч бид Их Багшийн адислалаар 5000 хуудсыг нэг цагийн дотор тарааж чадлаа.

Дараа өдөр нь Кабарожо болон Сан Гермaнтай хиллэдэг Порте Рикагийн баруун эрэгт хүрч хуудас тараах, мөн тэндхийн авшигтнуудтай семинар зохион байгуулахад нь туслахаар явав. Семинар энэ нутгийн нэгэн авшигтны найзын цагаан хоолны зоогийн газаро болов. Семинар эхлэхээс өмнө ширүүн бороо орж сэрүүн болов. Семинарын турш чин сэтгэлтэй, амар амгалан хүмүүсийг Багш адислаж буйг бид мэдэрч байлаа.

Бидний сүүлчийн ажил Порте Рикагийн Сатиу хотод үргэлжлэв. Бид хоёр их сургуулийн хотхонуудаар болон тэнхимүүдээр, профессоруудын шуудангийн хайрцаг, хичээлийн анги танхим, компьютерийн лаборатор, хүлээлгийн өрөөнүүдээр тараалаа. Санамж уриаг уншсан нэгэн профессор ”энэ хуудсанд хүнс тэжээлийн тоо баримт, цагаан хоолны ач тусын талаар дэлгэрэнгүй байгаа учраас талархан хүлээж авч байна” гэв.

8-р сарын 17-ны өглөө бид Порте Рикагаас Бахама улсын нийслэл Нассау уруу нисэв. Бахамад хар арьстан иргэд зонхилдог юм байна. Тэд халуун дотно, эелдэг найрсаг хүмүүс бөгөөд нутгийн хүмүүсийн 99% нь бидний тарааж буй уриаг дуртай гээч нь инээмсэглэн авч байсан юм. Автобусны жолооч



Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

нар автобусанд нь сууж явсан зорчигчдод тараахыг зөвшөөрсөн ба олон жолооч нэмж авав. Зарим нь уриаг үг үгээр нь чангаар уншиж байв. Цагаан хоолны материал хаанаас худалдаж авах, дуфу глютиныг яаж мэдэж авах зэргийг лавлаж асууцгаана. Бид тэдэнд “Багш маань бүх зүйлийг хүн бүрд хүртээлтэй, боломжтой болгож өгсөн юмаа” гэж хэлж явав. Зарим нь бясалгалын талаар сонирхон асууж байлаа.

Нассауд өнгөрөөсөн 2 дахь өдөр тээврийн гол замын уулзвар, хүн их цугларсан газруудаар тараав. Ялангуяа худалдааны газруудадын орчим замын түгжрэлээс болоод машины урт цуваа бий болж, хөдөлгөөн удааширсан байсан нь жолооч нарт гарт нь өгөхөд эвтэй байв. Бидний хуудас тараалтаас болоод замын хөдөлгөөнд саатал гарч байсан ч хэн ч дургүйцсэнгүй. Бүх жолооч тэдэнд тараасан уриаг авав. Хуудас тарааж буйг хараад урт цуваны хойнох жолооч нар цонхоо онгойлгон хуудсыг авахаар эртнээс бэлдэж байлаа. Бурханы хайрын илгээлтийг авахыг тэсэн ядан хүлээж байгаа хүмүүсийг харах үнэхээр сайхан байв.

Хэдийгээр авшигтнууд аяллын ихэнхид нь халуун наранд зогсох ёстой болсон ч хүн бүр Багшаас ирж буй хайр адислал, үйлчлүүлж буй хүмүүсийн жаргалтай царай, энерги, эрч хүчээр сэлбэгдэж байлаа.

Үнэндээ санамж уриаг хүлээж авсан хүмүүсийн тоо бидний бодсоноос хавигүй илүү байснаас болж нутгаасаа тараах хуудас нэмж авчруулсан юм. Бид испани хэл дээрх тараах хуудас 31000 ширхэгийг Порте Рикад, англи хэл дээрх тараах хуудас 8000 ширхэгийг Бахамад тараав. Энэ аялалаас бид олон хүн өөрчлөгдөхийг хүсч буйг мэдэрсэн билээ. Бурханы хайраар дүүрэн “Өөрөөр Амьдарцгаая” санамж уриа тэдэнд онгод хайрлаж, өөрчлөлт хийхэд нь итгэл өгч тус дэм болсон нь дамжиггүй.

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

АНУ

Бурханы хайрын мессеж Америкийн төв хэсэгт хүрлээ



Миссиоригийн Төвөөс, АНУ (Англи хэлээр)

Иова муж нь газар нутгийн байрлалаар Америкийн Нэгдсэн Улсын яг төв хэсэгт байрладаг. Тус муж нь шар буурцаг, эрдэнэ шишийн гол үйлдвэрлэгч бөгөөд хүнсний ногоо, цагаан хоолны уургаар Бурхнаас адислагдсан баян нутаг юм. Харамсалтай нь бараг ихэнх шар буурцаг, эрдэнэ шиш нь махны чиглэлээр өсгөж буй малын тэжээлд зориулагддаг. Тэндхийн олон хүмүүс хажууд нь бэлэн байгаа шар буурцгийнхаа шим тэжээллэг орц найрлагын тухай огт мэддэггүй юм шиг санагдсан. Миссиори мужийн авшигтнуудад 3-р Алтан Жилийн (2006) Наймдугаар сарын 2-ноос 5-ний өдрүүдэд Иова мужид Бурхны мессежийг түгээн, “Та ийм амьдралыг сонгож болно” тараах хуудсаа хүргэх сайхан боломж тохиосон юм.

Миссиоригийн авшигтнууд Оттумва, Оскалуза, Пэлла, Дэс Мойнэс, Коралвилл, Иова Хот болон Фэйрфилд хотоор аялжээ. Зам зуур алсад харагдах хөх тэнгэрийн тэртээ Иовагийн тал ногоорон шар буурцаг, эрдэнэ шишийн тариалангаар хучигдсан нь тэдний сэтгэлийг тайвшруулан амар амгаланг мэдрүүлж байлаа. Авшигтнууд маань тараах хуудас, цагаан хоолны жороо өөр өөр хотуудад тараан явахдаа нийтийн болон их сургуулийн номын сангуудаар орж номын сан болгонд “Агшин Зуур Билиг Нээгдэх Түлхүүр” цувралын хоёр ном, Үлгэр дэвтрээс нэг ширхэг, “Жинхэнэ Баатрууд” DVD нэг ширхэгийг тэдэнд өргөн барьжээ. Ялангуяа хоёр их сургуулийн захирлууд эдгээр материалууд дээр нэмээд “Агшин Зуур Билиг Нээгдэх Түлхүүр” номын цувралыг бүрэн эхээр нь хүлээн авах боломжтой болсноо сонсоод маш их баярласан юм.



Наймдугаар сарын 4-ний өглөө Дэс Мойнэс хотод цаг агаар маш халуун, бүгчим 90F (32C градусаас дээш) байсан учир авшигтнууд дөрвөн давхар машины зогсоолын дотор тараах хуудсаа өлгөсөн хэдий ч үүнд нэн их хүчин чармайлт гаргах шаардлагагүй гэдэг нь удалгүй тодорхой болжээ. Тэд Дэс Мойнэсээс даруйхан явж Фэйрфилдэд 8-р сарын 4-ний орой зохиогдсон Хүмүүнлэгийн явган зугаалгад санаандгүй оролцох болсон нь Бурханы зохицуулалт байсныг сүүлд ухаарсан байна.

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

Авшигтнууд тэр оройдоо 6 цагийн орчимд Иова мужийн Фэйрфилдэд очжээ. Хэдийгээр Фэйрфилд 6,000-аас цөөн байнгын оршин суугчтайн дээр гадны 6,000 оюутан амьдардаг жижигхэн ч маш оюунлаг хот юм. Төв цэцэрлэгийнх нь ойр цагаан хоолны нэг ресторан ажилладаг бас хэд хэдэн цагаан хоолны сонголттой ресторанууд байдаг ажээ. Авшигтнууд маань цагаан хоолны ресторанд хэдэн ном өгөөд гартал үүдэнд нь Лос Анжелесаас Фэйрфилд рүү оюунлагийн ажлаар нүүж яваа нэгэн эртэй тааралджээ. Тэр хүн манай байгууллагын тухай урьд нь сонсож Их Багшийн сургаалийн тухай бүдэг бадаг ойлголттой байсан ба номын ах, эгч нарыг хараад сэтгэл нь маш их хөдөлж Их Багшийн сургаал номын талаар тэдэнтэй яриа дэлгэсэн байна. Тус хотод олон хүн бясалгал хийдгийн зэрэгцээ тэдний зарим нь цагаан хоолтон ажээ. Тэрээр манай бясалгалыг өөрөө сонирхохоос гадна тэр хотод сар бүрийн эхний Баасан гарагт Хүмүүнлэгийн явган зугаалга болдог тухай авшигтнуудад ярьж, тэр арга хэмжээнд оролцон Аръяабалын бясалгалынхаа тухай бусад олон хүнд таниулахыг зөвлөжээ. Авшигтнууд энэ боломжийг ашиглан оройн 9,30 хүртэл Семинарын тухай болон “Та Ийм Амьдралыг Сонгож Болно” тараах хуудаснуудаа олонд түгээсэн юм.

Дараагийн өдөр нь тэднийг гэртээ эргэн ирсний дараа нөгөө хүн Фэйрфилдээс Миссиоригийн төв рүү утсаар ярьж Аръяабалын бясалгалын тухай илүү ихийг мэдэж, сэтгэлийн авшиг хүртэх хүсэлтэй байгаагаа хэлсэн. Мөн өөрийнхөө ээж болон урьд орой нь тараах хуудаснаас авсан хэсэг найз нартайгаа төв дээр ирэхийг маш их хүсч байгаагаа хэлсэн юм.

Авшигтнууд маань цаг агаарын халууныг үл хайхран АНУ-ын төв хэсэг Иова мужаар явахдаа 10,500 орчим тараах хуудас тараасан нь Бурханы тэднээр дамжуулан тарьсан оюунлагийн үр байсны дээр аль хэдийнээ нахиагаа дэлгэж эхэлснийг тэд харлаа.

Сингапур

Өөрөөр амьдарцгаая явуулын шоу

Сингапурын мэдээллийн групп (Англи хэлээр)

Сингапурын төв 3-р Алтан Жилийн (2006) 7-р сарын 8-нд “Өөрөөр Амьдарцгаая” явуулын шоуг Тоа Пэйо Шинэ Хотод байрладаг Сингапурын Барилга Хөгжлийн Удирдах Зөвлөлийн (БХУЗ) Төвд зохион байгууллаа. БХУЗ нь маш олон оршин суугч, худалдан авагчтай Тоа Пэйогийн Төв хэсэгт байрладаг тул Их Багшийн “Та ийм амьдралыг сонгож болно” мэдээллийг нийтэд хүргэхэд хамгийн тохиромжтой газар байлаа.

Явуулын шоу бүтэн өдөр үргэлжилж өглөө 10-аас оройн 10 цагт өндөрлөв. Түрээсэлсэн талбайг Их Багшийн фото зураг, дэнлүү, уран зураг болон савтай ургамал тэргүүтнээр маш гоё хялбархан чимэглэсэн байв. Бид гурван телевизор байрлуулж Сингапурын Цагаан Хоолны Нийгэмлэгээс

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

(СЦХН) урьдчилан бэлдэж өгсөн ”Үр Тариа Дэлхийн Хөгжилд” нэртэй видео бичлэг үзүүлэн мөн компьютераар цагаан хоолтон алдартнуудын тухай слайд шоу үзүүллээ. Цаашилбал бид зөвхөн цагаан хоолны сайн тал, тэжээллэг чанарын талаар таниулаад зогсоогүй олон нийтэд цагаан хоолоор үйлчилдэг газруудыг зааж өгсөн.

Үүний зэрэгцээ СЦХН 7-р сарын 22-30 нд “Махгүй Сингапур” (МС) нэртэй 10 хоногийн компанит ажил зохион байгуулсан юм. Уг арга хэмжээг хоёр дахь жилдээ зохион байгуулж байна. Энэ үеэр Эрүүл Хоолны Урлаг болсон Нийтийг Хамарсан Тусгай Баяр Ёслолын “МС” Оройн Зоог барьсан нь олон хүнийг цагаан хоолонд орохыг зоригжуулан дэмжиж цаашдаа өөр олон үйл ажиллагаа явуулах эхлэлийг тавьсан арга хэмжээ болсон. (www.singaporemeatout.org). Тус Нийгэмлэгээс зохион явуулж байгаа сайн үйлсийг дэмжиж Оройн Зоогийн билетийг борлуулхад нь бид тусаллаа.

Манай явуулын шоуны талбай БХУЗ-ийн Төвийн гол хэсгийн цэлгэр танхимд байрлаж байв. Тэнд төрөл бүрийн бараа зардаг худалдаачид талбай түрээслэн маш олон дэлгүүр мухлагууд танхимийн хоёр талаар байрлажээ. Бүтэн өдрийн турш үйлчлүүлэгчид хүмүүсийн хөл хөдөлгөөн тасралтгүй цуварсаар байлаа.

Эхлэх ёстой цагаас нь өмнө нэгэн эрэгтэй үйлчлүүлэгч лангуун дээр хүрч ирэн Их Багшийн фото зураг, уран зураг, дэлгэн тавьсан материалуудыг үзэж хоёр өгүүлэл худалдан аваад дараа нь видео бичлэг маш анхааралтай үзэж зогссон. Сүүлд нь тэрээр буцан ирж хоёр дахь удаагаа бичлэг үзсэн юм.

Мөн бидний өөдөөс харсан хувцас, үсний хэрэглэл зардаг лангууны эзэн өөрийнхөө үйлчлүүлэгчдийг анхаарахаас илүү видео бичлэг рүү анхааран үзэж байсныг бид ажигласан юм. Олон үйлчлүүлэгчдийн дунд хоёр дунд насны цагаан хоолтон эмэгтэй бидний энэ үйл ажиллагааг дэмжиж байгаагаа илэрхийлэв. Тэдний нэг нь цагаан хоол зардаг лангууны эзэн бөгөөд тэд найзууддаа өгөхөөр тараах хуудас олныг авч явлаа. Сингапурт бидний явуулж буй ном дэлгэрүүлэх ажилд талархан бидэнд сэтгэлийн урам хайрласан юм.

Ойролцоо байдаг автобусны паркийн жолооч нар цайны цагаараа видео бичлэг үзэхээр ирсэн байлаа. Тэдний нэг Энэтхэг жолооч цайны цагаа дуустал бичлэг үзэж цагаан хоолтон болохыг

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

хүсэж байгаа тухайгаа номын эгчид хэлж байсан болович нөгөө л тахианы махаа идсээр байв. Тэгээд бид түүнийг өдөр өдрөөр цагаан хоол идэх тоогоо нэмсээр цагаан хоолтон болохыг зоригжуулан зөвлөлөө. Мөн ямар учраас хүн цагаан хоолтон байх хэрэгтэйг таниулан дэлгэрэнгүй мэдээлэл өгсөн юм.

Өөр нэгэн эмэгтэй өмнө нь Багшийн бичлэг үзээд амьтдыг шаардлагагүй зүйлээс болж зовж байгааг хараад сэтгэл нь шимшрэн их уйлж түүнээс хойш мах идэхээ больсон тухайгаа бидэнд ярьсан юм. Түүнд нэг авшигтан хөөрхөн амьтдын зурагтай дээр нь “Биднийг хайрлаач, Бүү Идээч! Бүгдийн амь, амьдрал үнэтэй” гэсэн бичигтэй наалддаг зураг өгсөн нь буцаж мах идэхгүй байхын сануулга болжээ.

Үдээс хойш манай авшигтнуудын нэг нь нүдэндээ дүүрэн нулимастай бяцхан охиныг бичлэг үзэж зогсохыг харсан юм. Тэр охин аавaасаа хөтлөөд ээж нь ойрхон зогсож байлаа. Бичлэг дууссаны дараа манай нэг авшигтан тэдэн дээр очиж бяцхан охиныг тайвшрууллаа. Охины аав,ээж хоёр охиндоо амьтдыг яаж зовж байгааг үзүүлэх эсэхэд эргэлзэж байгаад эцэст нь үзүүлсэн гэж охины аав хэлж байлаа. Видео бичлэг үзээд охины сэтгэл хэрхэн эмзэглэж байгааг хараад аав, ээжийнх нь нүдэнд нулимс цийлэгнэсэн байв. Саяхнаас идэж буй зүйлдээ илүү анхаарал хандуулж эхэлсэн гэж аав нь нэмж хэлсэн юм. Бид тэднийг хялбархан аргаар эрүүл цагаан хоолтон болоход нь туслахын тулд дэлгэн тавьсан бүх мэдээлэл, харьцуулалт хийсэн сурталчилгааны хуудаснаасаа өгч, цагаан хоолтон байхын тал бүрийн ашиг тусыг багтаасан Их Багшийн сэтгүүлийн нийтлэл болон номын жагсаалт болон цагаан хоолтны амьдралын хэвшлийн эерэг талыг тусгасан вебсайтуудаар зочлохыг санал болголоо.

Орой нэг Энэтхэг эмэгтэй ирж “Өөрөөр Амьдарцгаая” гэсэн тараах материал, Цагаан хоолтон алдартнуудыг ихэд сонирхон уншиж байлаа. Мөн манай компанит ажил, Их Багшийн талаар мэдэхийг хүсэхэд авшигтнууд түүнд Аръабалын Бясалгал болон Их Багшийнхаа тухай дэлгэрэнгүй мэдээлэл өгч үлгэр дэвтэр болон олон төрлийн нийтлэлүүд, тараах материалууд өгсөн. “Надад доошоо бууж ирэх хэрэг байна гэдгийг мэдсэн юм” гэж тэр явахаасаа өмнө хэлэв. Тэр эмэгтэй үйлчилгээний төвийн дээд давхарт ажилладаг дэлгүүрийн эзэн хүн байлаа.

Сурталчилгааны хуудсыг авшигтнууд БХУЗ-ийн Төв дээр бүхэл өдөржин, оройжин тараасан бөгөөд бараг бүх хүний гарт хуудаснууд очсон харагдаж байв. Бүх л орчин тойрон Хайрт Их Багшийн маань хайр, адислалын хүчээр бялхаж байхад бид маш баяртай сэтгэл хангалуун байлаа.

Индонез

Цагаан хоолны эрин үе эхэллээ!

Индонезийн Мэдээллийн группээс (Индонези хэлээр)

Жакарта хотын засаг захиргаа худалдаа, соёл, урлаг болон үзвэр үйлчилгээг дэмжих алдар цуутай, нүсэр том Жакартагийн Яармаг Худалдааг жил бүр уламжлал болгон зохион явуулдаг. 3-р Алтан Жилийн (2006) Зургадугаар сарын 15-наас Долдугаар сарын 16-ны хооронд сар үргэлжлэх энэ жилийн Яармаг нээгдэж 2 сая гаран хүн оролцлоо.

Яармагт оролцохоор гадаа цэлгэр том талбай авахад бидэнд тусалсан Бурханы төгс төгөлдөр зохицуулалтанд баярлалаа. Тэнд бид том дэлгэц, прожектор, сандлууд байрлуулж оролцогсдыг хүмүүсийн урсгалд саад болохгүйгээр Их Багшийн видео лекцийг суугаад үзэх боломжийг бүрдүүлсэн. Олон оролцогсод манай асар луу сонирхон ирж Их Багшийн тухай болон Арьяабалын бясалгалын тухай асууж лавлаж байлаа. Энэ үеэр 200,000 гаран “Та Ийм Амьдралыг Сонгож Болно” тараах хуудас, 1,000 орчим үлгэр дэвтэр тараасан байна.

Үнэнийг хайгч олон хүн Их Багшийн видео бичлэгийг нэлээн орой болтол үзлээ. Бичлэг үзсэн нэг хүн Багшийн тэргүүний эргэн тойрон их гэрэл байхыг харж Их Багшийг даган оюун санааны бясалгалаар хичээллэхийг туйлаас хүсч байгаагаа хэлсэн юм. Үүнээс гадна олон оролцогсод Их Багшийн лекцийг үзээд сэтгэл нь нэн их хөдөлж үлгэр дэвтрийг гэртээ аваачиж уншихаар авцгаасан. Яармаг дээр ажиллаж байсан Лалын шашинтан нэг цэрэг олон шашны тухай ярьсан Их Багшийн лекцийг үзээд сэтгэл нь татагдаж DVD-нээс худалдан авахыг хүссэн боловч бидэнд нэг ч үлдээгүй байв. Маргааш нь түүнд DVD авчирч өгөхөөр амласан боловч тэрээр өөр газар ажиллах байлаа. Хэдийгээр тийм боловч маргааш нь нөгөө залуу зөвхөн DVD-ний төлөө ирээд түүнийгээ авсны дараа их л баярласан харагдаж байлаа

Жакартагийн Яармаг дээр бидний явуулсан арга хэмжээг дэмжиж мэдээллийн болон нийтийн бусад олон байгууллагууд нэлээд олон үнэтэй, эерэг саналууд тавьж байсан. Зарим хүмүүс манай группийн тухай илүү мэдээлэл авахыг хүсч буцаж ирж байсан ба бидний амьтдыг хайрлах хайр, энэрэл нигүүлсэл тэдний сэтгэлийг ихэд хөдөлгөсөн шиг санагдсан. Түүний зэрэгцээ бид нэлээн удаан хугацаанд цагаан хоол идсэн нэг хүнтэй таарлдсан. Тэрээр тараах хуудсыг уншсаныхаа дараа дахин ирж бидэнд түүнийг тараахад тусалсан юм.

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

ЮКАРТА

Цагаан хоолны тухай хүмүүсийн ухамсарыг дээшлүүлэх ажлыг үргэлжлүүлэхийн тулд Юкарта төв нь олон нийтэд зориулсан “Та ийм амьдралыг сонгож болно” гэсэн илгээлтийг сурталчилах үйл ажиллагааг судалсан юм. Бурханы хайр ивээлээр бидэнд ийм боломж амархан олдсон билээ. Энэ нь 8-р сарын 23-28 ны хооронд Мандала Бхати Ванитатмагийн зохион байгуулсан Жожиогийн Номын үзэсгэлэн худалдаа байлаа.

Юкарта, Банжарнегара мөн Сараганы авшигтанууд энэ томоохон үйл ажиллагаанд бэлдэцгээн хамтдаа ажилласандаа маш их баяртай байв. Жакарта болон Сураваягийн төвөөс тараах материалууд болох ном сэтгүүлүүд, DVD, “Өөрөөр Амьдарцгаая” тараах хуудаснууд гэх мэт олон зүйлийг бидэнд явуулсан юм.

Их Багшдаа болон хамаг амьтадад сайн сайхныг хүсэх мөн 8 сарын 22-28ны өдрүүдэд зохиогдох ухуулах хуудас сурталчлах үйл ажиллагаа найрсаг эвтэй уур амьсгалд явагдах болоосой гэсэн даатгалтайгаар авшигтнууд шөнийн бясалгалыг тухайн өдрүүдэд зохион байгуулсан.

Бүхэл бүтэн долоо хоногийн үзэсгэлэн худалдааны турш 20000 –с илүү хүн “Өөрөөр Амьдарцгаая” тараах материалыг баяр хөөрөөр дүүрэн хүлээн авч байлаа. Энэ нь бидний 5-р сард газар хөдлөлтөөс өмнөхөн нилээн хүч чармайлт гаргаж тараасан байдалтай харьцуулахад маш их ялгаатай байв. Хэдийгээр бидний гол зорилго бол “Өөрөөр Амьдарцгаая” материалыг тараах байсан болович бид бас Их Багшийнхаа номын үзэсгэлэнг жижиг мухлагт гаргаж тавьсан юм. Бидний тооцоолсноор залуучууд, настайчууд гэх мэтийн янз бүрийн нийгмийн давхаргын хэдэн зуун хүмүүс ирж Багшийн маань видео бичлэгийг үзлээ.

Өдөр бүр л тэнд хүмүүс бясалгалын тухай мөн цагаан хоолтон амьдралын хэв маягийг байнга асууж ирдэг байв.

Индонезийн зүүн зүгийн хот болох Нүса Тэнгара Тимүрээс ирсэн Их сургуулийн нэгэн оюутан, холбогчоос бясалгалын тухай асууж мөн сурах хүсэлтэйгээ хэлэв. Тэрээр цэвэр цаган хоолтон байх мөн бусад бүх л шаардлагуудыг хичээнгүйгээр дагасан гэж байлаа.

СУРАБАЯА

Сурабаяагийн авшигтанууд Сурабаяа дахь Пенелих Нийгмийн Халамжийн Төвөөс ирсэн гэрийн эзэгтэй нартай хамтран цагаан хоолтон амьдралын хэв загварыг хуваалцах ашиг тустай үйл ажиллагааг зохион байгууллаа. Энэ нь Индонезид олон удаа тохиолдож байсан үхрийн галзуу өвчин, шувууны ханиаднаас хойшхи маш чухал арга хэмжээ болсон юм. Товчхон мэдээлэл хийсний дараа цагаан

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

хоолны амталгаа эхлэв. Авшигтанууд маань цагаан хоолны уурагт сатай, цагаан хоолны стейк мөн BBQ Tempeh /маш өндөр уураг бүхий хөөлгөсөн шар буурцгийн кекс/-р дайллаа. Бүх цагаан хоолнуудаа бид тун сайхан амттай хийсэн байсан учраас ээзгтэй нар маань гайхсанаа нууж чадахгүй байв. Бид, цагаан хоолнууд нь өндөр чанарын баялаг мөн хоол бүр нь уургийн агууламж ихтэй, жишээ нь дүпү нь Индонезид маш алдартайд тооцогддог болохыг хэлсэн юм. Цааш нь бид вегатиран "мах" болон хуурай глутиныг өдөр бүр хэрэглэх мөн эдгээр нь цагаан хоолны бүтээгдэхүүн зардаг дэлгүүрүүдэд хангалттай бийг тэдэнд хэлж танилцуулсан юм. Өөрсдийн гэр бүлээ хооллох махнаас өөр зүйлийг аль хэдийн хайж байсан тэд маш их баяр хөөртэй байцгаав.

Үйл ажиллагаанынхаа төсгөлд бид тэдэнд вегатариан стейк, "Өөрөөр Амьдарцгаая" тараах материал, мөн үлгэр дэвтрийг багтаасан бэлэгнүүдийг өгсөн бөгөөд их л баяр хөөртэйгөөр тэд гэрлүүгээ авч явцгаасан юм. Эргэн тойронд маань өөдрөг сайхан сэтгэлийн уур амьсгал үүссэн байсан ба тэд өөрсдийн найз нартаа энэхүү цагаан хоолны тухай ярьж дагуулж ирж болох уу гэж биднээс асууж байв.

МИДАН

Авшигтанууд маань Миданы ойр орчимд "Өрөөр Амьдарцгаая" тараах материалыг байнга тогтмол тараасаар байгаа билээ. Энэ тараалтын ажил нь зарим авшигтануудын хувьд нийтийн бясалгалын дараа буюу Бямба, Ням гариг бүр хийгддэг тогтмол хэлбэрт орсон юм. Ням гарагт тэд хоёр багт хуваагддаг. Эхний баг нь хотын төв буюу орон сууцны хорооллуудад чиглэдэг бөгөөд мөн дэлгүүрийн орчин тойрон, сургуулиудад тараах материалаа тараадаг.

Хоёр дахь баг нь Меданаас 1-5 цаг гаруй явж хотын гадна үйл ажиллагаагаа явуулдаг. Бид "Та ийм амьдралыг сонгож болно" илгээлт мөн Дэлхийн цагаан хоолтон алдартай хүмүүсийн жагсаалтыг хоёр долоо хоногт нэг удаа үнэгүй тараагддаг сонинд бас Миданы тэргүүлэх ихэнх нэр хүнд бүхий сонингуудын нэг болох "Анализа" сонинд хэвлүүлсэн бөгөөд уг сонин нь өдөрт 60000 ширхэгээр түгээлтэнд очдог байна.

Бид мөн "Нэг Сая Гэрлийн Залбирал", "Нэг Сая Итгэл Найдвар" гэсэн арга хэмжээн дээр очиж 3000 ширхэг тараах материалыг тарааж чадсан юм. Энэхүү залбирал нь бидний эх орны сайн сайхны төлөө байсан

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

ба энэ ажиллагааг Миданы Лапанган Мирдика /Эрх чөлөөний талбай/ -д Индонезийн Буддистүүдийн холбоо зохион байгуулсан.

Бид мөн "Өөрөөр Амьдарцгаая" илгээмжийг бэлэглэхэд зориулж тэмдэглэлийн дэвтэрт хэвлүүлснээс гадна энэ илгээмжийг зурагт хуудас болгон Меданы нисэх онгоцны буудалд байрлуулсан юм.

"Өөрөөр Амьдарцгаая" - онгоцны буудал дээр амьд сурталчилгаа

БАЛИ

Балид цагаан хоолны зоогийн газрууд маш ихээр нэмэгдэж байгаа ба авшигтанууд маань эдгээр газруудыг "Өөрөөр Амьдарцгаая" хуудсыг тараах хэрэгсэл болгохоор шийдсэн юм. Зоогийн газрууд бүр тараах материалын тараалтыг хэрэгжүүлэхийг дуртайяа хүлээн зөвшөөрч мөн өөрсдийн үйлчлүүлэгчиддээ цагаан хоолтон болоход нь тус дэм болох үүднээс зурагт хуудаснуудыг дэлгэн үзүүлж байв. Хэдэн авшигтанууд Ринон мөн Видүгүлд "Өөрөөр Амьдарцгаая" материалыг тараахаар явцгаасан юм. Видүгүл нь Балийн алдартай аялал жуучлалын тосгон юм. Олон жуулчид бидний зорилгыг ойлгосныхоо дараа толгой дохицгоон санал нэгтэй байгаагаа хүлээн зөвшөөрч басхүү их баяр хөөртэй байгаа нь харагдаж байв. Саяхан, манай авшигтанууд Юбүд материалаа тараасан бөгөөд энэ тосгон нь мөн л Балийн аялал жуулчлалын томоохон газрын нэг юм. Бид мөн Балийн хажуу арал болох Ломбок-д материалаа тараасан.

Ренонд KVMI -ны зохион байгуулсан уртаа гэгчийн жагсаалд оролцсон бөгөөд ойролцоогоор 1200 гаруй жагсагчид Өөрөөр амьдрая гэсэн илгээлтийг ар тал дээрээ бичсэн футболкыг өмссөн байв. Бид тэр үйл ажиллагааны үеэр жижиг мухлаг нээн "Өөрөөр Амьдарцгаая" материалыг хүн бүгдэд тараасан юм. Энэ үйл ажиллагаа маш амжилттай болсон. Үнэхээр, цагаан хоолтоны эрин эхэлсэн байлаа.

ФОРМОСА

Шөнийн захууд цагаан хоолны зар сурталчилгаагар гэрэлтэж байна

Тайнаны мэдээллийн баг (Хятад хэлээр)

Тайнаны шөнийн захын хэсэгт байнга л олон хүн хөлхөлдөж байдаг билээ. Тайнан төвөөс манай авшигтанууд "Өөрөөр Амьдрая" материалыг сурталчилахын тулд Хинянг, Яншей, Мадоугийн шөнийн захуудад анхааралаа хандуулсан юм. Бид шөнийн зах дээр ирэх үедээ "Өөрөөр Амьдрая" тараах материалыг бүх л орох, гарах хаалгануудын ойр зогсон тарааж эхэлсэн бөгөөд мөн самбаруудыг байрлуулан, "Жинхэнэ Баатрууд" DVD-г тэнд гаргасан. Олон хүмүүс уг киног үзэхээр зогсоцгоох үед манай авшигтанууд маань өөрсдийн хийсэн нарийн боов, үндаагаар маш хурдан үйлчилж байлаа. Манай баг тэнд борлуулалтын зар сурталчилгаа хийгээгүй юмаа, харин амьтдыг хайрлах бас цагаан хоолтоны хэв маягийг сурталчилсан ба хүмүүс манай ер бусын лангууг маань сонирхоцгоон их сайхан сэтгэгдэлтэй байцгаав.

3-р Алтан жил /2006/-ийн 6-р сарын 24-нд Хинянг шөнийн захад "Жинхэнэ Баатрууд" киног гаргаж дуусахад нэг бүсгүй маш их оюунлаг асуултуудыг асуусан юм. Тэр хэлэхдээ: "Тэр Христийн шашинтан байсан, одоо нэг томоохон эмнэлэгт сувилагчаар ажиллаж байгаа. Олон өвчтөнгүүдийн зовлонг нүдээр харж байхдаа тэрээр амьдралын утга учир бол түрхэн зуурынх юм байна гэдгийг гүн гүнзгийгээр мэдэрсэн бөгөөд өдөр бүр л оюун санааг нь гэгээрүүлэх арга замаар Үнэнийг олоход Бурхан минь туслаач, өвчтөнүүдийн өвчинийг намжаахад туслах чадвартай болгож хайрла гэж байнга залбирч эхэлсэн гэнэ. Ингээд тэр эмэгтэй энэ газар /шөнийн захад/ Багшийн маань киног үзэхээр ирчихсэн байна" гэв.

Манай авшигтануудаас асуултууд асууж хариултаа сонссоныхоо дараа тэр залбиралынхаа хариултыг авсанд Бурханд баярлалаа гээд өөрийн өвчтөнүүддээ зориулж олон тараах материал, үлгэр дэвтрүүдийг авч явсан юм. Бас нэг хүн, ахлах сургуулийн газар зүйн багш "Өөрөөр Амьдрая" зар сурталчилгаанд сэтгэл нь ихэд догдлон үүнийг олонд хүрэхээр хамгийн сайн үйл ажиллагаа болжээ гээд зөв зүйтэй амьдрах, аллага хийхгүй байх, эрүүл энхийг эрхэмлэх, хоолны хаягдалаас зайлсхийх, ядуу буурай орнуудад туслах мөн цаашаагаа дэлхийн энх тайванд туслах гэх мэтийн үр нөлөөг хэлэхийн аргагүй юм гэсэн юм. Тэр эмэгтэй мөн цагаан хоол хэрэглэх ёс зүйг дэмжин бидэнтэй хамтарч ажиллахдаа дуртай байх

Энэрэнгүй цагаан хоолтой ертөнцийг бий болгох нь

болно гэлээ.

7-р сарын 19-нд Яншей шөнийн захад бид "Өөрөөр Амьдрая" материалыг тараахаас гадна мөн "Цагаан хоолтон байх 10-н шалтгаан" гэдгийг өгч байсан юм. Дунд болон ахлах сургуулийн олон хүүхдүүд эцэг эхийн хамт зугаалан явцгааж байхад нь бид тэдэнд тараах материалыг тайлбарлан нилээд олон зүйлийг хэлж өгсөн бөгөөд тэд гүйлгэн уншиж өөрсдийн эцэг эхтэйгээ хуваалцаж байв. Бүгдээрээ л баяр хөөртэйгөөр хүлээн авсан юм.

Моторт дугуйгаар явж байсан нэгэн эрэгтэй телевизийн дэлгэцээр Багшийг харангуутаа "Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай" гэж уулга алдан хэлэв. Тэр дугуйгаа хурдхан гэгч зогсоогоод Багшийн тухай лавлан асуулаа. Тэр өөрөө хөдөлгөөний хомсдолд зовсон хүмүүсийг асрах Сувлахуйн төвд ажилладаг гэв. Өнгөрсөн жилийн эхэнд Тайнан төвийхөн энэ төвд очицгоосон бөгөөд түүнээс хойш тэндхийн оршин суугчдын нэг нь Их Багш Чин Хайг дагахыг хүссэн боловч тэр бидэнтэй яаж холбогдохоо мэдэхгүй байв. Ингээд одоо энэ зах дээр тэр бидэнтэй тааралдлаа.

Бид түүнд өөрсдийн холбоо барих хаягтай үлгэр дэвтрээ өгсөн бөгөөд дараагийн удаад асаргаа сувлахуйн төвд зочилон очих цаг зав гаргахаа амалсан юм.

8-р сарын 21-нд Мадоу шөнийн захад хүмүүс манай лангууны хажуугаар өнгөрч явснаа Их Багшийн маань ярианд татагдан "Жинхэнэ Баатрууд" киног үзэхээр зогсоцгоож байв. Бид ойролцоогоор 600 гаруй "Өөрөөр Амьдрая" илгээмжтэй дэвүүрүүд, тэмдэглэлийн дэвтрүүд/pencil pads, бичгийн хавтас /file folders/ –г тараалаа.

ТАЙНАН ОЛОН УЛСЫН ЧИХСИ УРЛАГИЙН НААДАМ

Тайнан Хотын Зөвлөл ивээн тэтгэж Тайнан Олон улсын урлагын наадамыг 7-р сарын 21-нээс 31-ны хооронд Күнзийн Сүмийн Соёлын Цэцэрлэгт хүрээлэн болон хөрш зэргэлдээх жуулчины газруудад зохион байгууллаа. Тайнаны төв энэ боломжийг алдалгүйгээр 7-р сарын 29-31-нд гурван шөнө дараалан "Өөрөөр амьдрая" материалууд, тэмдэглэлийн дэвтрүүд, дэвүүрүүдийг тараасан юм. 7-р сард Тайваны өмнөд хэсэгт маш их халуун байснаас олон хүмүүс дэвүүрийг авахаар ирцгээсэн бөгөөд зарим унадаг дугуйтангууд өнгөрч явсанаа буцаж ирэн асууж байлаа. Тараах ажиллагааны хоёр дахь өдөр нэгэн рок хамтлаг тайзан дээр тоглолтоо хийн үзэгчдийг байлдан дагуулав. Зуу зуун хүмүүс "Өөрөөр Амьдрая" дэвүүрүүд, тэмдэглэлийн дэвтэрүүдийг барьчихсан хөгжмөө даган гараа дээш нь өргөн далалцгаан байхыг бид харсан юм. Энэ бол гайхамшигтай үзэгдэл байлаа. Рок хамтлагийн тоглолт бараг нэг цаг үргэлжилсэн ба үзэгчид мөн цагийн турш даллан байв. Бид бүгд их гайхацгаасан бөгөөд үүнд нь сэтгэл хөдлөн баярлацгаасан юм. Нэг номын эгчийг "Өөрөөр Амьдрая" материалаа дуусах үед нэгэн жижигхэн нохой хүрч ирэн тэр эгчийн зогсож байсан зүгрүү харсаар байв. Энэ нь дахин дахин давтагдаж тэр тэндээс явахыг

хүсэхгүй байгаа нь илэрхий харагдаж байв. Харсан хэн бүхэн гайхав. Энэ сүнс нь Их Багшийн маань бүх л төрөлхтөнийг хамгаалж байгааг мэдсэн гэдэгт бид итгэж байлаа. “Өөрөөр амьдрая” зар сурталчилгааны үйл ажиллагаанд оролцсон хүн бүхэн Их Багшийнхаа асар их адислал, хайрыг мэдэрсэн юм. Бид бүгд тэнгэрийн орны илгээлтийг хүргэх Бурханы “шуудан зөөгч” байхад боломж олгосонд чин сэтгэлийн угаас хүнээ хүндэтгэл илэрхийлье.

Багшийн хошигнол

Хэн нь Хэндээ туслав аа?

Их Багш Чин Хай,
Флорида, АНУ. 2003.02.03 (Англи хэлээр) Видео хуурцаг №755

Нэг эр гольф тоглож байгаад гэртээ ирэхэд эхнэр нь түүнээс “Тоглоом чинь ямаршуухан болов” гэж асуухад нөгөө эр,” Би ер нь дажгүй цохиж байсан л даа. Гэхдээ миний хараа бөмбөгөө хашаа ниссэнийг ч олж хархааргүй болтлоо муудчихсан байна” гэхэд эхнэр нь, “Жэк чи чинь 75 тай шүү дээ! өөр яана гэж бодоов? Чи ер нь яагаад ахыг минь дагуулаад явж болдоггүй юм бэ?” гэхэд Жэк” Гэхдээ тэр чинь 85тай шүү дээ, тэгээд ч гольф тоглохоо больчихсон” гэв. “ Гэхдээ л түүний хараа маш сайн, ядахдаа л бөмбөгийг чинь харж өгөхгүй юу “ гэж эхнэр нь хэлэв. Маргааш нь Жэк гольф тоглохдоо хадам ахыгаа хамт авч явжээ. Тэгээд ах нь харж, Жэк цохитол бөмбөг нь бас л хаа нэгтээ алга болжээ. Жэк ахаасаа “Та харж амжив уу?” гэхэд “Тиймээ тийм би харсаан, харсан!” гэжээ. “Тиймүү? Тэгээд хаана байна?” гэж Жэк асуухад “Харин ээ, би мартчихлаа.” гэж хариулжээ.

Их Багшийн ярьсан дээрх онигоог эхээр нь сонсох болон бусадтайгаа хуваалцахыг хүсвэл:
http://www.Godsdirectcontact.org.tw/eng/news/174/jk1.htm
http://www.Godsdirectcontact.us/sm21/enews/www/174/jk1.htm

Хайрын илгээлтийг алгаа тосон угтаж авсан хүүхдүүд

Авшигтан номын ах Санпи,Формоса, Шинжү төв (Англи хэлээр)

Саяхан Шинжү төв Багшийн "Өөрөөр Амьдарцгаая" санамж уриаг хүлээн авч Багшийн адислалыг хүртлээ. Надад Энэхүү сайхан мэдээг тарааж, цэцэрлэгийнхээ хүүхдүүдэд нэг боодол футболк цамц тарааж өгөх боломж надад олдсон юм. Хүүхдүүддээ энэ сайхан бэлгийг өгөх болсон нь миний хувьд нэр төрийн хэрэг байлаа. Цамцыг тэд ихэд баярлан авч шууд л дэлгэж үзэцгээв. Тэдэнд цамцанд дүрсэлсэн амьтад ихэд таалагдсан ба бид футболктайгаа зургаа авахуулав. Энэ үнэхээр сайхан үйл явдал болов. Бяцхан хүүхэд, тэдний эцэг эхэд энх амгалан амьдрахын утгыг таниулсан Их Багшдаа баярлалаа. Надад тэр өглөө яг л Алтан үед хичээл зааж буй мэт сэтгэгдэл төрж байсан билээ.

Гуань Инь вэб сайт

Бурхантай шууд холбогдох—

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэгийн интернэт дэх хаяг:

http://www.Godsdirectcontact.org.tw/eng/links/links.htm

Энэ хаягаар ороход төрөл бүрийн хэл дээрх Гуань Инь бясалгалтай холбоотой мэдээг авахаас гадна Үзэсгэлэнт ертөнцөөр аялахуй нэвтрүүлгийг 24 цагийн турш үзэх боломжтой. Түүнчлэн Агшин зуур билэг нээгдэх түлхүүр номын үлгэр дэвтрийг олон хэл дээр уншиж, мэдээ сэтгүүлийг татаж, электрон ном эсвэл хэвлэх байдлаар захиалан унших боломжтой.

Загас
Хайрын далайд сэлж явна

Авшигтны мэдээллээс Шан Кси муж, Их Газрын Хятад (Хятад хэлээр)

Саяхан манай охин загастай болохыг хүсч дэлгүүрээс хэдэн загас худалдан аваад гэртээ ирсэн юм. Би эдгээр загаснуудад өдөр болгон Их Багшийнхаа Буддагийн аялгууг сонсгож, Багшийнхаа гэрэл зургийг хажууд нь тавьж өгсөн. Үүний дунд ихэнх цагуудад тэд Самадид орсон мэт ид шидийн ч гэмээр байдалтай харагдах болсон.

Сүүлд нь би тэдэнд “Ганцхан миний Багш л та нарыг одоогийн энэ загасны амьдралаас чинь дээшлүүлж дараагийн төрөлд чинь хүн болоход тусалж чадна. Тэгвэл та нарт оюун санааны бясалгал хийн чөлөөлөгдөх завшаан олдоно шүү” гэж хэллээ. Мөн делфиний зурагтай “Та Ийм Амьдралыг Сонгож Болно” тараах хуудсыг ч тэдэнд үзүүлсэн. Нэмж хэлэхэд, би тэдэнд Их Багшийнхаа нэрийг дуудахыг зааж өгөхөд ойлгож байх шиг санагдав. Зарим нь сэрэл хөөрөлгүй бараг л “нисэж”, зарим нь үзүүлэнд тавигдсан юм шиг энд тэнд маш жаргалтайгаар сэлж, зарим нэг нь намайг сонсож байна гэх шиг нүдээ анивчуулсан юм. Тэгэхэд би маш сэтгэл хангалуун, баяртай байлаа.

Түүнээс хойш Их Багшийнхаа хуурцгийг загаснуудад үргэлжлүүлэн сонсгосоор байсан ба тэд үхэхдээ бие нь огт өөрчлөгдөхгүй яг л амьд хэвээрээ байх шиг санагддаг. Нэгэн удаа охин маань зүүдэндээ аварга том загас харсан гэж хэллээ. Тэр загаснаас Алтан шар өнгөтэй их гэрэл цацарч байсан гэнэ. Их Багшдаа энэ дэлхийг маань бүх оршин байгаа биетүүдтэй нь хамт адислаж байдагт Баярлалаа!

Цагаан хоолны эринд ойртож байна

Их Багшийнхаа заавраар цагаан хоолыг дэлгэрүүлэхийг дэмжихээр Арьяабалын Бодисатва Бурхан Багшийн Гэгээрсэн тэмдэглэлт өдөр болох Долдугаар сарын 14-нд “Та Ийм Амьдралыг Сонгож Болно” тараах хуудсыг би номын эгчийн хамтаар гудамжинд тараасан юм. Энэ дашрамд бид хүмүүст цагаан хоолтон байхын ашиг тус ба амьтдыг хайрлан хамгаалахын чухлыг тайлбарлаад энэ нь хүмүүсийг шувууны ханиад зэргээс сэргийлэх арга гэдгийг хэлж тэдний энэрэн нигүүлсэх сэтгэл дээшлэнэ гэдэгт найдаж байлаа. Хэрвээ хүн бүр цагаан хоолтон болвол амьтдын амьдрал аврагдаж, дэлхий энх амгалан болно.

Би нэгэн эмэгтэйд тараах хуудсаа өгөөд цагаан хоолны ач тусын тухай түүнтэй ярилцахад тэрээр өмнө нь сонин дээр “2015 он гэхэд дэлхий цагаан хоолны эринд орно” гэж зөгнөн бичсэнтэй тааралдсан гэж ярьсан юм. Энэ мэдээг сонсоод миний сэтгэл маш их хөдөллөө! Хүн төрөлхтнийг зөв амьдрахад сургаж тэднийг Бурханы Эзэнт гүрэн лүү буцахад тусалж байгаад Их Багшдаа Баярлалаа.

Биеэрээ туулж байж Гэгээрэлд хүрэх нь

Эзэн Бурханы сургаалийг сонссон чөтгөр ч гэгээрч болдог

Цаглашгүй Их Багш Чин Хайн айлдвар, Пэнгхү, Формоса, 2-р сарын 11, 1987 (Хятад хэлээр)

Шагжамуни Буддагийн үед юм байх, хөөрхий эмэгтэй бяцхан хүүгээ алдачхаад нулимсандаа живэх шахан байж л дээ. Тэр үед тосгонд нь ном тавьж байсан Шагжамуни Буддад зовлонгоо тоочиж, аугаа билиг ухаан, ид шидийн хүчээрээ хүүг нь аварч хайрлахыг гуйжээ. “Тэгэлгүй яахав, би аварч чадна” гэж Бурхан Будда амлаад: “Эхлээд та сүүлийн 5, 6 үедээ хэн нэгнээ алдаагүй тийм айлыг хайж олоод даавууны өөдөс, ямар нэг юм гуйгаад аваад ир. Тэгээд би хүүг тань аварч өгье” гэж гэнэ.

Хөөрхий эх Бурхан Буддагийн зааврыг дагаж айл үлдээлгүй явсан боловч 5, 6 үеийн турш хэн нэгнээ алдаагүй гэр бүлийг олсонгүй. Үхтлээ ядарч, урам нь хугарсан эх эргэн ирэхэд Шагжамуни Будда түүнээс “5, 6 үедээ хүнээ алдаагүй айл олов уу” гэхэд эх “Үгүй ээ, тийм айл нэг ч алга” гэж хариулав. Шагжамуни Будда түүнд хэлсэн нь: “Тийм бий. Амьдрал бол зуурдынх. Энэ дэлхий дээр төрсөн хэн боловч үхлээс зайлж чадахгүй. Эрт орой хэзээ боловч хэн хүнгүй насан эцэслэж энэ ертөнцийг орхиж явна. Та энэхүү зуурдын махан биеийг хэт чухалчлах хэрэггүй” гэв. Бурхан Будда үнэнийг айлдсан даруйд хүүгээ алдаж гашуудсан хөөрхий эх гэгээрчээ. Тэр цагаас хойш эх Бурхан Буддагийн үнэнч шавь болж хичээнгүйлэн бясалгасан байна.

Бас нэгэн царай муутай, аймшгийн Якса (чөтгөр)- гийн тухай түүх ярьж өгье. Аймшигт тэр Якса хүний маханд дуртай, айхавтар зуршилтай нэгэн байж л дээ. Яг л хүмүүс үхэр, гахай, тэжээвэр шувуу иддэг шиг, мөн бар хүн идэх дуртай шиг. Якса хүүхдийн маханд ухаангүй дуртай, нүдэнд нь торсон хүүхэд амтат идэш болдог байж гэнэ. Төдөлгүй тэр бээр тосгоны хүүхдийг бүгдийг идээд дуусгачихжээ. Аргаа барсан тосгоны эцэг эх Шагжамуни Буддагаас тус эрж гэнэ.

Якса нэг хүүтэй юмсанж. Бар нь амьтан, хүн барьж иддэг ч зулзагаа иддэггүй, хайрладгийн адилаар Якса хүүдээ их хайртай байжээ.

Шагжамуни Будда тосгоныхонд: “Яксаг гадагш явахаар хүүхдийг нь нуучих. Дараа нь яахыг би та нарт хэлэмз” гэж гэнэ. Тосгоныхон Яксаг гэрээсээ гарч явангуут хүүхдийг нь аваад нуучихжээ. Якса харьж ирээд хүүхдээ олж ядан ихэд шаналж, шалан дээр өнхөрч уйлж унжжээ. Эцэст нь тэр Бурхан Буддад бараалхаж тус эрэхээр очив гэнэ. Харж байна уу, чөтгөр ч гэсэн Бурханыг хүндэлдэг юм. Ад хорлол, чөтгөр бүхий л чин сэтгэлтэй бясалгагчдыг хүндэлдэг юм шүү дээ.

Шагжамуни Будда Яксагаас асуужээ. “Чи хүүхэддээ хайртай юу” гэхэд Якса “Тийм” гэв. “Хүүхэд чинь чамд энэ хорвоогийн хамгийн нандин зүйл мөн үү” гэхэд Якса мөн л “Тийм” гэв. “Бүх эцэг эх хүүхдээ хайрладагтай адил чи ч өөрцгүй хүүхэддээ маш их хайртай, тийм үү. Тэгвэл яагаад энэ тосгоны бүх хүүхдийг идэж байгаа юм бэ. Хэрвээ бусдын хүүхдийг идэхээ болино гэж амалвал чинь би хүүхдээ олоход чинь туслая” гэсэнд Якса даруй ам өчиг өгч гэнэ. Чөтгөр ч гэсэн гэгээрч болдог юм шүү дээ. Тийм байгаа биз? Шагжамуни Будда Яксад үнэнийг ойлгуулснаар тэр бээр гэгээрч бусдын хүүхдийг ч идэж зүрхлэхгүй болжээ.

Биднийхээр нялхас дэндүү балчир, явж, ярьж чадахгүй, насанд хүрэгсэдтэй харьцуулах аргагүй ч тэд бидний адил амьд бодьгал. Өсөж томроод бидэн шиг болно. Энэхүү домгийн төгсгөлд амьтан ч мөн амьд бодьгал гэдгийг хэлж байна. Ирээдүйд тэд их хичээн бясалгах юм бол бүгд хүн болж төрөөд бүр Будда ч болж болно. Буддагийн зааснаар замнан энэрэл нигүүлсэнгүй байхыг хүсэгч хэн боловч амьтныг идэх ёсгүй.

Дээрх хоёр түүхт гарч буйгаар бид гэгээрчихсэн төрдөггүй. Заримдаа үүнийг хэн нэгнээр тайлбарлуулсны дараа ухаарч ойлгодог юм. Эхний түүхт гарсан эхийг аваад үзье. Хүү нь нас баржээ. Гэсэн ч тэр бусдын хүүхэд ч нэг л өдөр нас барахыг ухаараагүй байна. Хүн бүр насан эцэс болно гэдгийг эмэгтэй ойлгоогүй л байж. Тухайн үед Шагжамуни Будда билэг ухааны үгээр түүнийг тайвшруулах гэж оролдсон гээд бодоод үзье л дээ. “Та яагаад уйлж байгаа юм бэ? Амьдрал зуурдын зүйл гэдгийг та ойлгох хэрэгтэй. Эрт орой хэзээ нэгэн цагт бид бүгд л үхнэ. Хаана шалтгаан байна, тэнд цээрлэл бий. Хэрвээ таны хүүгийн муу үйлийн үр их байсан бол мэдээж хэрэг тэр эрт талийгаач болох ёстой. Учир нь түүний цээрлэл нь бага адислагдсан хэрэг. Тиймээс уйтгарлаж гуниглан уйлах хэрэггүй”. Хэрэв ингэж хэлсэн бол тэр эмэгтэй Буддаг сонсохгүй л байх байсан болов уу. Иймэрхүү нөхцөлд бидний ихэнх маань тайвшруулах иймэрхүү аргыг л мэддэг.

Харин Шагжмуни Будда энэ аргыг хэрэглэсэнгүй. Эхийг шууд л гэрт нь нэг ч үхэл зовлон болоогүй тийм айлыг олуулахаар явуулжээ. Мэдээж түүнд тийм айл олдсонгүй. Яг тэр мөчид Шагжамуни Будда сургаалаа түүнд айлдахад эмэгтэй агшин зуур ухаарчээ. Учир нь эх бядан явах зуураа амьдралтай танилцсан байна. Эхний үед би ч мөн оюун санааны туршлагын талаар ярьдаг байсан. Хэрвээ бид өөрсдөө үнэнийг олж мэдэж чадахгүй бол үнэнийг мэддэг, түүнд хэрхэн яаж хүрэхийг зааж өгөх хэн нэгнийг олох хэрэгтэй болдог. Бид дотооддоо туршлага хуримтлуулсаны дараа өөрөө Үнэнийг ухаарч чаддаг болно.

Жишээ нь, Амитаба судард Шагжамуни Буддагийн тухай: “Амитаба Будда бол хязгааргүй гэрэл гэгээ билээ. Тэрээр үргэлж гэрлээ цацруулж биднийг хамгаалдаг. Амитаби Буддагийн ертөнцөд тиймэрхүү олон дэд ертөнц бий. Тэнд шувууд жиргээд л, туйлын ер бусын хөгжим дуугардаг

гэх мэт гайхамшиг зүйлс олон байдаг. Бид тэр гайхамшигт хөгжмийг сонсоход оюун ухаан маань тайвшран амарч, Будда болоод Гэгээнтнүүдийн нэрэн дээр төвлөрөн уншиж, тэдний сургаалуудыг санаж эхлэнэ”. Будда ингэж сургаж байсныг бид сонссон. Мөн хүмүүс Өрнөдийн Диваажинд очин тэдгээр гайхалтай ертөнцүүд дээр зугаацан цэнгэдэг болохыг ч сонссон. Гэлээ ч дотооддоо өөрийн гэсэн туршлагатай болоогүй цагт бид Өрнөдийн Диваажин гэж яг үнэндээ юу болохыг ойлгож итгэхгүй л болов уу. Тиймээс судар ном уншин, тэднийг тайлбарласан лекц сонсох нь бидний мэдрээгүй оюун санааны туршлага, тэр хүмүүсийн оюуны түвшинг сонсохтой бараг адил. Гэгээрэл болоод үнэнийг ухаарахыг хүссэн хэн ч дотоодын ижил туршлагатай байх ёстой, ядаж л Өрнөдийн Диваажинг хальт харсан байх хэрэгтэй.

Хэрвээ Шагжамуни Будда Яаксаг нэн даруй дуудан ирүүлж: “Бузар булай нүгэл хийн бусдын хүүхдийг идэхээ зогсоо. Эцэг эхчүүдийн зовлон шаналалыг ойлгохгүй байна уу чи? Чиний хийж байгаа үйлдэл чинь буруу. Чи хүмүүсийн сэтгэлийг эмтлэх ёсгүй” гэж зандран тушаасан бол тэрээр түвдэн сонсохгүй л байсан болов уу. Учир гэвэл зүрх сэтгэл нь эмтэрсэн эцэг эхийн сэтгэлийн шарх үнэндээ юу болохыг Якса өөрийн биеэр мэдрээгүй байсан. Тиймээс Шагжамуни Будда тэгэж хэлэхийн оронд хүүхдийг нь нуулгахад Яакса хүүхдээ алдахын зовлонг үзсэн. Дараа нь Будда түүнтэй ярихад нэн даруй ойлгожээ. “Өөрөө эцэг эх болж байж л эцэг эхээ бүрэн ойлгодог” хэмээн олны дунд хэлэгддэг шүү дээ.

Багшийн хошигнол

Хоёрын ухаан Нэгийнхээс дээр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, 2003 оны 2-р сарын 3
Флорида, АНУ (Англи хэлээр) Видео хуурцаг№755

Нэгэн өвөө үе тэнгийнхээ эмээтэй болзсоор 5 жил болж гэнэ. Өвөө нэг өдөр гэрлэхээр шийдээд түүнд хэлэхэд даруй зөвшөөрчээ. Маргааш өглөө өвөө сэрээд: “Миний саналыг тэр баяртай хүлээж авлуу ялалаа? Тийм байх аа. Үгүй ээ, над уруу нэг л сонин хараад байсан даа” гэхчилэн уймарч, эмээгийн хариуг яаж ч бодоод санасангүй.

Санах гэж цаг гаруй мунхаглаад эмээ рүү утасдав. Жаахан ичгэвтэр байсан ч өвөө зориглон түүний за, үгүй, яг ямар хариу хэлснийг ер санахгүй байгаагаа дуулгахад эмээ: “Ашгүй чи утастдаг нь сайн боллоо. Тийм ээ, би хэн нэгэнд За гэснээ санаад байгаа хирнээ чухам хэнд зөвшөөрснөө ер санахгүй байсан юм” гэжээ.

Бидэнтэй хэрхэн холбогдох вэ

Их Багшийн телевиз
мэйл хаяг: Info@SupremeMasterTV.com
Утас: 1-626-444-4385 / Факс: 1-626-444-4386
http://www.suprememastertv.com/

Үзэсгэлэнт ертөнцөөр аялахуй нэвтрүүлгийн видео бичлэг
E-mail: TV@Godsdirectcontact.org

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хэвлэлийн компани
мэйл хаяг: smchbooks@Godsdirectcontact.org
Утас: 886-2-8787-3935 / Факс: 886-2-8787-0873

Интернэт дэлгүүр
Вэб хаяг: http://www.thecelestialshop.com

Book Department
мэйл хаяг: divine@Godsdirectcontact.org
Факс: 1-240-352-5613 or 886-949-883-778
(Та бусад хэлээр Их Багшийн номыг орчуулахад туслаарай.)

Мэдээний баг
мэйл хаяг: lovenews@Godsdirectcontact.org
Факс: 1-801-740-9196 or 886-946-728-475

Бясалгалын асуулт хариултын баг
мэйл хаяг: lovewish@Godsdirectcontact.org
Факс: 886-946-730-699

S.M. Celestial Co., Ltd.
мэйл хаяг: smcj@mail.sm-cj.com
Утас: 886-2-8791-0860 / Факс: 886-2-8791-1216
http://www.sm-cj.com/

Арга хэмжээний хуваарь

Дэлхийд явагдаж буй оюун санааны дэвшлийг хадгалан цааш үргэлжлүүлэхийн тулд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг видео лекц мөн Үнэн Ёсыг хуваалцах арга хэмжээг илүү ихээр зохион байгуулж байна.

Та бүхэн энэхүү арга хэмжээнд найз нөхөд, хамаатан саднаа авч ирэхийг урья. Энэхүү арга хэмжээний сүүлийн үеийн хуваарийг доорх хаягаас авч үзнэ үү:

http://www.Godsdirectcontact.org.tw/eng/latest_news/events-datebook.htm

Дотоодын Үнэнд гадаад хил хязгаар гэж үгүй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвэр, Лондон, Англи 1999.06.09 (Англи хэлээр) Видео хуурцаг № 662

А: Энэ ертөнц дээрх бүх түвэгтэй асуудал нь ганцхүү Эзэн Бурханаас тусгаарлагдсанаас үүдэлтэй гэдэг нь үнэн болов уу?

Б: Тиймээ, бид хоёр талтай ертөнцөд амьдардаг. Тийм болохоор л бид худал хэлж, хуурч, бусдыг алж байдаг. Учир нь "Тэр надаас өөр юм" гэж боддогт байгаа юм. Энэ бол энэ ертөнцийн хоёр талт хүч нь нөгөө хүн биднээс арай өөр гэж бодоход хүргэн төөрөгдүүлдэгт байгаа юм. Өөрийн ноёрхолоо тогтоохын тулд арьсны өнгө, үндэсний хил хязгаар, өөр үзэл бодол гэхчилэн өөр ондоо юм эрж олж түүнээ устгадаг.

Өөр хоорондоо болоод Эзэн Бурханаас тусгаарлагдаж суухын оронд өөрийнхөө дотоодод нэвтэрч, улмаар "бүгд нэг" гэсэн үнэнийг мэдэх хэрэгтэй. Зөвхөн дотооддоо л үүнийг би танд баталж чадна. Гадна тал болох арьсны хар өнгийг баллуурдаж, Англи, Франц хоёр орны хил хязгаарыг арилгаж би чадахгүй. Харин та нар ижил мөн чанартай, бид бүгд ганц эцэгтэй гэх үндсэн мөн чанарыг би танд дотооддоо үзүүлж чадна. Түүний нэрийг хэн ч гэж дуудаж болох ч бид түүнийг "Эзэн Бурхан" гэж дууддаг.

Эзэн Бурхан бол бүхнийг эдгээгч

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвэр, Эдинбург, Шотланд
1999.06.05 (Англи хэлээр) Видео хуурцаг № 648

А: Би хүсэл тачаалаа хэрхэн хянаж сурах вэ?

Б: Хянасны хэрэггүй. Хичнээн хянахыг оролдоно, төчнөөн их хүсэл тачаал таныг тамд ч, диваажинд ч хөөх болно. Ердөө Эзэн Бурханыг л амьдралдаа урьж зал. Өдөр бүр тууштай бясалгаж Их Эзэн Бурхан, илүү их Гэрлийг амьдралдаа дуудан авчир. Тэгсэн цагт л хүсэл тачаал таныг орхих болно. Тэгсэн ч хүсэл тачаал байсаар байвал Эзэн Бурхан хүсэл тачаалыг тань өөрчлөх замаар таныг гэгээрүүлнэ. Тэр аль хүсэл тачаал нь илүү дээр болохыг таниулж таныг адислах болно. Тиймээс энэ дэлхийгээс явах цагт нүглээ жигнэхэд хэрвээ та доогуур дэсэд байж гэмээнэ өөртөө буруу өгсөний хэрэггүй. Эзэн Бурхан л бүхнийг эдгээдэг, өвчинг ч анагаадаг юм.

Гэрэл, Аялгуу бол Эзэн Бурхан юм

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвэр, Малайз, 1992.02.25
(Англи хэлээр) Видео хуурцаг № 219

А: Бид Гэрэл, Аялгуугаар дамжуулж Эзэн Бурхантай холбогддог гэж та айлдсан. Хэрэв бид тэрхүү Гэрэл, Аялгууг гаргаж гэмээнэ Эзэн Бурхантай хэрхэн яаж холбогдох вэ ?

Б: Та нар тэр Гэрэл, Аялгууг гаргана гэсэн үг биш. Гэрэл, Аялгуу бол Эзэн Бурхан өөрөө юм. Та түүнийг гаргаж чадахгүй. Хүн төрөлхтөн тэднийг гаргаж чадахгүй. Тэр бүхэн зөвхөн Эзэн Бурханаас л ирдэг. Гэрэл, Аялгуу бол Эзэн Бурханы давтамж, мөн Эзэн Бурханытөлөөлөл юм. Бид тийм төрлийн Аялгуу, тийм төрлийн Гэрэл гаргаж чадахгүй. Хичнээн их мөнгөөр худалдаж авъя гэсэн ч, та хичнээн ухаантай байсан ч хамаагүй тэр бол боломжгүй зүйл юм. Учир нь Гэрэл Аялгуу бол зөвхөн авшиг өгөхөд л дамждаг.

Зөвхөн өндөр түвшний Диваажингаас л ирдэг. Тэр бас таны дотоодод байдаг зүйл.

А: Тэгвэл авшиг авах үед л Эзэн Бурхантай холбогдож Гэрэл, Аялгуу бид өөрсдөө гаргаж чадна гэсэн үг үү?

Б: Бид түүнийг гаргадаггүй. Тэд таны хичээл зүтгэлгүйгээр цаанаасаа өөрөө ирдэг юм. Тэр бол Эзэн Бурхан өөрөө юм. Библи судрт "Анх эхлээд Авиа оршиж, тэр Авиа Эзэн Бурхантай хамт байв. Тэрхүү Авиа бол Эзэн Бурхан мөн" гэсэн байдаг. Тэр л авиа, аялгууг бид дотооддоо сонсдог. Тэр бол Эзэн Бурхан өөрөө юм. Тэр бол бидний жинхэнэ мөн чанар юм. Энэ нь бид түүнийг гаргах ёстой гэсэн үг биш. Та гэгээрэх тэр л агшинд ойлгох болно. Тэр л агшинд та түүнтэй холбогдох юм. Одоо бол зөвхөн онол. Урьд өмнө энгийн амьдралдаа мэдрээгүй юмыг хийсвэрлэн ярих нь тийм ч амар биш.

Диваажинг харсаны баталгаа

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Лондон, Англи,
1999, 06, 9 (Англи хэлээр) Видео хуурцаг № 662

А: Та диваажинг зүгээр нэг хуурамч үзэгдэл биш харин Диваажин мөн гэдгийг яаж мэддэг вэ?

М: Та эхнэрээ мэддэг шиг л би Диваажинг мэднэ. Хэрвээ эхнэр шигээ тийм хонгорхон, тийм ч тодорхой мэддэггүй ямар нэгэн хүн, юм байлаа гэмээнэ танд хачин санагдана биз дээ. Тэгвэл бид бүгд Диваажингаас ирсэн. Диваажин харагдах тэр мөчид л бид түүнийг мэдэх болно. Энэ бол их хялбархан зүйл. Би та нарт галзуу юм шиг харагдаж байна уу? (Сонсогчид: Үгүй). Тэгвэл би Диваажинг харсан л байж таараа, эсвэл өөр юу гэж. Хэрэв буруу бусармаг зүйл хийн, гаж сонин зүйл ярин, биеэ ч итгээд сонин авч явдаг хүн бол яах аргагүй тэр галзуу солиотой хүн мөн. Харин Диваажинг хардаг хүн бол амьдрал, хайр, аз жаргал болоод сайн сайхан энергийг оргилуулж байдаг. Бид юмны зөвхөн гадна талыг л харан шийддэг.

Хамт бясалгахаараа үүнийг би танд дотоодод тань баталж өгч болно. Гадна ертөнцөд та их л олон юм хардаг. Хэрэв билгийн нүд тань нээгдвэл биднийг эргэн тойрон гэрэл хүрээлж байгааг харна. Биднийг хүрээлсэн Гэрлийг харж байгаа хүн байна уу? Тийм үү? Сонсогчдын дундах нэг хүн уруу заалаа. Их баярлалаа. Тийм үү?
Их Багш дараагийн хүн уруу заалаа. Сайн байна. Та авшиг аваагүй юу? Баярлалаа, Эзэн Бурхан минь. /Их Багш хошигнож байна/. Тиймгүй бол би танд тэгэж хэлээрэй гээд урьдаас хэлчихсэн гэж бодоцгооно шүү. Та намайг анх удаа харж байна уу? Баярлалаа. Тэр намайг анх харж, мөн энэ махан биеийг тойрон гэрэлтэх Гэрэл олж харж байна.

Гадна талд гэрэлтэх Гэрэл харж чадаж байгаа юм чинь дотоодын гэрэл ямар байх бол хэмээн төсөөлж та нар чадаж байна уу? Яг л тэр хүн шиг бай. Гэрэл таны дотор байна. Та ч бас харж чадна. Би, та нар бүгд адилхан. Би тантай ижил зоог барьж, ижил зүйл хийдэг. Тэгэхээр бид цөм Диваажинд хүрч чадна. Өнгөрсөн үеийн гэгээнтнүүдийг тойрон тод Гэрэлт цагираг гэрэлтэж байдаг гэж

Залбирал ба Бясалгал

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Лондон, Англи, 1999, 06, 9 (Англи хэлээр) Видео хуурцаг № 662

А: Залбирал, бясалгал хоёрын ялгаа юу вэ?

Б: Би та нарт хэлье. Залбирал гэдэг нь Эзэн Бурхан, эвэл Диваажин бидний гадна талд оршдог хэмээн үздэг хүмүүсийг хэлнэ. Бясалгал бол таны дотор Эзэн Бурхан байхыг харсан, шууд асуулт асууж, эсвэл шууд сургаал хүлээж авахыг хэлдэг. Бид Эзэн Бурханыг хараахан мэдээгүй, бид шууд холбоо байхгүй. Түүнийг дуудсаар л байх үед залбирал их чухал байдаг. Харин бясалгал бол та Эзэн Бурханы сургаалыг хүлээн авч, Түүнээс шууд зөвлөгөө авах явдал юм. Жишээ нь, та юуны төлөө голдуу залбирдаг вэ? Дэлхийн энх тайвны төлөө юу? Өөрийнхөө дотоодод уу? Учир нь танд амар амгалан хараахан байхгүй учраас л үүний төлөө залбирах хэрэгтэй болдог. "Эзэн Бурхан минь ээ, та надад амар амгалан хайрлаач, амар амгалан хайрлаач"

хэмээн та нар гуйдаг.

Би бусад бясалгалын талаар мэдэхгүй л дээ. Би туршиж үзсэн юм. Харин энэ бясалгал бол агшин зуур амар амгаланг өгдөг цорын ганц бясалгал юм. Энэ бясалгал их хүчтэй. Тиймээ. Яагаад гэвэл та нар Эзэн Бурхантай шууд холбогддог. Та нарын Түүнтэй холбогддог утсан холбоо дахин нээгдэж засварлагддаг. Харин одоо бол та нар болоод Эзэн Бурханы хоорондох холбоо хаагдчихсан ч юмуу гэмтчихсэн байгаа. Эзэн Бурхан хэдийгээр юу хийхийн тань зөв хариултыг нь хэлэхээр тань руу залгадаг боловч та сонсдоггүй. Тэгээд л та нар залбирах л хэрэгтэй болдог. Магадгүй та нарын залбирал биелдэг байж болно. Эсвэл заримдаа биелэхгүй ч байж магадгүй. Учир нь өмнө хэлсэнчилэн Эзэн Бурханыг сонсдоггүйтэй холбоотой. Жишээ нь, та нар зөвлөгөө авахаар надад ханддаг. Гэтэл та нар цаг үргэлж л "Өө, Чин Хай, Чин Хай, Чин Хай" гээд л дуудаад байдаг. Тэгэхээр чинь би та нарт яах ёстойг чинь хэлж өгч чаддаггүй. Хэрэв та чимээгүй байх юм бол би та нартай харилцаж чадна.

Би та нарыг яаж чимээгүй байхыг сургаж байгаагийн адилаар Эзэн Бурхан мөн тэгж хэлэхийг та нар сонсох болно. Та залбирах ч хэрэггүй. Тэр бүхнийг мэдэж байгаа. Библийн сударт: "Та нарыг залбирахаас чинь өмнө Эцэг минь бүхнийг мэддэг" гэсэн бий. Энэ бол зөвхөн Эзэн Бурхантай холбогдсон авшигтнуудад л хамаатай.

Амар амгалан болон Аз жаргалыг ахуй ойлголтоороо олж авах нь зүйтэй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Айлдвар, Флоридагийн бясалгалын төвд болсон 4 өдрийн даяан, АНУ, 1999, 02, 15 (Хятад хэлээр) Видео хуурцаг № 635 I-р хэсэг

А: Сайн байна уу, Их Багшаа! Өдөр бүр Танаас би их хайр, адислал хүлээж авдаг. Үүнийхээ төлөө их талархаж явдаг. Гэсэн ч Гэрэл, Аялгуу ажин бясалгаж байхад Таны ярьсан ахуй ойлголтууд надад байдаггүй. Магадгүй оюун санаа минь завгүй үргэлж материаллаг зүйл дээр байнга төвлөрөөд байгаа учраас тэр үү. Энэ нь дотоодын оюун санааны бясалгалд маань нөлөөлж байгаа юм болов уу?

Б: Тиймээ. Тийм зүйл нөлөөлнө. Гэсэн ч та амар амгалан, аз жаргалтай байгаа бол зүгээр гэсэн үг. Энэ бол цэвэр бясалгалын тань үр дүн.

А: Гэхдээ надад ямар нэгэн онцгой ахуй ойлголт ер байдаггүй.

Б: Зүгээр дээ. Магадгүй та тэр мөчид унтчихсан байж болох шүү дээ. Жаахан амсхийгээд авах нь тийм ч муу юм биш. Хэрвээ гадна ертөнц дээр л сайн үр дүн гарч байгаа бол сайн хэрэг. Таны гэдэс хоосон бол бие махбодь тань хэрхэн яаж үүргээ гүйцэтгэх билээ дээ? Гадна ертөнц дээр та их амар амгалан, адислагдаж байгаагаа мэдэрч л байгаа бол энэ чинь харин та бясалгалаа сайн хийж байгаа гэдгийг харуулж байгаа юм. Ердөө л үргэлжлүүлээд бясалгаад бай. Хүн бүр л өөр өөрийн мэдрэмж болоод ахуй ойлголттой байдаг. Миний хувьд бол гадна ертөнц дээр амар амгалан, аз жаргалтай байгаагаа дотоодын ахуй ойлголтгүй байхаас илүүд үзнэ. Учир нь бясалгал хийх бүрдээ Диваажинд очоод, харин Самадигаас гармагцаа бид тамд ирчихсэн юм шиг санагдана. Тэгвэл ямар утга байна. Бид зөвхөн хэдхэн цаг л бясалгадаг. Өдөрт хоёр цаг хагас бясалгаж байгаа маань бидний Диваажинд өнгөрүүлж буй ахархан хугацаа юм. Үлдэж байгаа хорин нэг гаруй цагт нь бид тамд байдаг. Тэгвэл бид яаж амьдрах болж байна аа? Энэ чинь ямар сайн байхав дээ. Ийм болохоор бид даруухан ахуй ойлголттой байсан нь дээр. Магадгүй ахуй ойлголт орж ирэх үед нь та нар унтчихдаг байх. Тэр хамаагүй. Дажгүй. Юутай ч та аз жаргалтай хүн л сэрж байвал боллоо.

Хэрвээ бясалгалаар тань дамжиж амлалт ирсэн бол Эзэн Бурхан түүнийгээ мэдээд та нарыг адислах болно. Хувь заяа маань маш чухал. Бид хэтэрхий хичээн бясалгадаг. Энэ нь ердөө сул дорой болохоор доошоо уруудчихвий гэж болгоомжилдогтой маань холбоотой. Цаг нь ирмэгц хичээж байгааг тань Эзэн Бурхан мэдэж байгаа болохоор биднийг алгуурхан түлхэж өгдөг. Тиймээс дотоодынхоо түвшин болоод ахуй ойлголтондоо санаа зоволтгүй. Хэрвээ та нарт ахуй ойлголт байгаа бол зүгээр хэрэг, байхгүй бол бас зүгээр ээ. Бид хэт ихийг хүсвэл ахуй ойлголт маань чамламаар харагдана. Энэхүү “хүсэмжлэл” мөн л энэ ертөнц болоод оюун бодолд хамааралтай нэгэн төрлийн дур тачаал. Энэ бол бясалгалын сайн сайхан зүйл огт биш.

ХАЙР бол өндөр соёл иргэншлийн үндэс

Авшигтан номын эгч, Формоса (Хятад хэлээр)

Одын хүүхэд Ами" номыг хэвлэгдсэний дараа "Ами эргэн ирсэн нь" ба "Дотоод хөгжингүй ертөнцүүд" нэртэй цувралууд нь ард ардаасаа хэвлэгдлээ. Эдгээр номонд Ами найз Петерийнхээ хамт өөр гарагуудаар аялан явахдаа Винка гэгч шинэ найзтай болж өөрийнхөө гарагт авчирч байгаа болон орчлонгийн хайрын мөн чанарыг гүнзгий ойлгон ухаарч буй үйл явдал гарна.

Хайрын Мөн Чанар

Амигийн энэ хоёр номонд Хайрын үнэ цэнийг дахин онцлон дурджээ. Хайр нь хувьсал хөгжлийн хэмжүүр юм. Бид хэдийчинээ дээшлэн хөгжинө төдийчинээ хайр руу ойртоно. Хайр зөвхөн хүч, хэлбэлзэл, энергийн эх үүсвэр төдийгүй түүний үр жимс нь болох аз жаргалын үндэс болдог.

Бурхан бол хайр юм. Бурхан энэ ертөнц дээр чулуу, хүн, од, үүл,... гэх мэт зүйлсээр харагддаг тул бид Бурхан ертөнцийг бүтээсэн гэдэг. Хэдийгээр бид Бурхан өөрөө биш боловч далайн усны нэг дусал ч далайн нэг хэсэг байдаг шиг бид Бурхны нэг хэсэг юм. Түүнчлэн "бид Бурхны хайрын оч" ч гэдэг.

Амьдралын нэгэн төрөл болох Сүүн Зам ба оддыг оролцуулаад ертөнц дээрх бүх зүйл амьтай байдаг. Орчлон ертөнц бүхэлдээ амьд биет юм. Хөгжлийн өөр өөр түвшингийн хооронд орших шүүлтүүр нь таагүй зүйлсийг хаах ба сүйрлээс сэргийлдэг. Хувьсал хөгжил бол бидний хэлбэлзэлийн давтамжийн өсөлт болон бидний жинхэнэ мөн чанар болох хайрыг буцаан авах явдал юм.

Хэдий тийм боловч хайр өөр өөрөөр тайлбарлагддаг. Нэг төрлийн хайр нь бүх дэлхийн хайр болох Бурхны хайр. Нөгөө төрлийнх нь хязгаарлагдмал хайр ба хэдийгээр энэ нь хайр мөн боловч дээд түвшнийх биш юм. Ийм хайр хүнийг холын хараагүй, зөвхөн өөрийгөө болон амьдралд нь холбоотой хэдхэн хүмүүсийг харж хандлаг явцуу болгодог. Хэрвээ ийм хайр хэтэрхий даамжирвал хүмүүс хэрэг төвөгт орооцолдох болон дайн гарч ч болзошгүй юм. Үүнээс гадна дэлхийн шинжлэх ухаан, технологийн түвшин нэг нэгийгээ хайрлах

хайраас илүү өндөр түвшинд байвал биетүүд бие бие рүүгээ дайран өөрсдийгөө устгаж болзошгүй болдог. Хайр бол гараг эрхсүүдийг сүйрлээс сэргийлэх цорын ганц хүч учраас хайрыг соёл иргэншлийн үндэс хэмээн дээдлэн хүндлэх ёстой.

Гариг Эрхсийн Хөгжлийн Үе Шатууд ба Дэлхийн шилжилт

Энэ номны өөр нэг гол сэдэв бол гараг эрхсүүдийн хөгжлийн үе шатуудыг тайлбарласан хэсэг юм. Нэгдүгээр шатанд амьд биет байдаггүй. Хоёрдугаар шатанд байгаа амьд биетүүд хүнээс өөр хэлбэртэй ба гуравдугаар шатанд хүмүүс харагддаг. Харин дөрөвдүгээр шатанд хүмүүс хоорондоо нэгдэж нэгэн том гэр бүл шиг болоод хайрыг амьдралын зарчмаа болгодог байна.

"Оддын хүүхэд Ами" номон дээр ертөнц дээр манай Дэлхийтэй төстэй сая сая соёл иргэншил байсан болон тэд нэгэн цагт шалгуурыг давж чадалгүй устсан тухай Ами дурсдаг. Дэлхий дээр байсан Атлантчууд тэдгээрийн нэг байсан ба тэд маш өндөр хөгжсөн технологитай байсан боловч тэдний хайр, билэг ухаан хангалттай хөгжөөгүй байжээ. Энэ оньсон дайн Дэлхийг ноцтой гэмтээж бүх зүйлс дахин эхнээсээ эхлэхэд хүргэжээ.

Мөн эдгээр номонд гараг эрхэс ямар үед дээшилдэг тухай бичсэн байдаг. Газар хөдлөлтийн шалтгаан болдог Дэлхийн дотоод өөрчлөлт гэх мэт зарим ойлгомжгүй гоц үзэгдлийн нөлөөгөөр дээшлэлт явагдаж байдаг. Дээшлэх үедээ тухайн гараг илүү нарийн, илүү өндөр түвшний хэлбэлзэлтэй шинэ энерги гаргана. Энэ ялгаран гарч буй цацраг туяа нь хоёр үр дагавартай байдаг. Үүний хэлбэлзлэл нь хөгжлийн дээд түвшингүүдэд байгаа биетүүдийн түвшинг цааш дээшлүүлж харин доогуур түвшний биетүүдийн бодох чадварыг алдагдуулж эцэст нь тэднийг үхлийн алдаа хийн өөрсдийгөө устгахад хүргэдэг байна.

Энэ номон дээр бичсэнээр Дэлхий энэ цаг мөчид хөгжлийн гуравдугаар шатнаас дөрөвдүгээр шат руу шилжин бүх дэлхийн од гарагийн холбоонд нэгдэх үедээ явж байгаа юм. Ертөнц дээрх бүх юмс харилцан үйлчлэлтэй учраас хэрвээ нэг гараг устлаа гэхэд бусад өндөр түвшний гарагуудад нөлөөлдөг. Тийм болохоор бүх дэлхийн од гарагийн холбоо нь шилжилтийн шатанд явж байгаа гарагуудад туслахаар чадах бүхнээ хийнэ. Хэвлэгдэн гарсан болон шинээр гарах Амигийн цувралууд нь энэ тусламжийн нэг хэсэг болох бөгөөд хүн төрөлхтний ухамсрыг сэргээх гэсэн оролдлого юм.

Үхлийн Мөн Чанар ба Амьдралын Үнэн Амлалт

Эдгээр хоёр номонд үхлийн тухай ойлголтыг гүнзгий авч үздэг. Үнэн хэрэгтээ үхэл гэж байдаггүй. Доогуур хөгжилтэй ертөнц дээр хүмүүс бие цогцсоо солихдоо өмнөх амьдралын ой санамжаа хадгалж чаддаггүй. Энэ нь тэдэнд "үхэл"-ийн тухай буруу ойлголт төрүүлдэг. Хүн төрөлхтөн төгс төгөлдөрт ойртохын тулд янз бүрийн туршлага, нөхцөл байдал, газар орон, дүр, бодлоор өөрсдийгөө хөгжүүлэн суралцсаар иржээ. Хэдийгээр тийм боловч тэд ямар нэг юманд хүлээслэгддэг учир үхэл л тэднийг өөр оршихуйд зорчин суралцах цорын ганц зам нь болдог. Энэ хүлээсийг бид давж гарахгүй бол бид ой санамж, хүлээснээсээ хүчээр салгагдаж шинэ ой санамж эхлэх болдог.

Өндөр хөгжилтэй гаригуудад хүмүүс биеийхээ эсийн хөгшрөлтийг удаашруулж чаддаг байна. Мөн тэд саруул ухаан, бүх ой санамжаа хадгалсан хэвээр сүнсээ яаж хуучин биенээсээ шинэ биенд шилжүүлдгийг мэддэг ажээ. Тэдэнд хаая нэг хэрэггүй хүлээс байдаг ч үхлийн зовлонт үйл явцыг дамжилгүй өмнөх амьдралынхаа ой санамжаа хадгалсаар шинэ ертөнцөд идэвхтэйгээр алхан ордог байна. Ямар нэгэн гараг сав бүх дэлхийн од гарагийн холбоонд нэгдэн орох үед тэр гарагийн биетүүд

бусад өндөр хөгжилтэй гарагийн биетүүдээр мөнхийн амьдралын нууцыг заалгадаг. Тиймээс хөгжингүй соёл иргэншилт ертөнцийн хүмүүст мөнхийн амьдрал нь үнэн бөгөөд баталгаатай байдаг байна.

Дээр бичсэн өгүүлэл нь Амигийн цувралын хоёр, гуравдугаар номны хэсгээс авчээ. Эдгээр номны гайхамшигтай утга агуулга нь Их Багшийн сургаальтай яг давхцаж байгаа юм. (Их Багшийн 163-р сэтгүүл дээрх “Бүх Дэлхийн Хөгжлийн Хурдыг Гүйцэх нь” нэртэй Дэлхийн шилжилтийн тухай өгүүлсэн хэсгээс үзнэ үү.) Бид Дэлхийн шилжилтийн үеийн гэрч болж Алтан Үед амьдарч байгаа азтай хүмүүс төдийгүй Агуу Их Оюун Санааны Удирдагч Чин Хай багшаараа жолоодуулан түүний хязгааргүй хайраар урагшлан дэвшиж эх Дэлхийгээ дээшлэн хөгжихөд тусалж байгаа хосгүй заяатай хүмүүс юм.

* 166-р сэтгүүлийн “Номны танилцуулга” бүлэг дээрх “Оддын хүүхэд Ами”-нэгдүгээр номны тухай бичсэн хэсгээсүзнэ үү. (Энэ номыг 2006 онд зохиогч нь дахин бичиж одоо “Оддын Орноос”нэртэй болсон.)

Онч мэргэн үгс

Гараг хоорондын харилцаа холбоонд бэлдэцгээ

Цаглашгүй Их Багш Чин Хайн айлдвар, Сингапур, 3 сарын 3, 1992, (Англи хэлээр) Видео хуурцаг №223

Үүнийг бид л хийнэ. Магадгүй ирээдүйд бид бүхэн арай өргөн хүрээтэй бодож сэтгэдэг болох буюу зөвхөн өөрийнхөө байр сууц, амьдардаг тосгон, улс орныхоо тухай аминчлан бодохын оронд сансар огторгуй, сав ертөнцөд санаа тавьдаг болж, оюун ухааныхаа цар хүрээг тэлэн өргөжүүлж, тэгснээр газар дэлхийн ухамсар тэр чигээрээ дээшилж соёлох байх. Тэр үед бид гараг хоорындын харилцаа холбоонд бүрэн бэлтгэгдэж, илүү их юм сурч мэдэж, хурдан хөгжиж, цаашилбал илүү ая тухтай амьдардаг болох биз ээ. Бидний хүссэн бүхэн биелж, байгаагаа бусадтайгаа хуваалцан, бусад гарагууд ч байгаа бүхнээ бидэнтэй хуваалцан амьдрал маань сайжирч, үр хүүхэддээ сайн сайхан амьдралыг цогцлуулж өгнө. Энэ бүхэн биелнэ! Хамгийн гол нь өөрсдийгөө ийнхүү уужим бодож сургах хэрэгтэй юм. Энэ бол соёлтой хүний шинж.

Эртний соёл иргэншлүүдийн Нээлттэй орон зай

АНУ-ын мэдээллийн баг (Англи хэлээр)

Олон хүн эртний соёл иргэншлүүдийг болхи бүдүүлэг гэж боддог. Гэсэн ч -Египетийн пирамид, Төв болон Баруун Америк дахь эртний соёлын үлдэгдлүүд, Их Британийн Stonehenge зэрэг нь уран барилгын орчин цагийн өндөр гэгдэх технологи, инженерийн мэдлэгээр ч барьж босгоход хялбар бус гэдгийг бид мэднэ. Эдгээр барилгыг барихын тулд тэдгээр аварга том хавтангуудыг яаж тайрч, хэрхэн зөөн тээвэрлэж, яаж хамтад нь байрлуулсан бол гэж бодож байсан уу? Тэдгээр чулуунуудыг цахилгаан хэт авиагаар зүсэж, газраас дээш тусгай төхөөрөмжөөр зөөсөн байх гэж боддог. Багш нэгэн айлдвартаа: ”Бид сөрөг замыг дагах дур сонирхлоосоо болоод олон соёл иргэншлүүдийн газар дор нуран унасан баталгааг харж уншсаар байна. Түүх энэ бүхнийг баталдаг. Өнөө үед бидний соёл иргэншлээс хавьгүй илүү гайхам, сүр жавхлантай эртний хотуудын олон нээлт байгаа. Тэд соёл иргэншлийн маш өндөр түвшинд хүрсэн, мөн эрчим хүч механикийн хөгжлийн оргилд нь хүрээд сөнөсөн. Тэд Бурханы зааснаар замнаагүй, амьдралын зөв зарчим баримтлаагүй, тэгээд л доошилсон хэрэг. Энэ бол манай үеийнхэнд төдийгүй дараа үеийнхэнд том сургамж болох ёстой /Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн айлдвар, Формоса, Шихү, 1992 оны 5-р сарын 8/ тэмдэглэсэн. Багш мөн эдгээр соёл иргэншлүүд хэрхэн орших болсон тухайд ”Маш урт удаан хугацаанд дээд ертөнцүүдийн хүмүүс бидэнд зааж сургахаар дэлхий руу ирсэн. Зарим нь дундаж түвшнээс, зарим нь арай өндөр түвшнээс, зарим нь хамгийн өндөр түвшнээс ирцгээсэн. Дундах түвшний төрөлтнүүд бидэнд хэрхэн дэвшилтэт тоног төхөөрөмж, механизмыг бий болгох, далдын хүчээ хэрхэн ашиглах зэрэг тав тухтай, баян, соёл иргэншилтэй амьдрах боломжийг заасан. Сүр жавхлант эрин үеүдэд газар дэлхий дээр дундаж түвшний ертөнцийн багш нарын хичээлийн үр дүн болох Атлантидын гэх мэт эрин үеүд ноёлж байсан. Өнөө үед манай дэлхий машид иргэншиж, орчин үеийн археологичид тэр соёл иргэншлүүдийн ул мөрүүдийг олж байна /Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Япон, Токио, 1992 оны 3-р сарын 4/ гэж айлдсан. Бидэнд эртний гайхалтай соёл иргэншлүүдийн тухай илтгэж байдаг нээлтүүдийн цөөн жишээг дор дурдаж байна. Эдгээр

нь бидэнд чимээгүй үлдцээрээ чухал сургамж хайрлаж байдаг юм.

Гиза пирамид

Египетэд сүндэрлэх энэхүү сэтгэл татам барилга дэлхийн долоон гайхамшгийн нэгэнд тооцогддог нэн эртний гайхамшиг юм. Пирамид нь тэгшилж тайрсан шохойн болон боржин чулуун хавтангуудаар баригдсан байна. Хавтан тус бүр нь 2-15 тонн жинтэй. Тооцоолсноор нийт 2.4 сая хавтан орсон байна. Пирамидын дөрвөн талын 750 тохой урт суурь нь алдаа гэмээр зөвхөн 58 мм /ойролцоогоор 2 ямх/ өргөнтэй тэнцүү дөрвөн өнцөгтөөс нэг өнцөг хазайсан гэх мэт маш уран нарийн хийцтэй. Суурийн дөрвөлжний талуудыг дөрвөн ординат луужин хэлбэрийн /нуман 300/ ирмэгүүдээр зэрэгцүүлэн соронзон орны хойд зүгт байрлуулсан. Тэр үед агуу пирамидын гадна талыг налуу цагаан чулуунууд, хавтгай бортгон чулуунуудыг цагаан шохойн чулуугаар өнгөлж хийжээ. Эдгээр эртний соёл иргэншлүүдийн зарим бүтээлийг орчин үеийн шинжлэх ухаан, технологийн хөгжил дэвшилтэй харьцуулахад өвөрмөц. Пирамидын цагаан чулуунууд хатааны маш өндөр нарийвчлалтайаар бүтэн гадаргуугийн талбайн зөвхөн 1/50 ямхаар зүсэгдсэн байна. Орчин үед холбооснуудынх завсраар хутганы үзүүр ч орохооргүй бүгдийг нь хамтад нь төгс тогтооосон байдаг. Хойд талын нүүрний хэсэгт пирамид уруу орох хаалга бий. Хааны бунханд аваачих болоод бусад үйл ажиллагаанд зориулагдсан тоо томшгүй олон хонгил, гудам, нүдэнд үл өртөх цооногууд байдаг. Хааны бунхан пирамидын гол төвд байдаг бөгөөд тийшээ дээд давхрын хонгилоор уруудаж очдог. Хамгийн гайхам зүйл нь хааны бунхны хаалганд хүрэх замыг 3м урт, 2.4м өндөр,1.3м өргөнтэй хурц үзүүрлэсэн чулуугаар халхалсан явдал юм. Дотор чулуунуудыг завсраар нь цаас ч хавчуулж боломгүйгээр маш сайн тогтоосон байдаг.

Египтын пирамид

Инкагийн хант улс

Инкагийн соёл иргэншил нь Өмнөд Америкийн бүс нутаг буюу одоогийн Перу улсын нутаг дэвсгэр дээр байрлаж байсан бөгөөд Колумб ирхээс өмнөх үеийн хамгийн том хант улс байжээ. Тэр үед түүнтэй эн зэрэгцэх өөр соёл байгаагүй аж. Инкачуудууд энженер, уран барилагчид гэдгээрээ алдартай билээ. Тэд уртаараа 23,000 километр үргэлжлэх замыг барьж байгуулсан бөгөөд түүнийгээ байнга засаж сэлбэдэг байсан байна. Энэхүү цам нь холбоо барих, хүмүүс зорчих, бөс бараа тээврэлэхэд дөхөм болодог байжээ. Андэс уулан дахь олон эгц хавцалыг гатлахын тулд тэд гайхалтай гүүрүүдийг барьж байгуулсан байдаг. Мөн тэд олон газарт уулын хажуу талаар нарын зам барьж хоол хүнсний тээвэрлэлтийг хурдасгасан байдаг байна.


Игкагийн чимэзгүй хот холох Мачу Пиччүг харуулж байна.

Тиотихоукан

Тиотихоуканы Нарны пирамид, Мексик

Тиотихоукан нь эртний хот Мексикийн Хайландын Мексик хотод оршдог, Нарны Пирамид /дэлхийн гуравдагч том/ ба түүний дүү барилга болох Сарны пирамид хоёрын хэмжээтэй. Энэ нь уран зураг, ханын зургаараа хосгүй ба эндээс олдсон зургуудад хүчирхийлэл, харгислал мэт зүйл огт дүрслэгдээгүй, тэд нийгмийг одон орон, тухайн үеийнхээ оюун санааны бэлэг тэмдгүүдээр илүүтэй дүрсэлсэн байдаг. Энэ хот олон зууны турш өндөр хөгжсөн төв байхаар төлөвлөгдсөн болтой. Гэсэн ч нуран унаснаасаа хойш дахин өмнөх нэр хүндээ олж аваагүй юм. Үүнийг хэн барьсныг хэлж мэдэхгүй. Одоогийн нэрлэж байгаа нэрнүүд нь орхигдсоноос хойш урт хугацааны дараа нээн илрүүлсэн Азтекууд энэ газрыг аварга хүмүүс барьсан гэж төсөөлж байжээ.


Сарны пирамид



Some of the large stone statues, or moai, on Easter Island

Зүүн эргийн арал

Номхон далайн өмнө зүгт, Өмнөд Америкаас 3600км-т энэ арал оршдог. Далайн дундах энэ жижигхэн “цэгт” арлыг тойруулан барьсан, сөнөсөн галт уулын чулуужсан үнс нурмыг засч сийлсэн 887 аварга том чулуун хөшөө /moai/ байдаг. Хамгийн том moai нь 70 тохой өндөр, 150т жинтэй. Чулуурхаг газар нутаг, хадны зүүн талын хөшөөнүүдийг дутуу сийлснээс нь үзвэл энэ байгууламжийн ажлыг гэнэт орхисон мэт байдаг. Харамсалтай нь энэ бөглүү арлын түүхийг мэдэхэд туслах албан ёсны ямар ч бичмэл сурвалж байдаггүй. Гэхдээ энэ аварга том хөшөөнүүдийн төрх өнөө үед хүрч тэр үеийнхний оюун санааны итгэлцүүрийг илтгэсэн хэвээр байна.

Стоньхенг

Энэ нь Өмнөд Английн Амесбүр, Шилтшайрын цамхагаас баруун зүгт хоёр бээр, Салисбури Плейн ногоон аралд оршдог. Эртний аварга том чулуунуудаас бүтэх ба овоолсон цагираг, тахны хэлбэртэй. Stonehenge-ийн увдис эргэлзээгүй бөгөөд уран барилгыг нь дангаар нь тайлбарлахын аргагүй. 50 тонноос дээш жинтэй чулуунуудаар барьсан нь тухайн үеийнхээ инженерийн гайхалтайололттой холбоотой. Чулуун баганын гадна талын чимэглэлүүдийг холбоос гэж нэрлэдэг цагирган чулуунуудаар хийжээ. Тэд холбоос чулуунуудын хавтгай хэлбэрийг хадгалсан мөртлөө дугуй хэлбэрт оруулахыг яаж мэддэг байсныг тэдний тухайн үеийн уран барилгын хөгжлөөр нь тайлбарладаг. Үүнийг хэн барьсан, ямар зорилгоор барьсан нь тодорхой бус ч сүсэг бишрэлд зориулагдсан сүм, одон орон судлалын төв, оршуулгын газар, харь гаригийнхны ажил, харь гаригийнхны байрлаж байсан газар, чулуун эриний тооны машин, цаг ч байж болох юм гэсэн олон таамаглал байдаг.

Stonehenge in Southern England

Дэлхийн хүмүүсийн ихэнхи хувь нь оюун санааны дэвшлийн ач тусыг хүртээд байна. Алтан үед орох үйл явцыг бид үргэлжлүүлж байхдаа Их Багш ирээдүйг дүрслэн хэлж байсанчилан: "Хэрвээ дэлхийн бүх хүн оюун санааны бясалгал хийх юм бол манай дэлхий машид иргэншсэн, бусад гаригууд шиг өндөр түвшний гараг болно. Тэр үед бид юуг ч зохион бүтээж, бидний материаллаг бүх хэрэгцээ хангагдах болно. Учир нь оюун санаагаараа дэвшсэн учраас бид юуг ч хийж чадах юм. Тэдгээр гарагууд манай дэлхийгээс илүү өндөр хувиар билиг ухаанаа ашигладаг. Энэ л тэд болон бидний хоорондох цорын ганц ялгаа юм. Дэлхийн хамгийн ухаантай хүмүүс хүртэл оюун ухааныхаа багахан хувийг л ашигладаг. Та нар төсөөлж байна уу? Багахаан хувийг л. Тийм учраас л дэлхий харьцангуй дорой буурай байгаа юм" /Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай, Токио, 1992 оны 3-р сарын 1/ гэсэн айлдварт хүрэх боломжтой байна. Олон хүн энэ зуунд манай дэлхий маш хурдан хөгжинө, олон гайхамшигт явдлууд хэдхэн жилийн дотор болно гэж зөгнөсөн байдаг. Хэрвээ бид хайр болон билиг ухааны түлхүүртэй байх юм бол олон гайхалтай технологиуд дэлхийд нэвтрүүлэхэд бэлэн болчихоод байгаа.

Онч мэргэн үгс

Газар дэлхий дээр Диваажинг цогцлуул

Цаглашгүй Их Багш Чин Хайн айлдвар, Сингапур, 3 сарын 3, 1992, (Англи хэлээр) Видео хуурцаг №223

Орчин цагийн хүмүүс дэвшилт харилцаа холбооны ачаар харилцан мэдлэг оюунаа солилцож, ашиг тусыг нь хүртэж, газар дэлхийн ухамсрыг дээш татаж ойлголцлын өндөр түвшинд аваачин эх дэлхийгээ Диваажин болгон хувиргах боломжтой болсон билээ. Хэрвээ эх дэлхийгээ Диваажин болгочихвол өөр гараг ертөнц уруу шилжин суурьших ч юм уу, Нирваан ертөнцөд очих ямар ч шаардлагагүй болохсон.

КЕНИ

“Бидний дотор Бурхан байха хүндрэл бэрхшээлээс эмээх хэрэггүй.” – Амжилттайгаар худаг гаргалаа

Формосагийн мэдээний баг, утсаар үндэслэв (Хятад хэлээр)

Их Багшийн хязгааргүй их адислал, ажил гүйцэтгэгчдийн хичээл зүтгэлийн ачаар Их Багш Чин Хайн Олон Улсын Нийгэмлэг Кени улсад худаг гаргах төсөл мэдэгдэхүйц ажилтыг олжээ. Төлөсийн хүрээнд гаргасан худагуудын хоёр нь Баруун Кени дэх Кангуандо, Масай тосгоны хэдэн мянган ард иргэдэд амин чухал болсон усны хэрэгцээг нь хангаж байна. Ёс дүгээр сард барьж гүйцэтгэсэн гурав дахь худаг нь 6,000 гаруй нутын угуул иргэд болон шоронгын хоригдлуудыг усаар хангаж байна.

ХИЧЭЭЛ ЗҮТГЭЛ ҮР ӨГӨӨЖӨӨ ӨГЧЭЭ

Дөрөв дүгээр сард Их Багш үүрэг болгосны дагуу авшигтан номын ах эгч нар Кени улсыг зорисон бөгөөд усны гачигдалыг шийдвэрлэхэд тус дэм болох үүднээс нутгын худаг гаргадаг компаниудтай гэрээ байгуулжээ. (холбогдох мэдээллийг # 169. дугаараас лавлна уу). Нутгын иргэд ус авхад дөхөм байхыг бодолцон Кангуандо тосноны ойролцоох нэгэн цэгийг сонгосон боловч төсөл ажилт олоогүй байна. Ингээд хотоос цааш, хөндийд өөр нэгэн газрыг сонгожээ. Худаг гаргагч компаниууд өрсдийн туршлага дээр үндэслэн уг төслийг гүйцэтгэхэд багадаа хоёр сар шаардагдна гэж үзжээ. Гэвч Их Багшийн хайр адислал, уг төсөлийг удирдагч номын ах болон гэрээ байгуулсан компанийн ажилчидын хичээл зүтгэлийн үрээр 108 метрийн гүнээс урд тооцоолсоос богино хугацаанд ус олжээ. Бэлэн болсон худаг 3 дугаар алтан жилийн (2006) нэг дүгээр сарын 31 нд ашиглалтанд орж уулын тосгон Кангуандогийн ард иргэдийг ган гачигаас аварчээ. Худгыг барьж дууссан даруйд тосгоны иргэд баяр тэмлдэглэсэн ажээ. Тосгоны ахлагч, усны нөөц хамгаалах ажилтан болон бусад иргэдийн өмнө номын ах маань Кангуадо тосгоны

Төлөөлөгчид ус шахах өрөөний түлхүүрийг гардуулан өгчээ. Тэд бүгд худгын эргэн тойронд цугларч ардын дуу дуулан, хэмнэлд нь алгаа ташиж байв. Дуу дуулахын хажуугаар зогсолтгүй шахагдаж буй усны чимээ

тод сонсдож байлаа. Манго жимсний нэгэн модыг суулгаж усласан нь худгын усаар усласан анхны ургамал байв. Томчууд,хүүхдүүдгэлгүйбүгдхудгынтунгалагуснаасхутган гарнаасаа ууж байв. Уг тосгоны төлөөлөгч хүмүүсийнхээ өмнөөс чин сэтгэлийн талархалаа илэрхийлсэн юм. Тосгоны нэгэн эмэгтэй Багшид талархан сэтгэлийнхээ угаас дуулж байлаа. Баярлаж, талархасан хүмүүсээр дүүрэн баяр болж өнгөрсөн юм. Христийн шашинд сүсэгтэй тосгоны хэсэг иргэд ус шахах өрөөний эргэн тойрнод нүдээ анин сууж, залбирч байлаа. Үүний дараа төлөөлөгч түлхүүрээ гардан авсан юм. Энэ бол тосгоны 4,000 иргэд Багшаас ус хэмээх нандин бэлгийг хүлээн авч, усны гачигдлаас гарсан баярт үйл явдал байлаа.

Бурханы адисласан хайранд талархаж том жижиггүй нүдээ анин залбирал үйлдэв.

МАЗАЙЧУУДАД АМЛАСАН ИРЭЭДҮЙ

6-р сарын эхээр эхний худаг баригдаж дуусахаас өмнө авшигтан ах Мазайн Корромпой бага сургуультай танилцахаар явав. Энэ нь их өргөн уудам газрыг хамарсан өвс ургамалгүй, нүцгэн талд байх бөгөөд мөн эд материал усны нөөцөөр хомсдолтой газар юм.

Мазайчууд бол эртний уламжлалаа өнөө үед хадгалж үлдсэн Кенийн цөөн тооны хүмүүс юм. Ихэнх нь уламжлалт хувцсаа өмссөөр байгаа бөгөөд аглагч даяанчийн амьдралын хэв маягийг мөрддөг. Гайхалтай уян хатан байдал нь тэднийг онгон байгальтай ойр байлгадаг. Усны гачигдал нь цөөн тооны хүмүүсийн дунд үргэлж зөрчил тэмцэл үүсгэдэг гэж сургуулийн ажилтан эмэгтэй ярив. “Бид таныг цэвэр орчинд, цэвэр цонхтой угтаж авах ёстой ч бидэнд цэвэрлэгээний ус даанч алга даа. Энд тоос шороотой байгаад биднийг уучлаарай” гэж тэр хэлж байв. Төгс Гэгээрсэн Их Багшийн ОУН-ийн гишүүн тэнд очсоноор орон нутгийн 700 сурагч, Мазай тосгоны 2000 хүмүүс устай болно гэсэн итгэл найдвар тавьж байсан юм.

Худаг өрөмдөлт 6-р сарын эхээр сургууль амраагүй байхад эхлэв. Хүндрэл бэрхшээлийг үл харгалзан Бурханы хайр, адислалаар амжилттай хийж дуусган, 2 сарын дараа Корромфе сургуулийн хэдэн зуун сурагч “Бид маш их аз жаргалтай байна”, “Бид танд зүрх сэтгэлээ өгсөн” гэж дуулж талархлаа илэрхийлж байв. Үнэт усны эх ундарга бэлэглэсэн Их Багшийн нөхцөл болзолгүй хайранд талархсанаа илэрхийлэн тэд хамтдаа баяр жаргалтайгаар цуурайтуулан дуулж байлаа.

Багш, сурагчид, ажилчид тосгоны хүмүүс хамтдаа цугларцгаасан байлаа. ”Энэ мөчөөс эхлэн усны гачаалд санаа зовохооргүй боллоо” гэж уулга алдацгааж байв. Мазайн албаны төлөөлөгчид усны нөөцийг удаан хадгалахын тулд тусгай төлөвлөгөөнүүдийг төлөвлөж байгаагаа хэлэв .

Тэдүртариа, хүнсний ногоо болон бусад тариалангийн ургамлуудыг сургуулийнхаа

Local officials, villagers dressed in traditional clothes, the school faculty and hundreds of students join in the inaugural celebrations for the well.

ойр хавьд тариалан өөрсдийн хэрэгцээг бүрэн хангахаар төлөвлөжээ. Тэд орчноо сайхан болгохын тулд мод тарина гэж бодож байгаагаа бидэнд ярсан юм. Мазайчууд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн гишүүдийг дараа ирэхэд нь өтгөн ногоон орчинтой угтахыг чин сэтгэлээсээ хүсч байв. Түүнчлэн тэд "Бид танд зүрх сэтгэлээ өгсөн" гэж хүүхдүүд дуулсан тухай хийгээд Их Багшид маш их баярлан талархаж буйг дамжуулж өгөхийг авшигтан номын ахаас гуйсан юм.

ХАЙРЫН ХУДАГ

Эхний хоёр худагны гэрээ хийчхээд байх үед Накура шоронгийн хоригдлуудад бас усны хэрэгцээ зайлшгүй шаардлагатай байна гэсэн шинэ мэдээ ирэв. Энэ мэдээг сонсоод энэрэнгүй Багш маань тэдэнд гуравдах худгийг хурдан гаргаж өгөхөө амлав. Багшийн энэхүү хайр дүүрэн хариу Кенийн дэд ерөнхийлөгчийн анхаарлыг татсанаар орон нутгийн засаг захиргаа болон засгийн газар санхүүгийн тусламж үзүүлэхээр болов. Хамтын хайр ивээлээр бас нэгэн шинэ худаг 9-р сард хийгдэж дуусав. 5 сарын турш Кенийн ард иргэдийн усны хэрэгцээг хангахын төлөө номын ах худаг малталтын төслийн хүнд хүчир ажлыг зохицуулан ажиллаж байлаа. Тэр зүрх сэтгэлийнхээ гүнээс "Дотооддоо Бурхантай хамт байхад бэрхшээл зовлонгоос айх юм үгүй" гэж хэлж байлаа.

Энэрэл хайрын илэрхийлэл болгон Үндэсний хувцсаа өмссөн нутгийн ажилчин албан хаагчид, тосгоны хүмүүс, сургуулийн багш нар, хэдэн зуун сурагч худгийн нээлтийн баярт оролцсон юм.

Энэхүү мэдээний ТВ программыг "A Journey through Aesthetic Realms"
No. 208 and 214 дугаараас хүлээн авч үзнэ үү.
(Англи болон Хятад хадмал орчуулгатай),
at http://www.Godsdirectcontact.org.tw/tv, 24-цагийн online ТВ.

Баримтаас:
Эхний хоёр худагт нийт 46,165.00 ам доллар зарцуулсан байна.



Өсвөр насны хүүхдүүд тэнийг ийм худгаар шагнасанд нь талархан нүдээ анин залбирсан юм.

Тосгоны иргэд Их Багшийн хайранд талархаж буйгаа илэрхийлэн зурагт хуудас, лоозон барин зогсоцгоож байлаа.

Эзэн Бурхан мөнхийн хайраараа Кени улсыг адислав

Найроби дахь төвөөс эрхлэн гаргав (Хятад хэлээр)

Кени улсад олон арван байгууллага, хувь хүмүүс цэвэр усаар гачигдаж байдаг. Үүнийг арилгахаар Их Багш газрын гүний худаг гарган нутгийн иргэдийг цэвэр усаар хангах ажлыг Кени улсын номын ах, эгч нарт даалгасан юм. Эхний 2 худгийн ажлыг дуусгаад Найроби хотоос машинаар 2 цаг явж хүрч Накүрү хотын хорих газарт 3 дахь гүний худгийг өрөмдөж гаргав.

2006 оны 9 сарын 12-нд (Дэлхийн 3 дахь Алтан жил) болох шоронгийн гүний худгийн нээлтэнд Кени улсын дэд ерөнхийлөгч, дотоод хэргийн сайд, доктор, профессор Мүүди Авори хүрэлцэн ирэх байсан боловч нээлтийн ажиллагаа болох өдөр зайлшгүй ажлын шаардлагаар гадаад уруу албан ажлаар явж худгийн нээлтэнд оролцож чадаагүй юм. Ноён Мүүди Авори төлөөлөгч явуулах нь зохимжгүй гэж үзэж айлчлалаасаа буцаж ирүүт гүний худгийн албан ёсны нээлтэнд өөрийн биеэр байхыг хүссэн юм.

Ноён Огито Нжир дэд ерөнхийлөгч ирж чадаагүй талаар болон худгийг барихад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн хувь нэмрийн талаар сэтгүүлчдэд тайлбар өгч байна.

Дэд ерөнхийлөгчийн эзгүйд албан бус нээлт хийж, хүндэт зочид хүрэлцэн ирсний дотор Хорихын удирдах газрын эрүүл мэндийн программын гүйцэтгэх захирал, хатагтай Жемина Жичунжу, Хорих ангийн эрүүл мэндийн

Шахуургат байшингийн өмнө (зүүнээсээ баруун тийш) Хорихын удирдах газрын эрүүл мэндийн программын гүйцэтгэх захирал, хатагтай Жемина Жичунжу, Накүрү хотын хорих ангийн хяналтын албаны дэд дарга ноён Огито Нжир, Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн төлөөлөгч, Олон улсын цэвэр усны нөөцийн гүйцэтгэх менежер ноён Д.К.Жичэйн, Хорих ангийн эрүүл мэндийн программын дарга С.М.Ф.Кариоки, Шоронгийн

программын дарга, ноён С.М.Ф.Кариоки, Хорихын удирдах газрын дэд коммисар, Мужийн дэд дарга, ноён Жирэйл Мурими, Хорихын удирдах газрын дэд коммисор, Накүрү хотын хорих ангийн хяналтын албаны дэд дарга, ноён Огито Нжир, Олон улсын цэвэр усны нөөцийн гүйцэтгэх менежер, ноён Д.К.Жичэйн, Гүний худаг өрөмдөгчид, сургуулийн сурагчид, Кени улсын үндэсний нэр хүнд бүхий “Стандарт”, “Найшн” сонины сэтгүүлчид, Төгс Гэгээрсэн Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн гишүүд оролцсон юм.

Зочид шинэхэн баригдсан аврага том худаг дээр очиход Олон улсын цэвэр усны нөөцийн гүйцэтгэх менежер ноён Д.К.Жичэйн худгийн таглаат онгойлгомогц тув тунгалаг ус оргилон гарлаа. Сурагчдыг гарч ирэн оргилон гарах усаар гараа угаахыг урив. Усаар тоглож буй хүүхдүүдийн аз жаргал гэрэлтсэн царай, баяр

Эрүүл мэндийн программын дарга С.М.Ф.Кариоки нээлтийн үйл ажиллагаан дээр үг хэлж байна.

Олон улсын цэвэр усны нөөцийн гүйцэтгэх менежер ноён Д.К.Жичэйн худгийг барьж байгуулахад Чин Хай Багшийн хайр энэрэл, хувь нэмэрт талархсан сэтгэлээ илэрхийлж талархлын үг хэлж байна.

хөөрөөр бялхсан инээд нь тэнд ирсэн бүх л хүмүүсийн сэтгэлийг хөдөлгөж байлаа. Олон улсын цэвэр усны нөөцийн гүйцэтгэх менежер зочдод хандаж: " Цэвэр усаар гачигдаж байсан Накүрү тосгоны 6000 гаруй иргэд, хорихын хүмүүжигч нар Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн хайр ивээлээр өнөөдрөөс эхлэн цэвэр усаар бүрэн хангагдах болсонд Их Багшдаа гүнээ талархаж байна" гэж хэлэв.

Зочид хорих ангийн байр уруу очиход хоригдлуудын нэг нь цэвэр усгүй ямар хүнд нөхцөлд байгаа, цэвэр усны хэрэгцээ ямар чухал болохыг яриад Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд талархлаа илэрхийлсэн юм. Хэд хэдэн "Өөрөөр амьдарцгаая" зурагт хуудас, Үлгэр дэвтрийг бусад сонирхсон хоригдлуудаа дамжуулж өгөхийг хүссэн түүнд өгөв. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн гишүүн, Цэвэр усны нөөцийн ерөнхийлөгч хоригдлуудад хандаж: "Та нар хэдийгээр хүмүүжигдэж байгаа ч та нарыг бид мартаагүй, та нартаа маш их хайртай шүү" хэмээн товч болоод чин сэтгэлийн үг хэллээ. Үйл ажиллагааны дараа зочдод Накүрү хотын "Вотербак" зочид буудалд өдрийн зоог барих үеэр Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн бүх гишүүд цэвэр цагаан хоолтон болохыг олон зочид гайхаж, зарим нь эрүүл мэндээ бодон цагаан хоолтон болохыг хүсэж байв. Мөн Накүрү хотын хорих ангийн дарга бясалгал сурах чин хүсэлтэйгээ ч хэлэв.

Үйл ажиллагаа өндөрлөн Найробиг зорих замд Эзэн Бурхан хур бороо хайрлаж нутгийн хүн ардыг давхар адисласан.

Бурхан бүх хүмүүсийг адилхан хайрладаг, хоригдлуудын хүслийг ч мартаагүй хоригдлууд сануулга болгон хүлээж авлаа.

Кени улсын Корромпой хотоос цэвэр усны төсөл хэрэгжсэн явдалд талархалаа илэрхийлж захидал илгээв

Корромпой хотын ард иргэдийг төлөөлж бидний зүрх сэтгэлийг юу хэрхэн хөдөлгөж чадсан талаар энэхүү боломжийг ашиглаж бичих болсондоо бид маш их баяртай байна.

Цэвэр усны олон улсын төслүүд хэрэгжүүлж тэр дундаа Корромпой хотыг төсөлд хамруулсан явдалд Эзэн Бурхан тандаа талархаж байна.

Бидний мөрөөдлийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэг бодитой болгож өглөө. Цэвэр ус бол бидний мөрөөдөл байлаа. Гэвч хэрхэн цэвэр устай болох, хаанаас тэр их мөнгийг олох гэдэг бол хүнд асуудал байсан юм. Эзэн Бурханы ивээлээр бидний мөрөөдлийг биелүүлж өгсөн та нартаа баярласнаа илэрхийлье.

Багш, сурагч, эцэг эхчүүдийн дунд цэвэр усгүйгээс болж олон ч хүнд бэрх өдөр, сар, жилүүд өнгөрсөн. Багш бид үдийн цайны уух ус, мод услах усыг гэрээсээ авчрахыг сурагчдаас шаарддаг байлаа. Нөгөө талд эцэг эхчүүд хүүхдүүдийнхээ сургуулийн усны хэрэгцээ, гэр орныхоо өдөр дутмын цэвэр усны хэрэглээг хангаж чадахгүй хүндрэл учирч байлаа. Энэ нь сурагчдад хүнд дарамт болж байсан яриангүй.

Өрөмдөж гаргасан газрын гүний худаг нь манай сургуулийг болоод хотын амьдралыг цэцэглүүлэн тэлэх болно. Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийхэнд баярлалаа. Учир нь бидний тарьсан мод одоо усны гачигдалгүй болсон учраас удахгүй манай сургуулийн эргэн тойрон амьд байгалаар хүрээлэгдэн, хүмүүс аштай сайхан сэрүүцэн суух болно.

Манай сургуулийнхан болоод нутгийн иргэд одоо цангахын зовлон үзэхгүй боллоо. Мөн нутгийн иргэдийн тэжээвэр мал, амьтан ч холоос ирж энд цангаагаа тайлах болно. Худгийнхаа усыг ууж хэрэглэх болгондоо бид та нарыгаа санан дурсана.

Манай хотын хүн нэг бүрийн талархсан сэтгэлийг Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийхэн хүлээж авна уу.

Бидний төлөө хийсэн бүхнийг тань аугаа хүчит Эзэн Бурхан л та бүхнийг шагнаж чадахаас, мөхөс дорой бид баярлалаа гэхээс илүү сайхан үг олж хэлж чадахгүй байна. Та бүхний өгсөн тэр их хайрыг хэрхэн яаж хариулахаа бид мэдэхгүй нь. Гэвч та нарын хийсэн болгоны төлөө Эзэн Бурхан өөрийнхөө цаглашгүй хайраар хариу барина гэдэгт бид итгэлтэй байна.

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийхэнд цэвэр ус гаргах төсөлд санхүүгийн туслалцаа үзүүлж, цаг хүчээ гарган тусалсанд баярлалаа.

Эзэн Бурхан та бүхнийг хаа ч байсан үргэлж ивээх болтугай. Та нарын маань бидэнд зарцуулсан мөнгө, хайр, цаг, сайхан сэтгэл тань юутай ч зүйрлэшгүй билээ.


LETTER OF APPRECIATION

Thank You

Баярлалаа

Ау Лак

Далай мэт хязгааргүй хайр

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хай буяны байгууллагуудад хандив өргөв

Урлаг, уран сайхны багийн тайлан, Лос Анжелос, АНУ (Англи хэлээр)

Энэрэл нигүүслийн дээд Их Багш Чин Хай юу зааж сургаснаа өөрийн үйл хэргээр үргэлж харуулдаг.

> Бид энэ дэлхийд буян хураахын тулд юмуу ашиг сонирхлын төлөө сайн үйлс хийх ёсгүй. Зөвхөн хүүхдүүд, эхлэн бясалгагчид л хариу харж сайн зүйл хийдэг. Учир нь тэдэнд шагнал, буян, шийтгэл, магтаал, зэмлэл ч бас хэрэгтэй байдаг. Харин бид өндөр дэсэд хүрэхээрээ, арай илүү ухамсрын түвшинд очихоороо тэр болгоныг мартдаг. Бид бусдын сайн сайхны төлөө хариу харалгүйгээр зөвхөн ухамсраараа юу зөв байнав, түүнийг л хийдэг...
>
> Хэрвээ та үнэ цэнтэй хүн болъё гэвэл, түүнээс ч илүү бүр хүний ертөнцийг гэтэлчихсэн гэгээнтэн болж бүх л ертөнцөд ач тустай зүйл хийхийг хүсвэл 5 сахилаа ягштал сахин, зөвхөн сайн үйлс хий. Энэ нь л жинхэнэ хүн байх ганц зам юм. Энэ бол шудрага хүн байна гэсэн үг. Тэр бол зорилго, цорын ганц зорилго юм.
>
> ~ Их Багш Чин Хайн айлдвар
> Формосагийн Сихү Төв, 1995.06.06
> “Мэдээ” сэтгүүлийн № 47 “Их Багш ном тайлж байна” хэсгээс (Англи хэлээр)

Цаглашгүй Их Багш Чин Хай Ау Лак хотын ядууст туслахаар 65000 ам.долларыг ядуу буурай амьдралтай иргэдэд санаа тавьдаг зургаан ашгийн бус байгууллагад хандивласан юм. Эдгээр зургаан байгууллагад Вьетнамын Хараагүй хүүхдийн сан, “Хүүхдэд буцааж өгье” байгууллага, Вьетнам хүүхдийн төлөөх хүмүүнлэгийн үйлчилгээ, Вьетнам хүүхдийн тусламжийн программ, Вьетнамын Нэрвэгдэгсдэд үзүүлэх тусламжийн байгууллага орсон.

Вьетнам Хараагүй хүүхдийн сан нь хараагүй болоод хараа нь муудсан хүүхдийн эрүүл мэнд, сайн сайхны төлөө санхүүгийн болоод эд материалын туслалцаа үзүүлэхээр 2000 онд байгууллагдсан ба хоол хүнс, ном, сурах бичиг, тоног төхөөрөмжийг сайжруулах болон тэнд ажиллагсдыг санхүүжүүлдэг.

Сан Франциско хотын Айлчлал сүмийн санваартан, Вьетнамын Хараагүй

хүүхдийн сангийн ерөнхийлөгч Тюан Хоанг “Их Багш Чин Хайн хийсэн болгонд баярлалаа. Миний хайрыг Их Багшид уламжлаарай. Би хийсэн ажил болгонд нь түүний төлөө залбирах болно. Энэ ертөнцийн хүмүүсийн төлөө Таны ажилд туслаж байдаг бүх хүмүүст амжилт хүсье. Их Багш аа, Ау Лак хотын хараагүй хүүхдийн буяны санд 10000$ хандивласанд хязгааргүй их баярлалаа. Та эрүүл энх, аз жаргалтай, амар амгалан байх болтугай” хэмээн Их Багш Чин Хайд талархлаа илэрхийлжээ.

Вьетнамын Хараагүй хүүхдийн сангийн зөвлөх, хатагтай Дэста Вайт бас талархал илгээлээ. Тэрээр “Үйл ажилгааны маань цар хүрээ одоогоор бага байгаа хэдий ч хүрээгээ тэлж буй энэ санд Та анхаарч тусалсанд туйлаас талархаж байна. Таны хандивыг зааврын дагуу хүнд бэрх амьдралтай хүмүүст хэрэгтэй зүйлээр нь туслахад зарцуулах болно. Таныг бусдад үлгэр дууриал болж байгаад баярлалаа. Манай санд хандив өргөн бидэнд тусласанд дахин талархаж байна. Танд маш их баярлалаа” гэжээ.

Вьетнамын Хараагүй хүүхдийн сангийн зөвлөх, ноён Жосеф Мурфи хэлсэн үгэндээ: “Таны хийсэн сайн үйлст баярлалаа. Таны бүтээсэн гайхамшигт урлагийн бүтээл, хүмүүнлэгийн ажилд тань баяр хүргэе. Таны уран зураг, зохиосон хувцас, үнэт эдлэлийн загваруудыг би өнөөдөр анх удаа харлаа. Бясалгалыг дэлгэрүүлж байгаад тань гүнээ талархаж байна. Бясалгал бол хүний оюун санааны хөгжилд маш чухал үүрэгтэй гэж би боддог. Бид Таны цаашдын ажил хөдөлмөрийн тань төлөө залбирах болно. Таныг дэмжиж тусалсанд бид бүхэн туйлын баяртай байна” гэж тэмдэглэсэн байна.

“Хүүхдэд буцааж өгье” сан нь Ау Лак хотын ядуу зүдүү гэр бүлийг орон гэртэй

Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайд Вьетнамын Хараагүй Хүүхдийн Сангаас,“Хүүхдүүдэд Буцаан Өгье” Вьетнамын Хүүхдэд Зориулсан Хүмүүнлэгийн Үйлчилгээнээс, Хиймэл Эрхтэн Хийлгэхэд Туслах Сангаас болон Вьетнамын Тусламжийн Хөдөлгөөнөөс талархлын захидал тус тус илгээв.

болгоход туслахаар Роберт, Дороти Калацчан нарын санаачлагаар 2002 онд байгууллагдсан бөгөөд энэрэл халамж шаардлагатай хүмүүст эмнэлэгийн тоног төхөөрөмж, тухайлбал тахир дутуу хүний тэрэг, зүрхний мэс заслын багаж тусалж, бөглүү тосгонд хүүхдийн цэцэрлэг барьж, сургуулиас зайтай амьдардаг хүүхдийг унадаг дугуйгаар хангадаг. “Хүүхдэд буцааж өгье” сан Ау Лак хотын тэжээлийн доройтолтой хүүхдийг нэмэлт тэжээл, аминдэм, хүнсээр хангадаг.

Вьетнамын Хараагүй Хүүхдийн Сан – ВХХС
Баруун гараас: Эцэг Туан Хоанг / ВХХСангийн ерөнхийлөгч/, ноён Жозеф Мөрфи / ВХХСангийн зөвлөгч/, хатагтай Деста Вайт /ВХХСангийн зөвлөгч/ нараас манай Холбооны гишүүн ярилцлага авав.

Үерийн аюулд нэрвэгдсэн Солонгосын иргэдэд туслав

Солонгосын мэдээний баг (Солонгос хэлээр)

2006 оны 6-р сард тайфүүн хар салхи, аадраас болж урьд өмнө үзэгдээгүй үер бууж, олон тосгон, зам гүүр эвдрэн сүйдэж Солонгосын хойг асар их гарз хохирол амслаа. Солонгосын авшигтнууд гамшигт нэрвэгдэгсдэд туслахаар нэн даруй цугларав. Түр зуур ашиглах замыг засварлаж дуусмагц хэрэгтэй зүйлсээр хангаж, сэргээн засварлах ажилд гар бие оролцохоор авшигтнууд гамшигт нэрвэгдсэн тосгонууд уруу хөдөлцгөөв.

Инж-Гун, Гангвон-До

Гангвон–До бол зундаа Солонгосын өнцөг бүрээс олон зуун хүнийг өөртөө татдаг байгалийн үзэсгэлэнт газар юм. Үзэсгэлэнт сүрлэг уулс Гангвон–До нутгийг сэтгэл татам үзэсгэлэнтэй болгодог. 6-р сарын 16-ны ширүүн бороо нутгийн зарим хэсэгт ихээхэн хохирол учруулсан билээ. Аадар агшин зуур өндөр уулсаас аврага том усан бөмбөлөг болон бууж аврага мод, чулууг ч хуу хамж, хоромын төдийд тосгоны байшингуудыг эвдлэн эргэн тойрон нил ус, шавар шалбааг болон хувирсан юм.

Зам харгүй эвдэрсэн ч Аюулд нэрвэгдэгсдэд туслах баг тэргүүн зэргийн аврагчдыг аюулд өртсөн газар тийш нэн даруй илгээж байв. Орчноосоо тусгаарлагдсан тэдгээр тосгонд Засгийн газрын тусламж хүрч очиход хүндрэлтэй байсан нөхцөлд аврагчдын үүрэг маш чухал байлаа. Тэргүүн зэргийн аврагчдын мэдэгдсэнээр эвдрэл сүйдэл нь төсөөлж байснаас илүү их газрыг хамарч айж балмагдсан тосгоныхон хоргодох байр бараадацгааж байлаа. Сөүл хот дахь бясалгалын төвөөс гамшигт өртсөн газар тийш анхны тусламжийн зүйл бүхий 300 хайрцаг явуулжээ.

6-р сарын 20-нд Аврах баг Гарисан-Ли тосгонд очиход цахилгаан, утсан холбоо эвдэрчихсэн, холбоо барих

ямар ч боломжгүй, харин замын эвдрэл гайгүй, тосгоны хүмүүс айж сандарсан байдалтай байлаа. Аврах баг зарим эвдэрсэн байшинг сэргээн засварлаж, хохирогчдод анхны тусламжийн 100 хайрцаг, 25 ширхэг галт дохионы хэрэгсэл тараалаа. Хохирогчдоос юу хэрэгтэйг нь асуухад ихэнх нь гүн цочролд орчихсон, тайвшруулах эм л хүсч байсан.

Тусламжийн баг залгуулаад Деокжеок-Ли тосгонд очив. Тус тосгон хэдэн өдөр орчноосоо бүрэн тусгаарлагдсан байв. Аадар тосгоны гуравны хоёрыг нурааж 30 байшин усанд живсэн гэж Деокжеок-Ли тосгоны дарга, ноён Ким тайлбарлав. Тусламжийн баг эн түрүүн хүмүүсийг тайвшруулахаар тэдэнтэй уулзав. Тосгон тусгаарлагдсан байсан болохоор хоол хүнсийг Засгийн газрын нисдэг тэрэг агаараас буулгаж байсан боловч зарим хүн хүнсээ олоод авчих тэнхээгүй болсон байлаа. Тэд авшигтнуудын хайр, тайтгарал тэдний тайвшрахад тусалж, тэд хэрэгцээтэй зүйлсээ хэлж эхэллээ. Аврах баг тэдний хүссэнээр гэдэс, ходоодны эм, цахилгаан зай, зөөврийн хийн зуух, боолтыг нэн даруй бэлтгэж, бас будаа нийлүүлж туслав.

7-р сарын 21-нд байшин, тоног төхөөрөмж засварлах, сургуулийн эргэн тойрны шаврыг цэвэрлэх, нурсан тосгоны хэрэгцээгүй болсон зүйлийг цэвэрлэхээр дөрөв хуваагдав. 7-р сарын 22-нд зам цэвэрлэгдэж машин тосгонд нэвтрэх боломжтой болсноор 14000 сайн дурынхан гамшигт өртсөн газарт туслахаар ирцгээв. 100 ширхэг явуулын эмийн сан, будаа, ариутгах бодис сэлтийг түгээхээр нэмэлт баг Гарисан-Ли, Деокжеок-Ли тосгонд ирлээ. Деокжеок-Ли тосгоны оршин суугч ноён Гвон Ох-Сеок манай багийг халуун дотно угтан авлаа. Тэнд цахилгаан тасарсан байсан ч эхэлж очихдоо бидний өгсөн Их Багшийн Үлгэр дэвтэр, “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг тэрээр лааны гэрэлд уншиж байлаа. Түүнтэй ярилцаж байхад тэр уншсан төдийгүй бүгдийг цээжээр санаж байсан юм. Тэрээр: “энэхүү гамшиг бол Солонгосын сүүлчийн дайны бөмбөгдөлтөөс ч их газрыг хамарлаа. Энэ тосгон бол далай түвшнөөс 700 метр өндөрт оршдог. Анх удаа хүчтэй бороонд байшин урслаа. Их Багш Чин Хайн дэлхий дахинд үзүүлдэг туслалцаа бол асар их билээ. Их Багшийн заавраар танай нийгэмлэг олон хүнийг авран, материалаг зүйл болоод оюун санаагаар дамжуулан хайр энэрлийг нь түгээн дэлгэрүүлж байна. Солонгос оронд олон шашны урсгал бий. Гэсэн хэдий ч Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийн байнгын зогсолтгүй тусламж, дэмжлэгийн төлөө тосгоны бүх иргэд гүнээ талархаж байна. Бид өөрсдийн хүсэл тачаал, би үзлээсээ салах ёстой. Энэ гамшиг бол “Би”-гийн үзэл болон хүн байгальтайгаа буруу харьцсаны төлбөр юм. Би “Өөрөөр амьдарцгаая” зурагт хуудсыг уншсан, танай нийгэмлэг байгалийн эргүү зохицолдоог эрхэмлэж уриалж байгаа нь тун зүйтэй хэрэг. Дэлхий ертөнц та нараас аугаа том тусламж хүлээн авч байгаа нь энэ” гэж хэлсэн юм.

7-р сарын 23-ны ням гаригт 50 гаруй авшигтан аврах багт нэгдэж Деокжеок-Ли тосгонд байшин нь сэргээн засварлахаар явлаа. Эхний тусламжийн баг үерт автсан нэгэн настны байшинг яг л өөрийхөө байр шиг цэвэрлэж цэмцийлгэв. Мөн эвдэрсэн хүлэмжийг нь сэргээн засаж дахин ногоо тарьж болохоор болгож өгөв. Биднийг хараад настан ч удалгүй тайвшрав.



Өөр нэг баг ганц бие настай эмэгтэйн байшинд очлоо. Байшинг амар засахааргүй болжээ. Аз болж цэргийнхэн бидэнтэй нэгдсэн юм. Авшигтан нар цэргүүдтэй хамт байшингийн дотор гаднахыг цэвэрлэж эхлэв. Бидний өгсөн Үлгэр дэвтрийг нэг цэргийн дарга тэр дор нь уншиж байлаа.

Байшингуудыг сэргээн засварлаж дууссаны дараа багууд гараасаа хөтөлцөж баярлалдав. Богино хугацаанд олон арван чин сэтгэлт авшигтны дэмээр олон байшин буцаж хэвэндээ орсон юм.

Деокжеок-Ли тосгоны Эмэгтэйчүүдийн зөвлөлийн дарга, хатагтай Парк Деок-Бо олон байгууллага бидэнд тусаллаа. Гэвч тосгоны иргэд Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгийнхэнд талархлаа тусгайлан илэрхийлж байна. Би баярлаж талархсанаа олигтой илэрхийлчхэж нэг л чадахгүй байна. Хэрвээ бороо 10 хоног үргэлжлэн орсон бол бүх юм устаж үгүй болох байлаа. Бороог зогсоосон Эзэн Бурхан минь баярлалаа” гэж Төгс Гэгээрсэн Их Багш Чин Хайн Олон улсын нийгэмлэгт болоод Эзэн Бурханд чин сэтгэлээсээ талархаж байв. Деокжеок-Ли тосгоны дарга, ноён Ким Юун-Жеюн тосгон бүрэн сэргээн засварлагдсаны дараа буцаж ирэхийг уриад тосгоныхон бид та нарын сайхан сэтгэлийн хариуг барих болно гэв.

Жинжю хот

7-р сарын 13-нд аврах тусгай багийг гамшигт өртсөн газруудад илгээлээ. Жинжю хотын Мюнсан-Еюр нь үерт хамгийн их сүйрсэн газар гэсэн мэдээг тусгай баг болоод нутгийн авшигтнууд авсан байсан юм. Аврах ажил 7-р сарын 16 хүртэл тасралтгүй явагдсан.

Авшигтнуудыг очиход супермаркет дээвэрт тулсан их усаар дүүрсэн байлаа. Супермаркетын эзэн өөрөө гамшгаас болоод мэдрэлийн саатлад орчихсон сувилуулж байв. Авшигтнуудыг дэлгүүрийнхэн халуун дотно хүлээн авав. Бид дэлгүүрийн гадна талыг цэвэрлэх зуур гал сөнөөгчид усыг нь шавхаж бидэнд туслав. Дэлгүүрийн эзэн чин сэтгэлээсээ туслаж байгаа авшигтнуудыг хараад сэтгэл нь ихэд хөдөлж билээ. Тэрээр гамшигт өдрийг хүртэл бусадтай байгаагаа хуваалцах, хүмүүст туслах сайн үйлийг

ойлгодоггүй байснаа яриад цаашид бусдад туслах болно хэмээн амласан юм.

